*Тусгай дугаар...*

ЗӨВЛӨГӨӨ

ЭРҮҮЛ БАЙХ, ЭРҮҮЛ АМЬДРАХАД ОРОЙТДОГГҮЙ

76-р нүүрт

XVII ЖАРНЫ ГАЛ БИЧ ЖИЛИЙН ЦАГ УЛИРЛЫН БИЧИГ
/2016-2017 он/

ШИЙДЭЛ

**Төв аймгийн "ОЮУТОЛГОЙ" нь фермерийн аж ахуй**

53-р нүүрт

Улс төр, цаг үе,нийгэм мэдээллийн чөлөөт сэтгүүл

# ТОР АНАЛИЗ

Үнэний талд



УИХ-ын дэд дарга, Монгол Ардын Намын дарга Миеэгомбын ЭНХБОЛДТОЙ ярилцлаа.

## М.ЭНХБОЛД:

## ХЭТ МӨНГӨ ШҮТЭЖ, ХҮНЭЭ ХАЯСАН АЛДААГ ЗАСАХ ЁСТОЙ

2015 он

# *Мэндчилгээ*



*Улсынхаа Нийслэлийг энгэртээ тээж, тойрч суурьшсан Төв сайхан нутгийнхаа зон олны түмэн амгаланг айлтган мэндчилье. Та бүхэн минь өнөтэй сайхан өвөлжиж байна уу.*

*Миний бие уламжлал ёсоор нэг талаар сонгогч-Танд, нөгөө талаас нутгийн ахан дүүс-Та бүхэндээ УИХ-ын гишүүний 2015 оны ажлынхаа тайланг нэгтгэн, тоймлон хүргэж байна.*

*Зөвхөн сайхныг хүсч, сайныг хэлэлцдэг монгол уламжлалаараа үзэл улирч буй 2015 он урьдын адил монгол түмэнд минь, нутгийн ахан дүүс та бүхэнд минь ээлээ өгч, ивээлээ хайрласан сайхан жил боллоо. Улс орны амьдралд, ялангуяа эдийн засагт багагүй саад бэрхшээл байгаа ч, түүнийг даван туулахын төлөө Монголын ард түмэн байгаа боломжийнхоо хэмжээнд чадлаараа зүтгэн ажиллаж байна. Тэр дундаа МАН сөрөг хүчин гэхээсээ илүү Монгол Улсын нийтлэг эрх ашиг, нийт ард түмнийхээ төлөө холбирч, ганхаж гунхалгүй хоёргүй сэтгэлээр ажиллаж ирлээ.*

*Төрөлх нутаг Төв аймгийн маань хувьд багагүй бүтээн байгуулалт өрнөж, амжилт арвинтай байлаа. Халаалтын шинэ технологи бүхий инноваци, эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр фермерийн шинэ шийдэл зэргээ олж, эхнээс нь ажил хэрэг болгож аймгаараа хөгжил өөд зүтгэж, хөдөлмөрлөж байна. Нутаг орныхоо нэрийг улсад байтугай дэлхийд дуурсгасаналдартан ч олноор төрж аймгаараа, Монгол Улсаараа Төв аймгийнхнаар бахархсан сайхан жил байлаа.*

*Ирж буй 2016 он бол сонгуулийн жил. Монгол Улсын хөгжил, эдийн засаг, иргэн таны хувийн амьдрал ирэх дөрвөн жилд ямар байх нь таны сонголтоос хамаарах их хариуцлагын өмнө бид ирлээ. Улсын эдийн засаг өнөөдрийн адил уруудан доройтсоор явах уу, эсвэл эргэж сэргээхийн тулд илүү туршлагатай, чадвартайг нь сонгох уу гэдэг хариуцлагатай сонголтын жил байх болно.*

*Хуанлийн хугацаа 365 хоногоор эргэж, өнөөдрөөс илүү сайхныг авчрах нэгэн шинэ жил хаалга тогшлоо. Та бүхэндээ угтан ирж буй 2016 оны шинэ жилийн, удахгүй учран золгох гал бичин жилийн Сар шинийн мэндийг хамтатган хүргэе. Бидний бахархалт хүн-Гүн галуутайн их найрагчийнхаа хэлж захиснаар эрүүл байж, эрүүл явж улсын наадмыг олон, олон жил хамтдаа үзэхийг та бүхэндээ хүсэн ерөөе.*

*Азай буурлууд, элэг нэгт ах эгч, эрхэм дүү та бүхний минь бие эрүүл, амьдрал нь аз жаргал, инээд баяслаар бялхаж, эрхэлсэн ажил нь амжилтаар дүүрэн явахыг чин сэтгэлээсээ хүсье.*

**Монгол Улсын Их Хурлын дэд дарга, Монгол Ардын Намын дарга**

**Боржигон овогт Миеэгомбын ЭНХБОЛД**

Улс төр, цаг үе,нийгэм мэдээллийн чөлөөт сэтгүүл
ТӨР АНАЛИЗ
Үнэний талд

# М.ЭНХБОЛД:

# ХЭТ МӨНГӨ ШҮТЭЖ, ХҮНЭЭ ХАЯСАН АЛДААГ ЗАСАХ ЁСТОЙ

УИХ-ын дэд дарга, МАН-ын дарга М.Энхболдтой ярилцлаа.







# УИХ ДАНГААРАА ШИЙДЭХЭД ҮНДСЭН ХУУЛЬ АХАДНА

**-Ярилцлагаа Үндсэн хуулийн өөрчлөлтөөс эхэлье. МАН Үндсэн хуулийн өөрчлөлтийг дэмжихгүй гэлээ. Таны хувийн байр суурийг сонирхъё. Таныг Ерөнхий сайд байх үед одоогийн Үндсэн хуулийн хүрээнд ажил хийж болж байсан уу?**

-Жижигхэн залруулга хэлье. МАН Үндсэн хуулийн өөрчлөлтийг дэмжихгүй гэж ерөөсөө хэлээгүй. Харин цаг хугацааны хувьд боломжгүй гэж үзэж байгаа.

**-Яагаад...?**

-УИХ хууль батлах, Үндсэн хуульд өөрчлөлт оруулах эрхтэй нь үнэн. Гэхдээ нийгмийн хамгийн том гэрээ-Үндсэн хуулийг өөрчлөх эсэх, ямар өөрчлөлт оруулахыг дангаараа, ганцаараа шийдэхэд УИХ жижигдэнэ. Асуудал нь ахадна. Төлөөллийн ардчиллын зарчим талаасаа парламентыг бага “ард түмэн” гэдэг. Харин Үндсэн хуулийг өөрчлөх эсэхээ их ард түмэн нь мэдэж, тэднээсээ асууж, зөвшөөрсөн өөрчлөлтүүдийг “бага ард түмэн” нь хуульчлах нь зөв. Үндсэн хуулийг өөрчилдөг журмын тухай хууль гэж бий. Тэр дараалаар л явна. Ерөнхий санаануудаа гаргаад, олон нийт, эрдэмтэн мэргэдээр хэлэлцүүлж, ард нийтээсээ асууна. Үүнд цаг хугацаа хэрэгтэй. Одоо 30 хүрэхгүй хоногийн дараа он гарлаа. Он гарлаа л бол сонгуулийн жил эхэлнэ. Сонгууль болохоос зургаан сарын өмнө Үндсэн хуульд өөрчлөлт оруулж болдоггүй. Гэтэл яагаад заавал энэ 30 хүрэхгүй хоногт багтааж, яаруу сандруу, босож суухын завсарт Үндсэн хуулиа өөрчлөх гэж зүтгээд байгаагийн учрыг сайн ойлгохгүй л байгаа. Өнөөдөр төр, засгийн төвшинд эмх замбараагүй байдал бий болж, эдийн засагт хямрал, уналт нүүрлэлээ. Иргэдийн амьдрал илт доройтлоо. Энэ бүгдийн буруут Үндсэн хууль руу чихэж, өөрчилчихлөө, одоо л  сайхан болно гэх гэж байгаа бол буруу. Энэ бол улс төрийн заль. Үндсэн хууль Монгол Улсын нийгмийн суурь харилцааг, тэр дундаа сонгуулийг хэрхэн явуулахыг зохицуулах ёстой болохоос, Үндсэн хуулийг сонгуулийн улс төр болгох ёсгүй. МАН тийм явуургүй арганд ордог, ийм явган улстөр хийдэг нам биш.

*Гадаад өрийг нь ДНБ-тэй нь харьцуулж 108 орныг эрэмбэлэхэд Монгол Улс эхнээсээ хоёрдугаарт, Грекийн өмнө орж байна*

**-Ерөнхий сайд байхдаа одоогийн Үндсэн хуулийн орчинд  ажил хийж болдог байсан, үгүй тухайд...?**

-Ажил хийж болдог байлгүй яах вэ. Намайг Ерөнхий сайдаар ажиллаж байхад улс орны эдийн засагт өсөлт бий болж байснаас биш, унаж байгаагүй. Ард түмний ажил амьдралд нааштай ахиц, өөрчлөлтүүд гарч байсан. Төрийн албан хаагчдын цалинг 92 мянгаас 300 гаруй мянган төгрөгт хүргэж болж л байсан. Тэтгэврийг 30 мянгаас 80-аад мянгад хүргэж л байсан. Жилд 400-500 км орчим зам тавьж, 4600 гаруй км урт цахилгаан дамжуулах шугам татаж, 76 сумыг эрчим хүчний байнгын эх үүсвэртэй болгож байв. Үндэсний эв нэгдлийн Засгийн газрын үед аягатай хоол минь дүүрлээ




дээ гэж хүмүүс ярьдаг байсан юм шүү. Ганц миний гэлтгүй, миний өмнөх, надаас хойшхи олон Ерөнхий сайд, Засгийн газар энэ Үндсэн хуулийн орчинд ажиллаж болж л байсан. Ажиллаад бүтээсэн, босгосон нь хавьгүй их гэдэгтэй хэн ч маргахгүй.

**-Тэгэхдээ “Үндсэн хуулийн иим иим заалтыг өөрчлөхгүй бол болохгүй юм байна, ажилд саадтай байна” гэсэн бодол Ерөнхий сайд байх үед танд төрж байгаагүй юу?**

-Ерөнхий сайдын эрх мэдэл, танхимын тогтвортой ажиллах орчны талаар Үндсэн хуульд өөрчлөлт оруулах ёстой юм байна гэж бодогдож байсан зүйл бол бий. Тэгэхээр Үндсэн хуульд өөрчлөлт оруулах ёстой юу гэвэл, би тийм гэнэ. Хотын статусыг бий болгох, Ерөнхий сайдын эрх мэдлийг өргөтгөх, кабинетын зарчмыг чанд баримтлах, хяналтын эрхийг нь сулруулахгүйгээр парламентыг Засгийн газраас тусгаарлах гэх мэт асуудлууд байж болно. Харин одоогийн нөхдийн яриад байгаа шиг бүр яахаа алдчихсан, цаашаа явах ямар ч гарцгүй болчихсон зүйл Үндсэн хуульд огт байхгүй. Үндсэн хууль 70 зүйлтэй. Үүнээс 26 зүйл, 50 гаруй заалтад зарчмын өөрчлөлтүүд оруулах төсөл оруулж ирсэн байгаа. Тэгэхээр “Эх хууль” гэж нэрийн дор бараг шинэ Үндсэн хууль батлах гээд байгааг анхаарах учиртай. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн хязгаарлалтыг зөрчсөн зүйл ч цөөнгүй байна. Өнөөдрийн Үндсэн хууль өнгөрсөн 25 жилийн туршид Монголд ардчиллыг бүтээсэн, бэхжүүлсэн, цаашид ч хүчин төгөлдөр үйлчлэх түүхэн баримт бичиг. Гэтэл 25 жилийн туршид ард түмнээс сонгогдсон Ерөнхийлөгчийн эрх мэдэл рүү халдаж, ажиллаж болоод ирсэн 14,15 Засгийн газрыг хэт үгүйсгэж, нэг амиар дайрах замаар Үндсэн хуулийг өөрчлөхийг би хувьдаа дэмжихгүй.

**-МАН ирэх дөрвөн жилд олонх, эсвэл олон суудалтай болж магадгүй юм. Тэглээ гэхэд одоогийн Үндсэн хуулийн хүрээнд ажиллахад бид харамсахгүй гэж намын даргын хувьд баталгаа өгч чадах уу, та?**

-Баталгааг бол өгч чадахгүй. Би түрүүн хэлсэн дээ. Үндсэн хуулийг өөрчлөх үгүйг, өөрчиллөө гэхэд юуг яаж өөрчлөхийг их ард түмэн мэднэ гэж. Тэдний өмнөөс МАН баталгаа өгөхгүй. МАН ард түмний нам учраас ард түмэн юу гэж үзнэ, шийднэ, түүнийг л биелүүлнэ. Монголын төр тогтвортой байж гэмээнэ тодорхойлсон бодлого нь хэрэгжиж ажил хэрэг болно. Ажил хэрэг болж, бүтээж байж хөгжил бий болно. Тийм орчныг бий болгох, одоо байгааг нь баталгаажуулахын тулд Үндсэн хуульд өөрчлөлт оруулах шаардлага бол бий. Ер нь Үндсэн хуулийн өөрчлөлтийг сонгуулийн өмнө яарч сандарч биш, УИХ-ын нэр хүнд өнөөдрийнх шиг уначихаагүй, арай гайгүй үедээ л хийх ёстой.

**-УИХ-ын нэр хүнд гайгүй үед гэхээр сонгуулийн дараахан гэсэн үг үү?**

*Нам бол хэн нэгэн улстөрчийн фэн клуб биш. Нам бол үзэл бодлын нэгдэл*




-Тийм. Зарим улс оронд Үндсэн хуулийн өөрчлөлтийг хоёр парламентаар дамжуулж хэлэлцэж байж өөрчилдөг жишээ байна. Нэг парламент дангаараа хийдэггүй. Эхний парламент санал асууж, өөрчлөлтүүдээ бэлдээд, дараагийн парламент нь гардаж хийдэг зохицуулалт бас байна.

## НЭГ МОНГОЛ ХҮНД 5.9 САЯ ТӨГРӨГИЙН ӨР НООГДОЖ БАЙНА

**-Саяхан танай намаас зохион байгуулсан “Бид хамтдаа” үндэсний форум ч Үндсэн хуулийн өөрчлөлттэй шууд бусаар холбоотой. Та бүхнийг гарц хайж ийм форум хийлээ гэж ойлгосон. Шийдлээ олсон уу?**

-“Бид хамтдаа” форум бол гэнэт зохион байгуулсан, ганцхан долоо хоног хийгээд зогсох арга хэмжээ биш л дээ. Зургаан сарын өмнө эхэлсэн ажил. Бид Сүхбаатарын талбайд цагаан тагтаа нисгэж энэ аянаа эхэлсэн. Монголын бүх өрхөд захидал хүргүүлсэн. Манай намынхан өнгөрсөн хавар, зун, намрын турш орон нутагт ажилласан, иргэдийн санаа бодлыг сонссон. Саяхан тодорхой нэг шатыг дүгнэж үндэсний форум зохион байгууллаа. Форумд Ардчилсан намаас бусад бүх нам, нийт салбарынхан маш идэвхтэй оролцсон. Монголын эдийн засаг ямар байна вэ гэдэгт үнэлэлт, дүгнэлт өгсөн. Жишээлбэл, Монгол Улсын сайд, эдийн засагч М.Энхсайхан “Монгол Улс хэвтрийн эдийн засагтай боллоо” гэсэн. Би 2013 онд МАН-ын даргаар дахин сонгогдсоныхоо дараахан бүх намын дарга нарыг Үндэсний зөвшилцлийн уулзалтад урьсан. Хамгийн сүүлд, өнгөрсөн есдүгээр сарын 3-нд Үндэсний зөвшилцлийн 12



дахь удаагийн уулзалтаа хийлээ. Улс төрийн 22 намын дарга ирж, оролцсон. Тэнд, Сонгуулийн хууль, Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбоотой асуудлуудаар санал бодлоо солилцсон. Монголд эрдэм шинжилгээ, судалгаа, нэн ялангуяа эдийн засаг, нийгмийн чиглэлээр ажилладаг судалгааны байгууллагуудыг бүгдийг урьж, саналыг нь сонслоо.

**-Тодорхой асууя. Та форумыг хааж улстөрийн дүгнэлт бүхий илтгэл тавьсан. Тэнд дурдсан зүйлүүд танай намын 2016 оны сонгуулийн мөрийн хөтөлбөр гэж ойлгож болох уу?**

-Бүх нам л сонгуульд мөрийн хөтөлбөртэй орно. Улс орны эдийн засаг ингэж хүндэрчихсэн үед юунаас эхэлж, юуг засах ёстойг мөрийн хөтөлбөрт тусгахаас өөр аргагүй. Монгол Улсын түүхэнд төсвийн орлого нэг их наяд төгрөгөөр тасарч байгаагүй юм шүү дээ. Ирэх оны төсөвт зөвхөн өрийн үйлчилгээний төлбөрт гэхэд жилд 960 гаруй тэрбум төгрөг төсөвлөлөө. Дөрвөн жилийн өмнө 30 гаруй тэрбум байсан бол одоо 960 тэрбум гаруй төгрөг боллоо. Бараг 30 дахин өслөө. Монгол Улсын нийт гадаад өр энэ оны эхний хагас жилийн дүнгээр 21.7 тэрбум ам.доллар байна. 43 орчим их наяд төгрөг. Зөвхөн Засгийн газрын гадаад, дотоод өрийн нийлбэрээр үзвэл өнөөдөр нэг монгол хүнд 5.9 сая төгрөгийн өр ногдож байна. 2016 онд нэг хүнд 6.3 сая төгрөгийн өр ногдохоор байна. Би хотын дарга Э.Бат-Үүлийн "манай улс ирэх хавар гэхэд Грек шиг хямарна" гэж ярьсныг уншсан. Эрх барьж байгаа намын том зүтгэлтэн, тэгээд хотын дарга хүн санаандгүй, судалгаагүй ийм эшлэл хэлэхгүй нь тодорхой. Статистик харьцуулж харвал Грекийн хямрал улсын гадаад өр нь ДНБ-ийхээ 165 хувьд хүрснээр эхэлсэн юм билээ. Манай улсынх одоо ДНБ-ийхээ 180 хувийг даваад явж байгаа. Бодвол хотын дарга Э.Бат-Үүл энэ статистикийн харьцаан дээрээс тэгж хэлсэн байх. "Rensaissance capital" гэж олон улсын эдийн засгийн байгууллагын саяхны нэг судалгаа байна. Гадаад өрийг нь ДНБ-тэй нь харьцуулж 108 орныг эрэмбэлэхэд Монгол Улс эхнээсээ хоёрдугаарт, Грекийн өмнө, Исландын дараа орж байна гэж тэр судалгаанд

бичсэн байна. Саяхан, хэдхэн өдрийн өмнө "Fitch" зэрэг дэлхийн санхүүгийн агентлагууд манай улсын зээлжих зэрэглэлийг дахиад бууруулллаа. Хамгийн гол нь энэ их өртэйгөө тэнцэх хэмжээний бүтээн байгуулалт хийж чадсан бил үү, чадаагүй. Айл өрхийн амьдрал сайжирсан уу, сайжраагүй. Тэгэхээр улс орныхоо эдийн засгийг өөд татахын хажуугаар энэ их өрийг яаж дарах, эдийн засагт үзүүлэх ачааллыг яаж зөөлрүүлэх талаар намууд бодлогоо гаргана. Тэр нь сонгуулийн мөрийн хөтөлбөрт сууж таарна. МАН-ын хувьд гол санаанууд ерөнхийдөө ойлгомжтой болсон. Хүний хөгжил рүүгээ түлхүү хандах цаг болжээ гэж МАН үзэж байгаа. Жишээ нь, эрх баригч намын дарга бол хүний хөгжлийн асуудлыг гарыг нь ганзаганд, хөлийг нь дөрөөнд хүргэж өглөө, одоо яах нь хамаагүй, төр зөвхөн зохицуулалтын үүргээ гүйцэтгэх ёстой гэж байна. МАН-ын бодлого бол өөр. Хэрвээ улс орон гэж байгаа бол төр байдаг. Төр гэж байдаг бол улсынхаа ард түмний төлөө л байх ёстой. Төр "би зохицуулалт л хийдэг" гээд суугаад байж болохгүй. Ард түмний амьдралыг ахиулах, дээшлүүлэх ямар арга зам байна вэ, тэрхүү орчныг бүрдүүлэх ажлыг төр хийнэ. Төрийн зохицуулалт дор иргэд ажиллаж амьдрах ёстой гэж АН үзэж байна. Харин МАН бол ард түмний таатай амьдралд зориулж төр зохицуулалтаа хийнэ гэж үздэг. Энэ бол бидний, МАН болон АН-ын бодлогын ялгааны нэг л дээ.

**-Уг нь бол бүгдээрээ, аль ч нам эдийн засгаа өсгөх гэж зүтгэдэг, тийм үү?**

-Эдийн засгийг өсгөх нэг хэрэг. Харин бий болгосон эдийн засгийн өсөлтөө удаан хадгалах, үргэлжлүүлэх хуулийн болон улс төрийн тогтвортой орчин хамгийн чухал. Монгол Улс өнөөдөр гадаадын хөрөнгө оруулалтгүй, эдийн засаг уналттай байгаа нь зөвхөн дэлхийн зах зээл дээрх үнийн уналтаас болоогүй. Монголчууд бид ярьдаг даа. Зан сайтай айлд зочин олон, замаг ихтэй нууранд загас олон гэж. Гэтэл гурван жилийн өмнө ямар байлаа, хэвлэлийнхэн та нар мэднэ дээ.

**-Ямар байсан гэж...?**

-Тэр үед ямар байсныг биш, одоо ямар болоод байгааг ярих хэрэгтэй. Айлаар бол нэг л уруу дорой, бизнес наймаа ярих гэж тоож орж гардаг нь цөөрч, тойрч гардаг нь олон боллоо. Гэтэл гадаадын хөрөнгө оруулагчдын цуглах "замаг" нь бол байгаад байдаг. Харин бид өөрсдөө "зан сайтай айл" буюу тогтвортой Засгийн газартай, төрийн залгамжилсан тогтвортой байтугай тодорхой бодлоготой ч байж чадсангүй. "Зан сайтай айл ийм байдаг юм" гээд гурван жилийн өмнө бид хамаг байдгаа гадныхны өмнө дэлгэж, өргөн барьж байсангүй. Байгаа хуулийн орчинд, тогтвортой хамтарч ажиллаж байсан. Түүний хүчинд 4.6 тэрбум долларт хүрч байсан гадаадын шууд хөрөнгө оруулалт өнөөдөр Монголбанкны энэ оны гуравдугаар улирлын мэдээгээр 10 сая доллар болж буурсан байна. 460 дахин буурсан гэсэн үг. Тэр үед 1390 төгрөгтэй тэнцэж байсан нэг ам.доллар өнөөдөр бараг 2000 хүрч байна. Ирэх онд хэд болохыг мэдэхгүй. Сая төсөв, мөнгөний бодлогын хэлэлцүүлгийн үеэр Монголбанкныхан нэг ам.долларыг ирэх онд 2030 төгрөгтэй тэнцэхээр оруулж ирсэн. Төгрөгийн ханш 45 хувиар уналаа. Төгрөгийн ханш унаснаас болж иргэдийн худалдан авах чадвар гурван жилийн өмнөхөөс 60 хувиар унасан. Ингээд тоочвол их олон харьцуулалт хэлж болно. Ямарч гэсэн бид засгийн эрх барьж байх үедээ эдийн засгийн өсөлтийг айл болгоны хаалгаар оруулж, цалин, тэтгэврээ нэмж, иргэн бүрийнхээ халаасанд сар болгон 21 мянган төгрөг хийдэг байсан. Харин өнөөдөр өр тавьж авсан бондын гэх тэр их мөнгө иргэн бүрт хүрч, хийж байгаа гэх бүтээн байгуулалт нь нүдэнд харагдаж, гарт баригдахгүй л байгаа.

## ХҮНЭЭ ОРХИЖ, ХЭТ МӨНГӨ ШҮТСЭН 25 ЖИЛИЙН АЛДААГАА ОДОО ЗАСЪЯ

**-Форумыг дүгнэж таны хэлсэн үгнээс задалж асууя. Та "Нийгмийн гэрээний шинэ хувилбарыг яаралтай хэрэгжүүлэх цаг болжээ" гэсэн. Нийгмийн гэрээ гэдэг нь Үндсэн хууль мөн үү, хэрвээ мөн бол танай нам өөрчлөлтийг дэмжиж байгаа л юм биш үү?**

-Үндсэн хуулийн өөрчлөлт энэ Засгийн газрын үед явах боломжгүй ээ. Үндсэн хуулийн өөрчлөлт бол тохиролцоо наймааны завсарт ханцуйн дотор явдаг зүйл ч биш. Тэр битгий хэл, Үндсэн хуулийг өөрчлөх төсөл боловсруулах ажлын хэсгийн есөн гишүүнээс хоёр нь гарын үсэг огт зураагүй, одоо хоёр нь гарын үсгээ татаж авахад бэлэн байгаа. Харин форум дээр миний хэлсэн "Нийгмийн шинэ гэрээ" гэдэг нь Үндсэн хууль бол яг биш.

Нийгэм, олон түмэн төртэйгөө, төр нь иргэдтэйгээ тодорхой хэмжээний шинэ нөхцөл, шинэ шатанд ойлголцож байж энэ улс орныг авч явах ёстой болжээ гэсэн санаа. Хүний хөгжилд анхаарах цаг болж. Бид сүүлийн жилүүдэд эдийн засаг гээд хэтэрхий их мөнгө шүтэж ирж. Одоо хүнийхээ ухаан бодол, оюун санаанд шинэ ойлголт өгөх цаг болсон байна. Хүүхдийн зөв хүмүүжил, зөв үнэт зүйлд анхаарахгүй бол болохоо байчихсан байна. Нөгөө талаас, одоо улам бүр холдоод байгаа нийгмийн тэгш бус байдал, баян ядуугийн зөрүүг ойртуулах, энэ чиглэлийн бодлогыг үндэсний хөтөлбөрийн хэмжээнд шинэ төвшинд гаргаж хэрэгжүүлэх хэрэгтэй гэсэн санаа юм.

**-Нийгмийн шинэ гэрээ гэдгийг төр, иргэдийн хооронд шинэ харилцаа бий болгох гэж ойлгож болох уу?**

-Ер нь тэгж ойлгох ёстой.

**-Та сүүлийн үед нийгмийн дундаж давхаргыг дэмжинэ гэж их хэлж байгаа. Нийгмийн дундаж давхарга гэж яг хэнийг хэлж байна вэ. Энэ ангилалд ямар хүнийг хамруулах юм, хэдэн төгрөгийн цалинтай, ямар өмчтэй өрхийг хэлэх вэ?**

-МАН дундаж давхаргыг, боловсролтой хэсгийг нэмэгдүүлэхийн төлөө байдаг үзэл баримтлалтай нам. Цөөн тооны хөрөнгөтөн, олигархиудыг бий болгоё, тэд нь улс орныг авч явъя гэдэг бол буруу бодлого гэж МАН үздэг. Нийгэмд ажил хөдөлмөр эрхэлдэг дундаж орлоготой, амьдрал ахуйгаа аваад явах өрх гэр бүл л дийлэнх олонх нь болох ёстой. Ингэж чадвал төрийн нуруун дээрх ачаа хөнгөрнө. Улс орон хөгжинө. Үүний тулд төр өөрөө тодорхой ажлуудыг хийх ёстой. Хамгийн түрүүнд ажлын байрыг олноор бий болгох ёстой. Дундаж давхаргынхан гэж сарын төдөн төгрөгийн цалинтай өрхийг хэлнэ гэж яг тодорхойлж тоо хэлэх боломжгүй л дээ. Ерөнхийдөө тухайн нийгмийнхээ жишгээр, эдийн засгийн орчиндоо тааруулаад цалингаараа, өрхийн орлогоороо санаа зовохгүй сайхан амьдрах боломжтой өрхүүдийг л дундаж гэж үзнэ. Ийм өрхүүд олон болох ёстой. Дундаж орлоготой айл бол орон сууцанд амьдарчихдаг, хүүхдүүд нь бүгд сургуульд явдаг, хүүхдийнхээ сургалтын төлбөрийг өгчихдөг, өдөр тутмын амьдралын хэрэгцээгээ хангачихдаг санхүүгийн бололцоотой байх ёстой. Бага зэргийн зээлтэй байж болно, жишээ нь орон сууцны зээлтэй ч юмуу. Тэрийгээ төлөх мөнгөний эх үүсвэр нь найдвартай, 5-10 жилийн дараа зээлээ бүрэн төлөөд дуусчих баталгаатай ажлын байртай айл өрхийг нэмэгдүүлэх ёстой.

**-Бас “1-3 настай хүүхэдтэй эхчүүдэд тэтгэмж олгох ёстой” гэсэн байна. Энэ нь хүүхдээ харсны тэтгэмж, хүүхдийн мөнгийг хэлээд байна уу, үүнээс өөр хөтөлбөрийг хэлээд байна уу?**

-Одоо бол хүүхдийг нэг нас хүртэл харахад тэтгэмж, 12-36 сар хүртэл нь харахад цалингүй чөлөө олгож болж байгаа. Эргээд л хүний хөгжил рүү орох гээд байна. Монгол Улсын ирээдүйн иргэнийг төрсөн цагаас нь бэлтгэх хэрэгтэй. Японд бага ангийн багш нарыг “зөвхөн хичээл заадаг бус, ирээдүйн япон иргэнийг бэлтгэдэг” гэж үздэг. Нэрт сурган хүмүүжүүлэгч Сухомлинский “Хүнийг дахин сургаж, хүмүүжүүлнэ гэж байдаггүй юм” гэсэн үг ч байдаг. Хүний хүмүүжил, боловсрол хүүхэд байхад л эхэлнэ. Монгол хүнийг бүр багаас нь, ой ухамсар сууж байх үеэс нь анхаарч байж бид монгол хүнээ дэлхийн иргэн болгож чадна. Тэгэхээр аав, ээжүүд бол хүүхдээ өсгөхөөс гадна, ирээдүйн монгол иргэнийг бэлтгэж байгаа юм. Энэ их хөдөлмөрийг нь үнэлэх, орчныг нь бий болгохын төлөө төр одоо анхаарах цаг болсон. Сүүлийн 20 гаруй жилд бид хэт их эдийн засаг, улс төр ярьсаар байгаад хүнээ орхижээ. Өнөөдөр боловсрол, эх орноо гэсэн сэтгэл, хүмүүжлийн хувьд учир дутагдалтай үе гарч ирж байна. Энэ үеийг өөрчлөх, хүмүүжүүлэх нь бидний үүрэг. Дунд сургуулийн сургалтад ч хүн болгож хүмүүжүүлэх хөтөлбөрүүд байх ёстой гэж би үздэг.

**-Өндөр настны тэтгэмжээс гадна өндөр насалсны тэтгэмж гэж өгье гэсэн санаа бас байсан. Энэ нь тэтгэврээс өөр үү?**

-Одоо манайхан 55-60 нас хүрээд тэтгэвэрт гарч байгаа. Монголын үе үеийн төр ахмадуудаа яаж тэтгэдэг байсныг судлаад үзэхэд асар ихээр харж, хандаж байсан байгаа юм. Чингис хааны үед их хааны шийдвэрээр 70-аас дээш настай ахмадуудад шан, харамж олгодог байж. Богд хаант Монгол Улсын үед буюу 1911 онд VIII Богд Жавзандамба хутагтын зарлиг ч байна. 70 нас хүрсэн өндөр настанд тусгай урамшуулал, төдөн лан мөнгө олго гэсэн байгаа юм. 90 нас хүрсэн бол илүү өндөр шан, харамж өгдөг байсан байгаа юм. Төрийн энэ уламжлалыг хадгалж 70 насалсан азай буурлуудаа төр анхаарч, хандахад буруу юм байхгүй. Халамж хавтгайруулсан улс орон боллоо гээд л өнөөдөр шүүмжилдэг. Гэхдээ улс орон, төр гэж байгаа бол улс орныг авч явсан ахмад үеэ халамжлах үүрэгтэй. Бид Ач санах хууль гэж ярьж байгаа. Одоо бол ач санаж нэмэх



*Сарын 250 мянган төгрөгийн цалинтай хүн, сардаа 25 саяар нь цалин урамшуулал авдаг хүн хоёр адилхан 10 хувиар татвар төлөх нь шударга бус*

нь битгий хэл, авч байсныг нь бага болгоод байна. 70 насална гэдэг сайхан хэрэг. Хэдийгээр дундаж наслалт нэмэгдэж байгаа ч, 70 насална гэдэг чинь нэг талаар асар их хөдөлмөр зүтгэл, бас зөв, эрүүл амьдралын үлгэр дуурайлал. Тийм учраас тэтгэврээс нь гадна тогтмол урамшуулал олгох ёстой гэж боддог. Өнөөдөр төрийн бодлогын толгойд бүх орд газар, уул уурхай, төрийн өмчийн компаниуд байна. Одоо энэ хандлагаа өөрчилж, хүнээ төрийн бодлогын толгойд залж чаддаггүй юмаа гэхэд, төрийн бодлогын гадна ганц ч монгол хүн үлдээхгүйн төлөө ажиллах цаг болсон.

**-Таны илтгэлд бас Хүн амын орлогын албан татварыг ялгавартай тогтооно гэсэн байгаа юм. Одоо байгаа 10 хувийг нэмэх гээд байна уу, хасах гээд байна уу?**

-Хүн амын орлогын татвар бол төсвийг хамгийн амархан бүрдүүлдэг орлогын нэр төрөл. Би хотын даргаар ажиллаж байхдаа энэ татварыг хотын орлогын эх үүсвэр болгохыг УИХ-ын гишүүдэд санал болгож байж, хууль эрх зүйн орчныг нь бүрдүүлж байсан юм. Тэр үед энэ татварын орлого хотынх биш,Төрийн санд улсын төсвийн орлого болж очдог байсан юм. Өнөөдөр Улаанбаатар хот хүн амын орлогын татвараас жилд 400-500 тэрбум төгрөг олж байгаа байх. Бодит амьдрал дээр харвал Хүн амын орлогын татварыг ангилалтай, хувь хэмжээ нь олж байгаа орлогоос нь хамаарсан ялгавартай болгомоор байгаа юм. Гайгүй орлого олдог зарим хэсгээсээ энэ татварыг нь нэмж авъя л даа. Тансаг хэрэглээний татвар гэдэг шиг сардаа 20-30 сая төгрөгийн цалин урамшуулал авч байгаа хүн яагаад 20-30 хувийн татвар төлж болдоггүй юм. Сарын 250 мянган төгрөгийн цалинтай хүн, сардаа 25 саяар нь цалин урамшуулал авдаг хүн хоёр адилхан 10 хувиар татвар төлөх нь шударга бус. Жишээ нь, Оюутолгойн ТУЗ-ийн гурван гишүүний жилийн цалингийн сан 100 мянган доллар гэж чуулган дээр хэлж байсан. Хэрвээ тийм бол, гурван хүн байдаг гэхээр нэг хүний жилийн цалин 33 мянган доллар буюу 66 орчим сая төгрөг. Тэгвэл энэ хүн, жилийн найман сая төгрөгийн цалинтай жирийн албан хаагч хоёр адилхан 10 хувиар татвар төлж байгааг өөрчлөх хэрэгтэй.

**-Энэ нь таны түрүүнд ярьсан нийгмийн шинэ гэрээний нэг хэсэг үү?**

-Тэгж ойлгож болно. Ер нь бол Зүүн хойд Азийн орнууд дундаа Монгол Улс хамгийн бага татвартай. Намайг Ерөнхий сайдаар ажиллаж байхдаа татварын энэ тогтолцоог бий болгож, "дөрвөн 10" гэж ярьдаг татварын орчныг баталж байсан юм. Татварыг бууруулах бодлого цаашид ч байх ёстой. Гэхдээ хавтгайруулж биш, олж байгаа орлоготой нь уялдуулж ялгавартай тогтоодог тогтолцоо хэрэгтэй. Европын орнууд ерөнхийдөө тийм байгаа.

**-Авлигатай тэмцэх газартай холбоотой маш их шүүмжлэл байна. Тухайлбал, Н.Алтанхуяг гишүүн АТГ-ын мөрдөн шалгах эрхийг авъя гээд хуулийн төсөл оруулаад ирчихсэн байгаа. Гэтэл та**



**“Бид хамтдаа” форум дээрээ АТГ-ыг бэхжүүлэх, авлигатай тэмцэх бодлогыг чангатгах ёстой гэсэн дүгнэлт хэлсэн. Энэ нь өнөөдрийн АТГ-ыг хэвээр нь хадгална гэсэн үг үү, эс бол Н.Алтанхуяг гишүүний өргөн барьсан хуулийн төслийг дэмжиж байгаа юу?**

-Н.Алтанхуяг гишүүний өргөн барьсан төсөлтэй танилцсан. Тэнд хоёр зүйл байгаа. Нэгдүгээрт, Прокурорын мөрдөн байцаах албыг АТГ-т харьяалсныг буцааж прокурорт нь шилжүүлье гэж байгаа. Түүнийг яах вэ, АТГ-т байх нь зохимжгүй гэвэл шийдчихэж болно. Хоёрдугаарт, авлига авсан, өгсөн, зуучилсан хэргийг шалгадаг эрх нь АТГ-таа үлдэх ёстой. Гэтэл Н.Алтанхуяг гишүүний төсөлд төсвийн мөнгө идэх, шамшигдуулах, залилан хийх гэх мэт авлигатай холбоотой үүсдэг бүх хэргийг цагдаад шилжүүлье гэсэн байгаа юм. Ингэнэ гэвэл хэтэрхий өрөөсгөл болно. Одоо бол асуудалд холбогдсон хүмүүс нь би хэлмэгдчихлээ, энээ тэрээ гэж ярьсаар байгаад нийгэмд буруу зөрүү ойлголтыг бий болгоод байгаа юм. Түүнээс бус, авлигатай тэмцэнэ гэдэг



*УИХ-ын гишүүн хүн зөвхөн нэг аймаг, нэг гудамж хараад байх явдал байхгүй. Ерөөсөө улс орны эдийн засаг, нийгмийн байдал, нийт ард түмний амьдралд санаа бодлоо чилээж ажиллах ёстой.*



бол зөвхөн Монголын асуудал биш. Бүс нутгийн, дэлхийн асуудал. Бид саяхан АТГ-ыг хэрхэн үнэлэн харж байна вэ гэсэн жижигхэн судалгааг Улаанбаатар хотын есөн дүүрэгт явуулсан. Тэгэхэд судалгаанд оролцсон иргэдийн 39.4 хувь нь "дарга нарын захиалгаар ажилладаг байгууллага" гэж хэлсэн байна. Энэ байгууллага ард иргэдийн дунд ийм үнэлэмжтэй, нэр хүндгүй болсон байна. Хэрвээ ардчиллыг дэмждэг, ардчилсан засаглалтайгаа явах нь үнэн л юм бол ардчилалтай хамт нэг малгайд багтах учиргүй авлигатай тэмцэх л ёстой. Тийм учраас энэ байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх, сайжруулах, хуулийн хүрээнд шударга ажиллуулах бодитой шаардлага бий. Үүний тулд хууль эрх зүйн орчинд нь УИХ анхаарал тавихаас өөр арга байхгүй. Авлигатай тэмцэх талаар амжилт олж байсан зүйл байсан боловч сүүлийн жилүүдэд улстөрчид энэ байгууллагын дотоод үйл ажиллагаа руу нь хэтэрхий орж, янз бүрээр хэлэх нь ихдээд байна.

**-Дахиад асууя. Таны сая ярьдаг, форум дээр хэлсэн нийгмийн шинжтэй эдгээр зүйлс МАН-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн гол амлалт болох уу?**

-Сонгуулийн хуулийн төслийг ид ярилцаж байна. Юу амлах, амлаж болохгүйг хуулиар зохицуулдаг. Бид ард түмнээсээ асууснаа, форумаар хэлэлцсэнээ сонгуулийн мөрийн хөтөлбөртөө шингээх, бодит ажил болгохын төлөө ажиллана.

## МАН СУЛЬДВАЛ ТУСГААР ТОГТНОЛ Ч СУЛАРЧ БОЛЗОШГҮЙ

**-Манай улс жилд 960 гаруй тэрбум төгрөгийг өр, зээлийн үйлчилгээний урсгал зардалд төлж байна гэлээ. Тэгэхээр иргэдийн цалин, тэтгэврийг нэмэх, ахмадуудад нэмэлт тэтгэмж өгөх зэрэг боломж эдийн засагт гарах болов уу?**

-Гарахгүй гээд суугаад байвал гарахгүй л байх. Гаргана гэж зүтгэвэл болох л байх. Өр зээл их ч, өрөө дараад, иргэдийнхээ амьдралыг өөд татах олон гарц бий. Харин буруу бодлого явуулаад байвал бүр хүндрээд л байна. Ямарч бэрхшээл боломжтойгоо хамт ирдэг гэдэг. Тэрийг нь олох хэрэгтэй. Жишээ нь, өнөөдөр нэмэлт орлого олохыг гол болгох уу, байгаа эдийн засгаа хэрхэн сэргээх вэ гэдгээ гол болгох уу гэдэг нь бодлогын сонголт. Хамгийн гол нь төр, засгийн бодлого айл бүрт хүрч, амьдралд нь зэрэгээр тусч байж үр дүн гарна. Харамсалтай нь, шийдлийн гэж нэрлээд байгаа өнөөдрийн Засгийн газар буруу шийдээд байна. Энэ Засгийн газар Засгийн газрын, төрийн ажлыг завандаа хийж байна. Энэ Засгийн газар өөрөө тогтохын тулд хэвлэлийн PR-т, АН доторхи фракцуудын сонирхлыг

хангахад хэтэрхий их цаг зав, мөнгө үрж байгаа. Ард түмнийхээ амьдралыг дээшлүүлэхийн төлөө ажиллах үүргээ бүлэглэлийн сонирхлыг хангах, суудалдаа тогтож үлдэх зэрэг улстөрийн явцуу эрх ашгийнхаа ард, бүр хамаагүй хойно эрэмбэлж явна. Жишээ нь, дэлхийн зах зээл дээр нэг баррель нефтийн үнэ 120 ам.доллараас 42 болтлоо буурлаа. Гурав дахин. Харин Монголд бензиний үнэ гурав дахин буурсан уу, үгүй. Бид төсвийн хэлэлцүүлгийн үеэр сайд нарт зөндөө хэлсэн. Гэтэл тэд нефтийн бүтээгдэхүүний үнэ унасан таатай нөхцөлийг ашиглаж татварын орлого нэмэгдүүлж, 200, 300 тэрбум төгрөг олно гэж зүтгэх юм. Хэрвээ бид байсан бол бензиний үнийг 300-400 төгрөгөөр буулгаад, татвар авахгүй. Бензиний үнэ 50 төгрөгөөр нэмэгдэхэд талх гурван төгрөгөөр нэмэгддэг гэсэн судалгаа байдаг байсан. Хэрвээ бензиний үнийг 300 төгрөгөөр бууруулчихвал талхны үнэ буурна. Худалдаа үйлдвэрлэл, худалдан авалт сэргэнэ гээд гинжин урвалаар нөлөөлөх зэрэг нөлөөлөл нь хамаагүй их. Гэтэл боломж олдсон дээр нь татвар авна л гээд суучих юм. Татвар авахад хэзээ ч оройтохгүй. Хамгийн гол нь тэр татварыг төлж чадах орчин, санхүүгийн чадварыг бий болгох нь чухал. Тэгээгүй байж, юуны түрүүнд л татвараар дарамтлах нь мөнгөгүй, орлогогүй хүнээс мөнгө нэхэхтэй адилхан. Хүмүүс ажлын байргүй болохоос айж байна. Айсандаа зарим нь өөрийгөө шатаахыг завдаж байна. Ажлын байртайгаа үлдэж байгаа нэг хүний ард гэр бүлийнх нь амьдрал байгаа. Өнөөдөр ажил хийж байгаа монгол хүн бүрийн ард Монгол Улсын амьдрал байгаа. Тийм учраас татвараар дамжуулж орлого олъё гэхээсээ илүү ажлын байраа хадгалж үлдсэн компаниудыг харин ч татварын хөнгөлөлтөөр урамшуулах хэрэгтэй. Энэ мэтээр эдийн засгаа сэргээх, зохицуулалт хийх нь Засгийн газрын үндсэн ажил. Засгийн газар бол татвар цуглуулаад буцааж тараадаг бүтэц биш шүү дээ. Жишээ нь, бензин дээр гэхэд зах зээл дээр үнэ нь нэмэгдээд байна гэж “Үнэ тогтворжуулах” хөтөлбөрөөр дотац өгсөн. Одоо болохоор, зах зээл дээр үнэ буухаар нөгөө дотацын дэмжлэгээ татварын хөтөлбөр болгоод, үнийг урьдын хэмжээнд нь хадгалаад байгаа юм. Энэ буруу бодлогын хохирол, сөрөг тал нь ард түмний нуруун дээр л ирж байгаа.

**-УИХ одоо дахиж нэмж өр авах гээд байна уу?**

-Хүн өөртөө зориулж янз бүрийн л зүйл хийх юм. Өмнө нь улсын өрийн босгыг УИХ дээр 3/2-оор шийддэг, цөөнхөө сонсдог байлаа. Гэтэл зарим гишүүн үүнийг Цэцэд хандаж босгогүй болгоод одоо ердийн олонхиор өрийн асуудлыг шийдэж байна. Өрийг ДНБ-ий 58.3-иас хэтрүүлж болохгүйг УИХ-ын тогтоолоор хааж өгсөн. Гэтэл Цэцэд хандаж босгогүй болсноор өрийн асуудлыг одоо бидэнтэй бидэнгүйгээр эрх баригчид өөрсдөө дангаараа шийдээд явж байгаа. Яах вэ, өндөр өртөгтэй өрөөс гарахын тулд бага хүүтэй зээл авч болно. Хамгийн гол нь сайн бодож, тооцож үзэх хэрэгтэй. Тавьсан өрөөрөө юу бүтээв, бүтээсэн зүйл нь өрөө эргүүлж төлөх мөнгө олж чадаж байна уу гэдгийг тооцох үзэх хэрэгтэй юм. Ямарч хүн хийх юмаа олж, төлөвлөчихөөд мөнгө зээлдэг. АН-ынхан мөнгөө олчихоод хийх юмаа төлөвлөх гээд байх юм. “Чингис” бондыг тэгсэн шүү дээ. Мөнгө босгоод ирсэн, гэтэл оруулах бизнесийн төсөл байгаагүй. Тэгээд зам руу баахан мөнгө оруулсан. Зам бол өөрөө өртгөө нөхдөг бизнесийн төсөл биш. Өртгөө, хүүгээ хамт олдог бизнесийн төсөл байхгүй учраас “Чингис” бондын гуравны нэгийг одоо болтол хэрэглээгүй, хэрэглэж чадахгүй сууж байна. Монголчууд бид саваа бэлдэж байж саалиа авна гэдэг. Гэтэл “Чингис”, “Самурай” бондын мөнгийг шингээх “сав”-ыг бэлдээгүй байхдаа авчихсан учраас “саалиа” сул асгаад дуусч байх шиг байна. Дансаараа бол Хөгжлийн банкинд 500 сая ам.доллар байх ёстой. Яг байгаа, үгүй нь бас мэдэгдэхгүй л байгаа.

**-Ер нь энэ парламентад намуудын зөвшилцөл гэж байна уу. Хэдийгээр АН засгийн эрх барьж байгаа ч, олонхгүй парламент шүү дээ?**

-Тийм зүйл байхгүй юм шиг байна. Ууган намын хувьд бид зөвшилцөх гэж янз бүрээр үзлээ. “Үндэсний зөвшилцөл” нэртэй уулзалт хийж үзлээ. Хамгийн олон суудал авсан намын удирдлагууд ирдэггүй юм байна. 12 удаагийн уулзалт хийхэд АН ерөнхий нарийн бичгийн даргынхаа түвшинд хоёр удаа л оролцсон. АН-ынхан ганц удаа хамгийн олон суудал авчихаад бүх зүйлийг болгоно, бүтээнэ гэж зүтгээд байгаа бол одоо яах вэ. Зүтгээд байхаас. Уул үзээгүй байж хормой шууна гэдэг шиг ард түмэн санаж байгаа бол УИХ-ын даргыг хүртэл МАН-ын оролцоогүйгээр сонгож, манай намыг УИХ-д бүлэггүй явуулж, эхэндээ их хүч түрсэн дээ. Гэтэл дэлхийн өнөөдрийн чиг хандлага бол олон суудалтай нь битгий хэл, олонх болсон нь дангаараа явахаас татгалзаж, кнопны олонхид биш, олуулаа зөвлөлдөж байж шийдвэрээ гаргахыг илүүд үздэг болж байна. Яагаад гэвэл тэгж гаргасан шийдвэр зөв бөгөөд

урт настай байдаг.

**-Уг нь танай намынхан бол засагт хамтрах гэж үзсэн, тийм үү?**

-Засгийн газарт хамтрах санаачилга МАН-аас биш, АН-аас анх гарсан. Бидэнд албан ёсоор санал тавиад, одоогийн Ерөнхий сайд Ч.Сайханбилэгээс манай намын Бага хурлын гишүүдэд уран сайхан үгтэй захидал хүртэл илгээж байлаа. Тэгэхээр нь, уриад байхаар нь, нээрээ ч бидний туршлага хэрэг болоод, улс оронд, төр засагт тогтвортой байдал бий болгох юм болов уу гэж хамтаараа хэлэлцээд Засгийн газарт хамтарсан. Гэтэл хэдхэн сарын дараа одоо та нарын хэрэгцээ байхгүй. Явцгаа л гэсэн. Биднийг эхлээд улс орны эрх ашгийн төлөө гэж Засгийн газарт уриад, дараа нь улс төрийн зорилгоор, улс төрийн эрх ашгаа бодож хөөж гаргасан л даа. Тэгж хэлсэн АН-ын удирдлагуудын үг ч бий.

**-Танай намынхан ч гэсэн ямар нэгэн зорилготой л Засгийн газарт хамтарсан байж таарна. Тэр зорилгоо биелүүлж чадсан уу?**

-Бидний засгийн газарт хамтарч ажилласан хугацаа нь дэндүү богино байсан. Гэхдээ улс орныхоо төлөө тодорхой ажлуудыг хийсэн.

**-УИХ-ын Сонгуулийн хууль бас л улс төр. Зөвшилцөж байж л явна. Үүнийг кнопны олноор баталж чадахгүй. Танай намынхан бол хар машинаар л тоолуулахгүй гээд байх шиг байна. Зөвшилцөөд сонгуулийн хуулиа баталж чадах болов уу?**

-Сонгуулийн хуулийн гурван ч төсөл дээр дээр ажлын хэсэг ажиллаж байна. МАН өөрчилж батлахын төлөө байгаа. Хар машины тухайд, бид огт тоолуулахгүй гээгүй. Тоолуулъя, хэрвээ нэр дэвшигч гомдол гаргавал гараар давхар тоолъё, тоолоод зөрүү гарвал гар тооллогыг баримталъя гэсэн санал гаргаж байгаа. Энэ бол хүлээж авч болохгүй санал биш. Монголын ард түмэн хар машинд итгэхгүй л байгаа. Сөрөг хүчний намын дарга учраас ганц би хэлээд байгаа ч юм биш. Захын хэнтэй ч уулзсан хар машин нэг л биш гэж хэлээд байгаа.

**-Томсгосон тойргийг жижиглэх, нэг тойрог-нэг мандат гэсэн хувилбарыг МАН дэмжиж байгаа юу?**

-Тойрог, мандатын хуваарийг хуулийн төсөл бүрт өөр, өөрөөр оруулсан байна. Су.Батболд





*Хэрвээ эвсэх, хамтрах дээрээ тулбал МАН, МАХН хоёрын зорилго, зарчим нийлж байх ёстой*

нарын санаачилсан хуулийн төсөл дээр 48 тойргоо жижиглэж 48 мандаттай болгоё гэсэн байгаа. Су.Батболд гишүүний гэсэн нэртэй боловч энэ бол улс төрийн 20 намын хамтран санаачилсан хуулийн төсөл. Тийм учраас МАН одоогийн байгаа 48:28-аар тогтож, мажоритар хэсгийг буюу 48 тойргоо 48 мандат болгоё гэсэн улс төрийн 20 намын саналыг дэмжиж байгаа.

**-Өмнөх сонгуулиар листэнд орсон нэр дэвшигч ирэх сонгуулиар дахин жагсаалтад орж болох уу?**

-Өнөөдрийн хуулиар бол хориглосон зүйл байхгүй. Гэхдээ намын нэрсийн жагсаалтыг ард түмэн хүлээн зөвшөөрөхгүй л байгаа шүү дээ.

**-Тухайлбал, та энэ удаагийн сонгуулиар тойрогт дэвших үү, намын листэнд орох уу?**

-Яг тэгнэ гээд хэлэхэд эрт байна. Сонгуулийн хуулийг харна. Тойрогтоо дэвшээд, олон түмэндээ нүүрээ харуулаад, тэднээрээ дүнгээ тавиулаад явах нь шулуун шударга, зөв байх гэсэн бодол бол байгаа. Хувийн бодлоор бол тойрогтоо л дэвшиж л таарах болов уу. Гэхдээ намын эрх ашиг, намын хамт олны шийдвэр бол хувийн бодлын дээр эрэмбэлэгдэх ёстой. Тэр тусмаа намын дарга.

**-Сүүлийн үед МАН МАХН хоёр сонгуульд хамтрах, эвсэх тухай мэдээлэл гарч байна. МАХН-тай эвсэх гээд байгаагийн шалтгаан нь юу вэ. МАН-аас МАХН руу элсэж байгаа гишүүдийн урсгал хүчтэй байна уу, эсвэл санал хуваагдахаас айж байна уу?**

-Манай намаас МАХН руу тийм олон хүн элсээд л, тэр нь “хүчтэй урсгал” гэж томъёолох хэмжээнд хүрч байна гэж үү?

**-Байна л даа. Нарийн бичгийн дарга байсан Ж.Сүхбаатараас эхлээд...**

-Явж байгаа мэдээлэл нь МАН-аас олон арван хүн МАХН руу орж байгаа юм шиг боловч үнэн хэрэг дээрээ ганц, хоёр хүний л асуудал бий. Аль намд байх нь тухай хүний асуудал.Улс төрийн нам бол хэн нэгэн улстөрчийн, хэн нэгэн улс төрийн лидерийг дэмжигчдийн фэн клуб биш шүү дээ. Улстөрийн нам бол үзэл бодлын нэгдэл. Улс төрийн нам бол нийтийн төлөө нэг зорилго дор ажиллах, хамтарч чадах багийн, хамт олны тоглолт. Гэтэл одоо үзэл бодол хамаагүй, аль намд байх нь надад ашигтай вэ гэдэг ганц шалгуураар сонголтоо хийдэг болж. Би л байхгүй бол, миний эрх ашиг л хангагдаагүй бол бусад нь, баг надад хамаагүй гэх байдлаар хандаж, өөр намд очоод хангагдаагүй тэр эрх ашгаа олж, очиж чадаагүй албан тушаалаа авдаг болсон байна. Цаашдаа ийм хүмүүс МАН-д гэлтгүй,

Монголын улс төрд орон зайгүй байх ёстой. Улс орон хөгжихөд улстөрч хүний тууштай, шударга чанар эрхэм бөгөөд мөнгөнөөс ч үнэтэй. Хаврын тэнгэр шиг хуйсгануур зан хамт олондоо ч, хувь хүндээ ч хортой. Хэрвээ Монгол Улс хөгжье л гэвэл улс төрийн орчин нь цэвэр, улстөрчид нь эрүүл үзэл бодолтой байх хэрэгтэй. Тэрний төлөө холын зорилго тавиад явж байгаа багийн дундаас зарим хүн замын дунд эргэж буцах нь улсын хөгжилд ч хорлонтой. Энд би эргэж буцах гэдгийг ганц нам солихтой холбож хэлмээргүй байна. Үзэл бодлоосоо, үнэт зүйлээсээ, өмнө гаргасан шийдвэрээсээ буцна, няцна гэдэг бол улстөрч хүний, тэр тусмаа монгол хүний зан биш.

**-Тэгвэл санал хуваагдахаас болгоомжилж байгаа юу, 2012 онд бол хуваагдсан?**

-Яах вэ, нэг цул байсан нам хоёр хуваагдахаар дагаад бодит амьдрал дээр санал бол хуваагдаж байгаа. Гэхдээ сонгогчийн саналыг хуваахгүй гэж МАХН-тай сонгуульд хамтрах, эвсэх нь бодит шалтгаан болохгүй. Байх ч ёсгүй. Хэрвээ эвсэх, хамтрах дээрээ тулбал МАН, МАХН хоёрын зорилго, зарчим нийлж байх ёстой. Сонгогчдын саналыг хуваахгүй гэдгийг ганц шалгуур болгож механик эвсэл үүсгэвэл үзэл бодол, үнэт зүйлээсээ урвасантай ялгаагүй. Ер нь сонгуульд зориулсан механик нэгдэл ч дээ, олон түмэнд итгэл төрүүлж саналыг нь авсан хэр нь сонгуулийн дараа салж хагацах нь амархан, хийж бүтээх нь бага юм уу гэж би хувьдаа хардаг. Сонгуульд намууд хамтарч эвсэж орох нь монголчууд бидний хувьд шинэ зам биш. АН хэдхэн жилийн өмнө Эх орон, Иргэний зориг намуудтай эвсэж сонгуульд ороод хамгийн олон суудал авсан ч, удалгүй эвсэл нь задарсан. Өнөөдрийн МАХН, МҮАН-ын “Шударга ёс” эвсэл ч ялгаагүй, эвсэж хамтарсан Засгийн газрынхаа сул тал дээр улстөр хийсэн, хэдхэн хүн хүссэнээ шингээх гэж хяссан цөөхөн хэсгийн нэгдэл мэт харагддаг. МАН, МАХН-ын



*МАН 2016 оны сонгуульд амжилттай оролцох нь миний намын дарга болсны гол зорилго. Тэр зорилгынхоо дагуу бодож, төлөвлөсөн ажлаа хийгээд явж байна.*

хувьд ахмадууд маань намын удирдлагуудтай уулзаж, сонгуулийн өмнө хэл амаа ололцооч гэсэн санал тавьсан. Манай намын хэсэг залуу юу, юугүй хамтрах нь буруу гэж байгаа. Би намын дарга болсны дараа орон нутагт хоёр намын анхан шатны нэгжүүд учраа олж, ойлголцож ажиллаарай гэж хэлж байсан. Тэгэхээр өнөөдөр яг ингэнэ, тэгнэ гэж хэлэх зүйл алга. Асуудал нээлттэй байгаа. Зөвхөн МАН, МАХН гэлтгүй, бүх нам улс орныхоо төлөө, орон нутагт бол аймаг, сумынхаа төлөө өдөр бүр хамтарч ажиллах ёстой гэж үздэг хүн, би.

**-Сонгуульд хамтрах талаар та МАХН-ын дарга Н.Энхбаяртай хэд хэдэн удаагийн уулзалт хийсэн юм биш үү?**

-Ганц, хоёрхон удаа л уулзсан. Тэгж олон удаа уулзсан юм байхгүй.

**-АН-ын рейтинг муу байгаа гэх юм. Тэглээ гээд танай намын рейтинг бас өсөхгүй байгаа юм биш үү. Танд намуудын рейтингийн судалгаа байна уу?**

-МАН-ын рейтинг бага, багаар өсөж байгаа. Ямар ч гэсэн АН-ынхаас илүү байгаа. Нэг хоёр пунктээр илүү байсан бол, одоо гурав, дөрөв болж нэмэгдсэн. Нэлээд хэдэн байгууллагын судалгаагаа иймэрхүү ойролцоо дүн гаргаж байгаа.

**-Жаахан өсөлт байгаа бол тэр нь танай намын үйл ажиллагаатай холбоотой өсөлт байна уу, эс бол эрх баригчдын нэр хүндийн уналтыг дагаж автоматаар ирсэн өсөлт үү?**

-Аль аль нь л байгаа байх. Юу ч хийхгүй суугаад байгаа мэт харж болохгүй. Жишээ нь, Өршөөл үзүүлэх тухай хууль, улсын төсөв хэлэлцэхэд бид маш тодорхой байр суурьтай байсан. Үүнийг олон түмэн харсан л байх. Өдөр болгон хэвлэлээр гараад, өөд уруугүй өөрийгөө магтаад байхаар рейтинг өсдөг ч юм биш. Бас сөрөг хүчин гээд бүгдийг сөрөөд байж болохгүй. Манайх шиг тулхтай, туршлагатай улс төрийн хүчний хувьд бүгдийг сөрөөд байхгүйгээр том, зарчмын асуудлууд дээр дуугараад, олонхидоо ажил хийх боломжоог олгох нь улс төрийн соёл. МАН бодитой эрсдэлийг урьдчилж хардаг, зөв үнэлэлт дүгнэлт өгдөг, зөв шийдэл санал болгодог, улс орон, олон нийтийнхээ төлөө олж, оноож дуугардаг сөрөг хүчин байж чадаж байгаа. Хэрвээ бид намдаа сонгуулийн рейтинг цуглуулахын төлөө ажил хийдэг байсан бол, рейтингийн арай өөр дүн, улс төрийн арай өөр орчин байх байсан болов уу.

**-Жишээ нь, таныг дарга болох үед танай намын рейтинг хэд байсан, одоо хэд болоод байна вэ?**

-Намайг намын дарга болоход 18,19 хувьтай байсан рейтинг одоо 30 гаруй хувьтай байгаа.



**-Та хоёр дахь удаагаа МАН-ын дарга болсон. Мэдээж, бодсон зүйл, зорилго, төлөвлөгөө байсан л байх. Одоо тэр зорилгынхоо хэдэн хувьд хүрээд байна вэ?**

-МАН-ын дарга байх нь намын дарга болохоос хэцүү. Яагаад гэвэл МАН өөрөө олон жилийн түүхтэй, арвин туршлагатай, эрх барьсан ч, цөөнх болсон ч олон түмний итгэлийг тээж явдаг нам. МАН алдах, хазгай гишгэх нь Монголын ард түмэн алдсантай бараг дүйх хэмжээнд, ойлгогддог, хүлээн зөвшөөрөгддөг. Хэрвээ МАН сульдвал Монгол Улсын тусгаар тогтнол ч суларч болзошгүй. Тэгэхээр Монгол Улсын тусгаар тогтнолыг хамгаалах манаач нь ч, монголчуудынхаа амьдралыг авч явах ёстой менежер нь ч МАН юм. Иймэрэмбэ, зангараг, үүрэгтэй намын дарга байна, намын даргаар ажиллана гэдэг бол асар их хариуцлага, итгэл. Тийм учраас МАН 2016 оны сонгуульд амжилттай оролцох нь миний намын дарга болсны гол зорилго. Тэр зорилгынхоо дагуу бодож, төлөвлөсөн ажлаа хийгээд явж байна. Сонгуулиар үр дүн нь харагдана. Яг өнөөдөр хувилаад дүгнээд байх зүйл алга.

**-Та намын дарга болоод залуучуудыг, шинэ хүмүүсийг нэлээн дэмжиж байх шиг байна. Шинэ хүн чухал юм уу, нэр цэвэр, улс төрийн туршлагатай хүн чухал юм уу?**

-Аль аль нь чухал. Аль нэг тал руу нь туйлшруулж огт болохгүй. Туршлагатай нь шинийгээ чирч, үлгэрлэж, бие биеэ нөхөж явах ёстой. Тэгж дараагийн туршлагатай улстөрчийг өмнөх үеэр нь бэлдүүлэх нь Монголын төрийн түүхэнд эртнээс байж ирсэн дэг сургууль. Түүний төлөө аминдаа залуучуудаа дэмжих, гаргаж ирэх бодлого баримталж байгаа. Мэдээж аливаа юманд, тэр тусмаа хүний нөөцийн бодлогод тунг нь тааруулах шаардлага бий. Өнөөдөр төрийг улстөрийн намаар дамжуулж байгуулж, засгийн эрхийг намуудаар дамжуулж барьж байна. Дэлхийн бүх оронд тийм байна. Энэ тохиолдолд засгийн эрх барьсан үедээ, бариагүй үедээ ч төрийн хүнийг бэлтгэх нь намуудын үүрэг. Энэ үүргээ хамгийн сайн ухамсарладаг, хамгийн сайн биелүүлдэг, бас төрийн ажлын туршлагатай хүний нөөцөөр хамгийн баялаг нь МАН. Иймд МАН-д элсэх, энэ намын үүрээс эхлээд орон нутаг, төв байгууллага хүртэл бүх шатанд ажиллана гэдэг бол улс төрийн карьер хөөхөөс гадна монгол төрийн хүн болох, Монголын төрд зүтгэх амьдралын их сургуульд суралцаж байгаа хэрэг юм.

## ТОЙРГОО СОЛИХ НЬ УЛСТӨРЧ ХҮНД БАЙХ САЙН ЧАНАР БИШ

**- Та хотын дарга байсан мөртлөө хөдөө, Төв аймагт нэр дэвшдэг. Хэрвээ 2016 онд тойрогт дэвшвэл бас Төв аймгаа л сонгох байх. Энэ нь өөрөө УИХ-д сонгогдох найдвартай байдлаа харсан сонголт уу, эсвэл өөр хүчин зүйл байна уу?**

-Би Улаанбаатараас УИХ-д сонгогдож байсан л даа. Баянгол дүүргийн 65 дугаар тойргоос 70 гаруй хувийн саналаар сонгогдож байсан. Түүний дараа намын нөхөд маань орон нутагт нэр дэвшээч гэсэн. Төв аймгаас хоёр удаа сонгогдсон. Ирэх сонгуулийн тухайд найман жил итгэл хүлээлгэсэн Төв аймгийнхан маань юу гэж бодож, дүгнэж байдгийг харж байж шийднэ. Тэгээд ч байнга тойрог солиод байх нь улстөрч хүний зөв үйлдэл биш гэж би үздэг.

**-Та тойрогт, төрсөн нутаг Төв аймагтаа нэр дэвшлээ гэж бодъё. Хоёр ч удаа сонгогдсон хүнээс сонгогчид уйдах асуудал бий. Төв аймгийнхан танаас уйдаагүй, тэдний итгэлийг алдаагүй баталгаа танд байна уу?**

-Байна аа, судалгаа байна. Нутгийн олныхоо, сонгогчдынхоо итгэлийг өөрийн чадал, боломжийнхоо хэмжээнд зүтгэлээр хариулж яваа. Тийм учраас итгэлтэй байна. УИХ-ын гишүүн хүн зөвхөн нэг аймаг, нэг гудамж хараад байх явдал байхгүй. Ерөөсөө улс орны эдийн засаг, нийгмийн байдал, нийт ард түмний амьдралд санаа бодлоо чилээж ажиллах ёстой.

**-Энэ итгэлийг Та юугаар олж авсан юм. Том намын дарга гэдэг албан тушаалын нэр хүндэд найдаж байна уу, эсвэл үнэхээр тойрогтоо ажилласан юм уу?**

-Тойрогтоо ажиллалгүй яах вэ. Ажиллана, та нарын төлөө зүтгэнэ гэж сонгогдчихоод УИХ-ын чуулганы танхимд шигдээд суугаад байх нь миний зан биш. Савыг нь хоосон буцаадаггүй монгол зан заншил гэж байна. Надад өгсөн, намайг УИХ-д сонгосон сонгогчийн саналыг би итгэлээр, зүтгэлээр, буцааж хариулах нь улстөрч хүний үүрэг. Саналыг нь буцааж хариулна гэдэг нь мөнгө төгрөг тараана гэсэн

үг биш шүү дээ. Шууд болон шууд бусаар тухай сонгогчийн амьдралд ээрэгээр нөлөөлөх төрийн шийдвэр гаргуулахаас эхлээд сонгогчдынхоо итгэлийг дааж ажиллах хүртэл олон боломж бий. Том эрх ашгийн дор жижиг нь захирагдаж явдаг. УИХ-ын гишүүд заавал тойрог гэхгүйгээр улсынхаа хөгжлийн төлөө гаргасан нэг зөв шийдвэр, нэг сайн бүтээн байгуулалтын хаялга нь бүх монгол хүнд, тухайлбал миний сонгогчид болох Төв аймгийнхны асуудлыг ч давхар шийдэж байгаа юм. Асуудлыг тэр өнцгөөс нь харах чадвар Монголын ард түмэнд, тэр дундаа манай Төв аймгийнханд бий.

**-Танай нам эрх баригч байхад, та Шадар сайд байхдаа тойрогтоо ажилласан байх. Харин саяхан сөрөг хүчин байхдаа яаж ажилласан байх вэ. УИХ-ын дэд дарга бол тойрогтоо төсөв хуваарилаад байх эрх мэдэлтэй албан тушаалтан мөн үү?**

-Төсөв мөнгөн дээр, ер нь УИХ-ын төвшинд УИХ-ын дэд даргад ямар нэгэн илүү эрх мэдэл байхгүй. Жишээ нь, би сая сонгогдсон дөрвөн жилийнхээ хугацаанд Төв аймгийн төвд том театрын барилгын ажлыг эхлүүллээ. Одоо барилгын ажлын 70 орчим хувьтай явж байна. Аль ч Засгийн газраас энэ асуудлыг оруулж ирээгүй. Төсөв УИХ-д өргөн барьсан хойно, 2013 оны арваннэгдүгээр сард өргөн барьсан төсөл дөө. Би Засгийн газар төсвөө өргөн барьсан хойно УИХ дээр ярьж ойлгуулж байгаад улсын нийслэлд хамгийн ойрхон байдаг, Улаанбаатарт ирсэн зочин болгон очдог, урлаг соёлоороо гадна дотнын зочдод үйлчилж байх ёстой аймгийнхаа 200-300-хан хүний суудалтай 1950-1960 онд барьсан жижиг театрын барилгыг шинэчилж чадлаа. Энэ бол сэтгэл байгаад зүтгэвэл заавал олонх цөөнх гэхгүйгээр УИХ анхаарч шийдэж болдгийн нэг жишээ.



Мэдээж аймаг, сум, суурин газарт эдийн засаг, санхүүгийн дэмжлэг болох ажлыг хийх ёстой. Би Шадар сайд байхдаа Жаргалант, Борнуур, Батсүмбэр сумыг Улаанбаатар хотын хүнсний хангамжийг сайжруулах Германы төслийн хүрээнд авто замтай болгох асуудлыг шийдсэн. Төсөл нь сая дуусч байна. Энэ бол гурван суманд байгаа иргэдийн ногоо, сүүн бүтээгдэхүүнийг чанарын эрсдэлгүй Улаанбаатар хотод оруулж ирэх боломжийг нээсэн хэрэг. Одоо ямарч гэсэн энэ гурван сумын иргэд өглөө авсан сүүгээ гашилгачихгүйгээр өдөртөө Улаанбаатарт авчирч зараад байх бололцоотой болсон.

*МАН бол том зургаа хардаг нам. Нэг улсад амьдарч, ашгийг нь улсаараа хүртэх том төслийг манайх авна, танайх тэрийг нь ав гэж зодолдоод байх бүлэг фракц манай намд байхгүй.*

**-Ойрхон учраас тойрог руугаа та их явах уу?**

-Явна аа, явна.

**-Захиа занаа их ирэх үү, хариуг нь өгдөг үү?**

-Ирэлгүй яах вэ. Ирсэн захиа бүрийг уншина. Уншаад цохолт хийгээд туслахдаа өгдөг. Тавьсан асуудал бүрийг боломжоороо, хуулийн хүрээнд шийдэхийг хичээдэг.

**-Ярилцлагын эхэнд та “Хэчнээн өртэй байгаа ч гэсэн улсын хөгжлийг том зургаараа аваад явах боломж байна. Өрөө ингэж шийдэх боломжтой” гэж ярьсан. Үүнтэй адил Төв аймгийн ирэх дөрвөн жилийн ирээдүйг та яаж төсөөлж байна вэ?**



-Төв аймаг бол хөгжих бололцоотой нутаг. Улаанбаатар хотыг тойрч оршиж, олон жил ар тал нь болж ирсэн аймаг. Одоо тодорхой хэмжээний дэмжлэг, дэд бүтцийн нөхцөл бололцоог бүрдүүлэх шаардлагатай. Социализмын үеэс л Төв аймгийн газар тариалангийн бүтээгдэхүүнийг Улаанбаатар руу зөв зохистой нийлүүлэх талаар төр, Засгийн газрын төвшинд анхаарч ирсэн. Энэ тал дээр нэмж анхаарал хандуулбал аймаг, орон нутгийн иргэдийн амьдрал дээшлэх боломжтой. Өнгөрсөн дөрвөн жил Угтаал суманд гэхэд 30-40 мянган тонны Элеватор засаж сэлбэх ажлыг эхлүүлж, саяашиглалтад орлоо. Ойролцоох сумд одоо тэнд будаагаа тушаачих жишээтэй.

**-Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ашиглалтад орно. Үүнийг дагаж аймгийн хөгжил яаж өөрчлөгдөх бол, энэ буудлыг барих шийдвэрийг гаргахад таны оролцоо байсан уу?**

-Би Ерөнхий сайд байхдаа 2006 оны гуравдугаар сарын 6-ны өдөр Токио хотод Койзүми Ерөнхий сайдтай уулзаад “Ази, Европыг холбосон хамгийн ойр зам Улаанбаатарын дээгүүр байна. Монголд нисэх онгоцны буудал барихад туслаач” гэдэг хүсэлт тавьж байлаа. Тэр хүсэлтийн дараа долдугаар сарын 11-нд наадмаар Койзүми Ерөнхий сайд Монголд айлчилж “Таны тавьсан хүсэлтийн дагуу нэлээд судалгаа хийлээ. Тодорхой компанид үүрэг өгсөн. Зайлшгүй шаардлагатай, зөв юм ярьсан байна” гэж хэлсэн. Тэгээд 2007 оны нэгдүгээр сард Монгол Улсын Ерөнхийлөгч Япон улсад айлчлахад нь “Бид хөнгөлөлттэй зээл олгож танай Засгийн

газрын тэргүүний тавьсан хүсэлтийн дагуу нисэх онгоцны буудлын ажилд дэмжлэг үзүүлэхэд бэлэн байна" гэж эцсийн хариугаа өгч байсан юм.

**-Тэр үед газрыг нь Хөшигийн хөндий гэж сонгосон байсан уу, сүүлд сонгосон юм уу?**

-Нэг хэсэг Налайх руу их явсан юм аа. Би Налайхад болохгүй гэж үзэж байсан. Хэрвээ Налайхад энэ буудлыг хийе гэвэл хоёр талаасаа буух бололцоо нь Хөшигийн хөндийгөө давж өгөхгүй байсан юм. Хөшигийн хөндий бол аль ч талаасаа бололцоо нь илүү шийдэл гэж мэргэжлийн хүмүүс ч дүгнэсэн. Дээр нь нисэх буудлыг дагасан нэг том хот Төв аймагт бий болох учраас би тэр талд зогссон. 80-100 мянган хүнтэй хот босно гэсэн судалгаа байдаг. Замын асуудлыг нь энэ Засгийн газар шийдэж байх шиг байна. Хөшигийн хөндийн нисэх буудлын дараа Төв аймагт их хөлийн газар болно. Зарим хүн дэд бүтэцгүй л гэдэг юм. Дэд бүтцийг бол бий болгож болно. Улаанбаатарт ч тэр, дэд бүтцийн асуудалдаа анхаарах ёстой гэж гаднынхан зөвлөдөг. Улаанбаатар хот 470 мянган га хавтгай дөрвөлжин нутаг дэвсгэртэй мөртлөө ердөө 30-хан хувьд нь суурьшлын бүс тогтсон байдаг. Энэ нь дэд бүтэцтэй холбоотой.

**-Өнгөрсөн дөрвөн жилд Төв аймгийн төсөв нэмэгдсэн үү?**

-Урсгал төсөв тогтвортой байгаа. Харин хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа. Гэхдээ тэр нь аймаг гэхээсээ илүү Улаанбаатар хотын замыг сайжруулах үүднээс Төв аймгийн нутаг дэвсгэрийг дайрч түүнийг Төв аймагт хийсэн хөрөнгө оруулалт гэж тооцвол нэмэгдээд байгаа юм.

**-Төв аймгаас сонгогдсон гишүүд бүгдээрээ сөрөг хүчнийх. Эрх баригчдаас байхгүй болохоор тухайн аймаг хаягддаг гэх шүүмжлэл, гомдол бусад гишүүдэд байдаг. Төв аймагт тийм зүйл байна уу?**

-Бий шүү. Ганц жишээ ярья. Сая шинэ 112 объектыг 123 тэрбум төгрөгөөр барьж байгуулахаар Засгийн газар УИХ-д өргөн барилаа. Хүн хамгийн түрүүнд аймгаа л хардаг юм билээ. Тэгсэн чинь, Төв аймагт гээд зөвхөн Хөшигийн хөндийг дагаж байгуулах хотын ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад зориулж 600 сая төгрөг тавьсан байгаа юм. Гэтэл энэ бол Төв аймагт зориулсан хөрөнгө оруулалт биш. Улсын хэмжээний бүтээн байгуулалт, Улаанбаатар хотын нүүр царайтай холбоотой л тавьсан мөнгө. Өөр Төв аймагтай холбоотой юм төсөвт юу ч байхгүй. Сөрөг хүчнийх болохоор ийм л байгаа юм. Гэтэл Өвөрхангайд есөн объект шинээр барихаар тусгасан. Яагаад гэвэл Өвөрхангайгаас сонгогдсон АН-ын гишүүд дунд сайд ч байна. УИХ-ын дарга ч Өвөрхангайнх. Энэ бол өнөөдрийн эрх баригчид Төв аймгийг, ер нь төсөв хуваарилахдаа УИХ-ын гишүүн нь эрх баригч намынх, сөрөг хүчнийх гэж ялгаж хардгийн илэрхийлэл.

## ЗАСГИЙН ГАЗАРТ МАН ҮНЭЛЭЛТ ӨГӨХИЙГ ҮГҮЙСГЭХГҮЙ

**-УИХ-ын зарим гишүүн Засгийн газрыг огцруулахаар гарын үсэг цуглуулж байгаа. Танай намаас ч нэлээд гишүүн зурсан. Таныхаар одоо Засгийн газрыг огцруулах, оролдох нь зөв үү?**

-Чинийхээр яагаад буруу гэж?

**-Сонгуулийн цаг хугацаа их ойртлоо. Солилоо гэхэд шинээр байгуулсан засаг сонгууль хүртэлх зургаахан сард юу ч хийж амжихгүй…?**

-Үнэхээр хариуцлагагүй байгаа бол цаг хугацаанаас үл хамаараад хариуцлагатай болгох ёстой. Би хувьдаа энэ Засгийн газрыг сайн ажиллаж байна гэж огтхон ч хэлж чадахгүй. Ч.Сайханбилэгийн Засгийн газар өнөөдөр ямар ажил хийх вэ гэхээсээ яаж удаан тэсэж тогтох вэ гэдгээ л бодож байна. Сонгууль ойртлоо, дараагийнх нь юу ч хийж амжихгүй гэдэг бол муу ажиллаж байгаа, юу ч хийхгүй Засгийн газрыг аварч, авч үлдэх шалтгаан болох учиргүй. Алдаа гаргаж амьдарсан амьдрал бахархмаар юмгүй ч, юу ч хийлгүй амьдарснаас дээр, илүү үнэ цэнэтэй гэж үг байдаг. Гэхдээ энэ Засгийн газрын хувьд юу ч хийхгүй байна уу, хийсэн нь үргэлж алдаа болоод байна уу гэдэг нь ялгарахгүй байгаа. Тийм учраас байгуулсан Засгийн газраа огцруулахаар гарын үсэг цуглуулж буй эрх баригчдын дотоодын улс төрд МАН оролцохгүйгээр, бие дааж улс төрийн тодорхой үнэлэлт дүгнэлт өгөхийг үгүйсгэхгүй.

**-Танайхан улс төрийн дүгнэлт өгнө гэж сүржин мэдэгдээд л алга болчихдог. Жишээ нь, "Дубайн гэрээ"-нд дүгнэлт өгнө гэж хэлээд хэдэн сар өнгөрч байна.**

**Ядаж намын ажлын хэсэг чинь дүгнэлтээ танилцуулах болоогүй юу?**

-"Дубайн гэрээ"-нд шүүмжлэлтэй хандаж байгаа. Одоо ч Ерөнхий сайдаас асуух зүйлс олон байна. Гэрээг байгуулснаас хойш хаврын чуулганд Ерөнхий сайд асуулт асуух гэхээр боломж олгохгүй байсан. Саяхан асуулаа. Тэр дагуу манай намын байгуулсан ажлын хэсэг нэмэлт байдлаар ажиллаж байгаа. Оюутолгойн уурхайд "Дубайн гэрээ"-ний дагуу зарим ажил эхэлж, олон улсын зах зээл, хөрөнгө оруулагчдын өмнө Монгол Улс ямар нэгэн байдлаар үүрэг хүлээчихлээ. Тэр тохиолдолд Тавантолгойн ажлын хэсгийнхэн шиг дотоодын улс төр болгон бужигнуулж улсаа хохироож, том төслүүдийнхээ нэр хүндийг дэлхийн зах зээл дээр унагаж болохгүй. "Дубайн гэрээ"-гээр өмнөх гэрээнийхээ заалтыг дордуулсан, баялгаа бүхлээр нь барьцаанд тавьсан, ямарч баримтгүй их хэмжээний мөнгөн дүнг хөрөнгө оруулалт гэж хүлээн зөвшөөрсөн гээд нарийвчилж судалж үзэхээр юм их бий. "Дубайн гэрээ"-гээр дэлхийн хэмжээний төслийн хувь заяаг шийдэж байгаа учраас энэ чиглэлийн яриа Монгол Улсаас хальж, Монгол Улсын нэрийг сайн муугийн аль нэгнээр дэлхийд гаргана. Тийм учраас ул суурьтай судлах, жинтэй дуугарах ёстой.

**-Тавантолгойн ажлын хэсэг гэснээс та энэ ордыг ашиглах тал дээр ямар байр суурьтай байгаа вэ. Энэ төсөл эдийн засгийн бүлэглэлүүдийн зодоон болчихлоо. Эхнийх дээр бол таныг эсрэг байна уу гэж харсан. Одоо Тавантолгойн шинэ төслийг УИХ-д танилцуулна гэж байна?**

-Засгийн газраас одоогоор УИХ-д орж ирсэн зүйл алга. Өмнөх төслийн тухайд Засгийн газрын төслийг УИХ-д оруулж ир гэсэн бичигт би гарын үсэг зурсан. Дөрөвдүгээр сард. УИХ-ын дарга, гурван дэд дарга зурсан. Харамсалтай нь, УИХ-ын бүх удирдлага гарын үсгээ зурсан ч, тэр төсөл УИХ-д орж ирэлгүй, замын дундаас буцчихсан. Ажлын хэсэг байгуулаад ажлын хэсгийн дарга нь ажлын хэсгийн шийдвэр мэтээр өөрийнхөө болон бусдын үгийг хэвлэлээр дайсаар яваад цаг хугацаа их алдсан. Тэгээд Засгийн газар ч төслөө буцааж татсан. Сураг сонсвол дахиад нэг төслийг гишүүд санаачилсан гэж дуулдаж байна. МАН бол том зургаа хардаг нам. Нэг улсад амьдарч, ашгийг нь улсаараа хүртэх том төслийг манайх авна, танайх тэрийг нь ав гэж зодолдоод байх бүлэг фракц манай намд байхгүй. Тийм ёс зүй, хүмүүжил, ухамсар манай намын гишүүдэд байхгүй, байж болохгүй гэдэг нь бараг тархинд нь кодлогдсон гэж болно. Тийм учраас тодорхой төсөл орж ирвэл үнэхээр эдийн засгийн өгөөж өгөх, Монгол Улсад ашигтай, монголчууд баялгийнхаа эзэн байж чадахаар бол дэмжинэ. Зарчмын байр суурь нь зөв тодорхойлогдсон байвал нэг хоногийн өмнө ч гэсэн Тавантолгойг эргэлтэд оруулах нь улсын эдийн засагт хэрэгтэй.

**-Хүн хэнтэйгээ хамтарч бизнес хийх нь чөлөөтэй. Гэхдээ гишүүдийн хөрөнгө орлогын мэдүүлгийг харахад бизнесээрээ нам дамжин хамтарсан, одоо улстөрд ид яваа олон хүн харагддаг. Үүнийг нэг талаар нам дамжсан бизнесийн бүлэглэл гэдэг байх. Тухайлбал, танд АН-ынхантай хамтарч байгуулсан компани, бизнес байдаг уу?**

-Байхгүй. Миний хувьд хүн амьтантай муудахгүй яваад байдаг нь нэг талаар нэг их бизнес хийгээд байдаггүйтэй холбоотой гэж боддог. Хүмүүс ихэнхдээ ашиг орлого, бизнесийн асуудлаас болж сайндаж муудаад байх шиг харагддаг. Надад тэгж бусадтай булаацалдаад байх бизнес байхгүй. Хар залуугаасаа төрийн ажил хийгээд явж байгаа л хүн. Янз бүрийн нэр хоч, мэдээ мэдээлэл заримдаа гарч л байдаг юм. Тэрэнд нь адгаад л, "би буруугүй, нэр төрөө цэвэрлэнэ, сэргээнэ" гэж гүйгээд байдаггүй. Хамгийн гол нь би өөрөө үнэнээрээ, үнэний төлөө явах нь чухал. Түүнээс бус, намайг гүтгэх ч юм уу, өдөж байгаа бусдын буруу үйлдлийн төлөө санаа зовоод л, татагдаж ороод л явах нь би өөрөө буруу үйлдэл хийж байгаатай бараг адилхан гэж үздэг.

**-Бас улс төрийн талцал гэж байна. Жишээ нь М.Энхболд У.Хүрэлсүхтэйгээ, Сү.Батболдтойгоо муудсан гэнэ гэдэг. Өнөөдөр МАН-ын лидерүүд дунд бодитой зөрчил байгаа юу?**

-Байхгүй. Ингээд хэлэхээр зарим хүн "намын дарга нь учраас худлаа хэлж байна л" гэх байх. Гэтэл бодит байдал дээр үнэхээр байхгүй юмыг би байхгүй гэхээс өөрөөр юу гэх билээ. Би түрүүн хэлсэн дээ, МАН-ынханд зөрчилдөөд байх эрх ашиг, бизнес булаалцалдаад байх ёс суртахуун байдаггүй гэж. Тэр зарчмаараа УИХ-ын сонгууль ойртох тусам манай намынхан улам нягтарч байгаа. Ганц МАН гэлтгүй, том зорилгынхоо төлөө улс дотроо намууд нь, улстөрчид нь нам дотроо эв нэгдлийг эрхэмлэх ёстой юм.



*1990 оноос хойш МАН-гүй, МАН-ын бүлэггүй УИХ гэж байгаагүй. Харин МАН-гүй, МАН-ын оролцоогүй Засгийн газар гэж байх үед ард түмний амьдрал яаж дордож, төрийн нэр хүнд, үнэ цэнэ хэрхэн дор ордгийг Монголын ард түмэн хоёр ч парламентын өнгөн дээр бодитой харлаа*

## "ХҮН ШИГ АМЬДРУУЛНА" ГЭСЭН АРДЧИЛСАН НАМЫНХАН ХҮЛЭЭЖ АВСНАА ИНГЭЖ УНАГАЖЭЭ

Монгол Ардын нам

МАН 2012 онд эдийн засгийн ийм үзүүлэлттэй Засгийн газар хүлээлгэж өгөв

Ардчилсан нам

2012 оны сонгуулиас хойш АН-ын хоёр дахь Засгийн газрын үед эдийн засаг ингэж өөрчлөгдөв

| | МАН | АН |
|---|---|---|
| Эдийн засгийн өсөлт | 17.5% | 2.5% |
| Гадаад валютын нөөц | 4.6 тэрбум ам.доллар | 1.4 тэрбум ам.доллар |
| Өрсөлдөх чадвар | 144 орноос 93-т | 140 орноос 104-т |
| Ам.долларын ханш | 1340 ₮ | 2000 ₮ |
| Инфляц | 12% | 3.4% |
| Чанаргүй зээл | 295.1 тэрбум төгрөг | 855.5 тэрбум төгрөг |
| Гадаадын шууд хөрөнгө оруулалт | 4.6 тэрбум ам.доллар | 10 сая доллар (Монгол банкны энэ оны 3-р улирлын тайлангаар) |
| Зээлжих зэрэглэл | B+ (Fitch) | B (Fitch) |
| Ажилгүйдлийн түвшин | 8,2% | 9.1% |
| Нэг хүнд ногдох өрийн хэмжээ | 1.4 сая төгрөг | 5.9 сая төгрөг |
| Хүний хөгжлийн индекс | 187 орноос 108-д | 187 орноос 103-т |
| Амьдралын чанарын үзүүлэлт | 192 орноос 72-т | 192 орноос 107-т |
| Нэг хүнд ногдох ДНБ | 3691 $ | 4116 $ |
| Бензиний үнэ (1 литр) | Дэлхийн зах зээлд нэг баррель нефтийн үнэ 111.67 ам.доллар байхад 1620 ₮ (1 баррель = 159 литр) | Дэлхийн зах зээлд нэг баррель нефтийн үнэ 41.75 ам.доллар байхад 1660 ₮ (1 баррель = 159 литр) |

**-Тухайлбал, таны том зорилго дотор 2017 он багтаж байгаа юу?**

-2016 оны сонгуулийн үр дүн л түүнийг хэлнэ дээ.

**-Би дараагийн Ерөнхийлөгчийн сонгуулийг л хэлж байна?**

-Ойлгоод л байна. Миний гол зорилго бол 2016 онд өөрөө УИХ-д орохоос илүүтэй МАН олонхи болох нь хамгийн чухал. Эс тэгвээс улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалд хүндрэл бэрхшээл ч бий болох нөхцөл байдалд хүрчихлээ. Ардчилал мандсан 1990 оноос хойш МАН-гүй, МАН-ын бүлэггүй УИХ гэж байгаагүй. Харин МАН-гүй, МАН-ын оролцоогүй Засгийн газар гэж байх үед ард түмний амьдрал яаж дордож, төрийн нэр хүнд, үнэ цэнэ хэрхэн дор ордгийг Монголын ард түмэн хоёр ч парламентын өнгөн дээр бодитой харлаа. Нэг нь 1996-2000, нөгөө нь 2012-2016 оны УИХ-ын үед. Өнөөдрийнхөөс илүү дордохыг хэн ч хүсэхгүй. Тийм учраас ирэх 2016 оны сонгуульд МАН амжилттай оролцох, улс орныхоо эдийн засгийг өөд татах нь нэг талаар нийгмийн захиалга. Нийгмийн энэ захиалгыг биелүүлэхийн төлөө зүтгэх нь МАН-ынхан, тэр дундаа намын даргын үүрэг учраас миний хувийн улстөрийн карьер, амбийц бол ёстой зуудугаар асуудал.

**-Сүүлчийн асуулт. Саяхэдхэн хоногийн өмнө Ерөнхий сайд Ч.Сайханбилэг ард түмэндээ хандаж үг хэллээ. Ерөнхий сайдыг их өөдрөг үг хэллээ гэж зарим хүн хэлж, зарим хэвлэлд бичиж байна. Тэгэхээр таны хэлж байгаа шиг тэгж их дордчихоогүй, бас дордохгүй юм биш үү?**

-Өөдрөг гэхээсээ өмнөх, өнгөрсөн дөрөвдүгээр сард хэлсэн үгээ л давтаж уншлаа гэж ойлгосон. Цаг хугацаа, орчин нь өөрчлөгдсөн болохоос өнгөрсөн дөрөвдүгээр сард хэлсэн үгнээс нь ялгарах онцгой содон зүйл байхгүй байна лээ. Ажил болгож чадаагүй өмнөх амлалтаа дахиад амлаж байгаа юм байна гэж ойлгосон. Дөрөвдүгээр сард, тэр үед хэлснээсээ нь өнөөдөр юу ажил хэрэг болсон, юу нь бүтээн байгуулалт болж эхэлсэн бэ гэхээр оножхэлэх зүйл үнэхээр байхгүй. Хүсвэл хэвлэлийнхэн та нар тулгаж хараарай. Нөгөө талаас, хэвлэл тэгж бичиж байна биш, хэвлэлд тэгж бичүүлж байна гэж би ойлгож байгаа. Засгийн газар хийсэн ажлаа хэвлэлээр сурталчлах ёстой. Харин хийгээгүй ажлаа мөрөөдөл болгож ярих, АН-ын сонгууль угтсан улстөрийг Монгол Улсын Засгийн газрын нэрээр сурталчлахыг би буруу гэж үзэж байгаа. Эдийн засаг дордсон, дордоогүй тухайд онолын маргаан өрнүүлж, олон тоо хэлэх нь үнэхээр илүүц. Хэрвээ эдийн засаг дордоогүй юм бол хотын захын гэр хорооллын зарим хэсэгт хоёр айл дундаа нэг талх авахгүй. Хотын дарга, АН-ын нийслэлийн дарга нь "ирэх хавар гэхэд Грек шиг хямарна" гэж ярихгүй. Хэрвээ ирэх онд илүү дордохгүй юм бол Засгийн газраас нэг ч бүтээн байгуулалтгүйгээр, төрийн албанаас 3000 хүнийг цомхотгохоор, цалин тэтгэврийг огт нэмэхгүй, харин ч 10 хувь хасахаар 2016 оны төсвийн төслийг оруулж ирэхгүй л байсан. УИХ дээр ярьж байгаад хүмүүсийг цомхотгож болохгүй, дотоод урсгал зардлаа танах замаар ажлыг байрыг нь хадгалж үлд гэж шийдвэр гаргасан. Үйл явдал, цаг хугацаа хамгийн үнэнийг хэлдэг гэдгийг улстөрчид тооцох хэрэгтэй.


МОНГОЛ ЗУРХАЙН "ТҮВДЭНПЭЛЖЭЭЛИН" ХИЙД

Огторгуйд орчигч одон гараг
Орчлонгийн амьтанд сайн
муугаар нөлөөлмүй
Огоорч авахыг мэдүүлэхийн тулд
Оддын зурхайг бичвэй би.

**Лувсандамбажанцан (1639-1704)**

...Хамаг амьтан амгалан хийгээд
амгалангийн шалтгаан лугаа
төгөх болтугай.
Хамаг амьтан зовлон хийгээд
зовлонгийн шалтгаан лугаа
хагацах болтугай...

**Бурханы сургаалаас**

**XVII ЖАРНЫ "МУУ НҮҮРТ" ХЭМЭЭХ**
**ГАЛ БИЧ ЖИЛИЙН**
**ЦАГ УЛИРЛЫН БИЧИГ**
**(2016-2017 он)**

Монгол зурхайн Түвдэнпэлжээлин хийдээс эрхлэв.
Улаанбаатар хот
2016 он

**МЭНДЧИЛГЭЭ**

Цаг хугацааны алтан хүрд "Муу нүүрт" хэмээх гал бичин жилийг зааж буй торгон мөчид, өргөн түмнийхээ амар мэндийг айлтгая. Та бүхэнтэйгээ өөрийн бүтээлээрээ 14 дэх жилдээ учран золгож байгаадаа баяртай байна. Гал бич жил монгол түмэнд маань эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг бэлэглэнэ гэдэгт итгэлтэй байна. Энэ өлзий дэмбэрэлтэй цаг мөчид Ялж төгс нөгчсөн, Түүнчилэн заларсан, Дайсныг дарсан, Үнэхээр төгсгөсөн Бурхан багшийн ханьцашгүй дараах сургаалыг амьдрал ахуйдаа хэвшүүлж, өөрөө жаргаж, өрөөлийг хайрлан хүндлэхийг сүсэгтэн олноосоо хичээнгүйлэн хүсч байна. Багшийн айлдсан Дармападагаас:

Сэтгэлийн гэмүүдээ шүүрдэн хаяад
Авралт гэгээрлээр ариутган сүлэгч
Энэ насандаа гэгээрлээр замнана
Айлтгүй, ирэх төрөлдөө ч ялагдашгүй дээшилнэ.
Занах уурлах чиний хилэн
Замын дайсныг цогцлоож босгоно
Заналгүй уучилж, өшилгүй мартвал
Зам цэвэршиж дайсан арилна
Хорслыг хорслоор ялдаггүй нь
Хорвоо ертөнцийн үнэн
Өшийг өршөөлөөр дардаг нь
Өнө мөнхийн зам
Элээх биеийг олж төрөгсөд

Ээлжээ дуусгаад буцах гийчид
Эргүүлж дуудах үхлээ санагч л
Элдэв хэрүүлтэй хөөцөлдөж зовохгүй
Амьдрах биехэн хэврэгийг санаж
Ассан тачаалаа атган татаж
Атгаг хүслээ хазаарлан чангааж
Авралд итгэж, шамдвал
Хар салхи алгадаад халирах
Хадан уул шиг буян батжиж
Хатуу, гашуунаар хорлогч шулам
Хаанаас ч элтэлж барахгүй болно

Хамба лам гэвш Ж.Гончигсүрэн

# ТӨВ АЙМАГТ 2016 ОНД УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Ирэх оны төсөвт хэдий шинэ хөрөнгө оруулалт хийхгүй байхаар тусгасан ч он дамжин хийгдэж байгаа томоохон төсөл арга хэмжээг бүрэн санхүүжүүлж дуусгахаар төлөвлөөд байгаа юм. Төв аймгийн хувьд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2013 оноос хойш он дамжин хийгдэж байгаа 10 төслийн санхүүжилтийг бүрэн шийдвэрлэж, 2016 онд бүтээн байгуулалтыг дуусгахаар төсөвлөсөн байна. Тухайлбал, 2012 оноос хойш Төв аймгийн Эрдэнэ суманд баригдаж байгаа 320 хүүхдийн ерөнхий боловсролын сургуулийн барилгын ажлын санхүүжилтэд 650 сая төгрөгийг төлөвлөснөөр эл бүтээн байгуулалтыг 2017 онд Улсын комисст хүлээлгэн өгөхөөр болжээ. Мөн Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургуулийн дэргэдэх 120 хүүхдийн дотуур байр, Зуунмод сумын Аврах, гал унтраах ангийн барилга, Лүн сумын төвийн бүрэн шинэчлэлийн бүтээн байгуулалтын ажлыг 2016 онд хийнэ. Төв аймгийн Батсүмбэр сумын Ахмадын асрамж, хөгжлийн төвийн өргөтгөлийг барилгыг бүрэн дуусгаж, ахмадуудаа хүлээн авахаар төлөвлөсөн аж. Мөн 2016 онд Төв аймгийн Бор нуур суманд 15 ортой эмнэлгийн барилга ашиглалтад орж, иргэдэд үйлчилж эхлэх нь. 2016 онд Төв аймагт улсын төсвөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгт найман тэрбум 913 сая төгрөгийг төсөвлөсөн бол Орон нутгийн хөгжлийн санд зургаан тэрбум 679 сая төгрөг хуваарилжээ.

***2016 онд хийх хөрөнгө оруулалтын задаргааг хүснэгтээс дэлгэрэнгүй харна уу***

***Өгөөмөр жаргал эдлэе гэвэл***
***Өр төлөөснөөс ангижиръя гэвэл***
***Өөрийн суудалд бусдыг зал***
***Бусдын оронд өөрийгөө зал***

*/Буддын сургаалиас/*

## ШИНИЙН НЭГНИЙ ӨГЛӨӨ ЗҮГ ЧИГЭЭ ХЭРХЭН ГАРГАХ ВЭ?

Ургасан жилд хүнийг ямар хүлэлд суусныг тооцохдоо эрэгтэй хүнийг "Гал"-аас эхлэн нар зөв, эмэгтэй хүнийг "Ус"-аас эхлэн нар буруу тойруулан билгийн насаар тоолж ямар хүлэлд хүрнэ тэр нь хүний тухайн жилд суух суудал болно. Шинийн нэгний өглөө зүг чигээ гаргахдаа суусан хүллийн хийморийн зүгт гарч буян хишгийн зүгээс ирдэг. Уг цаглабарт огторгуйн жил, хаврын тэргүүн сар, шинийн нэгний өдөр болон луу цагуудын хар нохойн амыг гарган тооцсон тул та дараах хүснэгтэнд бичсэний дагуу мөрөө гаргаж, шинэ жилийнхээ ажил амьдралыг эхлэнэ үү.

| | Унших тарни, гарах, ирэх зүг | Хүйс | Төрсөн он |
|---|---|---|---|
| ГАЛ | Хойд зүгт гарч, «Ум базар пад дагийни хум мама бизъяа суха» тарнийг 7-21 удаа уншаад, урд зүгээс ирнэ. | Эр | 1904, 1912, 1920, 1928, 1936, 1944, 1952, 1960, 1968, 1976, 1984, 1992, 2000, 2008, 2016 |
| | | Эм | 1908, 1916, 1924, 1932, 1940, 1948, 1956, 1964, 1972, 1980, 1988, 1996, 2004, 2012 |
| ШОРОО | Баруун хойт зүгт гарч, «Ум бадма дагийни хум мама бизъяа суха» тарнийг 7-21 удаа уншаад баруун урд зүгээс ирнэ. | Эр | 1903, 1911, 1919, 1927, 1935, 1943, 1951, 1959, 1967, 1975, 1983, 1991, 1999, 2007, 2015 |
| | | Эм | 1909, 1917, 1925, 1933, 1941, 1949, 1957, 1965, 1973, 1981, 1989, 1997, 2005, 2013 |
| ТӨМӨР | Баруун урд зүгт гарч, «Ум радна дагийни хум мама бизъяа суха» тарнийг 7-21 удаа уншаад баруун зүгээс ирнэ. | Эр | 1910, 1918, 1926, 1934, 1942, 1950, 1958, 1966, 1974, 1982, 1990, 1998, 2006, 2014 |
| | | Эм | 1910, 1918, 1926, 1934, 1942, 1950, 1958, 1966, 1974, 1982, 1990, 1998, 2006, 2014 |
| ОГТОРГУЙ | Зүүн хойд зүгт гарч, «Ум пагма дагийни хум мама бизъяа сууха» тарнийг 7-21 удаа уншаад баруун хойд зүгээс ирнэ. | Эр | 1909, 1917, 1925, 1933, 1941, 1949, 1957, 1965, 1973, 1981, 1989, 1997, 2005, 2013 |
| | | Эм | 1903, 1911, 1919, 1927, 1935, 1943, 1951, 1959, 1967, 1975, 1983, 1991, 1999, 2007, 2015 |

## *2016 онд хийх хөрөнгө оруулалтын задаргаа*

*(сая төгрөгөөр)*

| № | Хөрөнгө оруулалтын төсөл, барилга байгууламжийн нэр | эхлэх | дуусах | Төсөв өртөг | 2016 онд санхүүжих дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | Эрдэнэ сумын 320 хүүхдийн сургуулийн барилга | 2012 | 2017 | 2668.7 | 650.0 |
| 2 | Батсүмбэр сумын сургуулийн 120 хүүхдийн дотуур байрны барилга | 2013 | 2016 | 1200.0 | 850.0 |
| 3 | Аймгийн хөгжимт драмын театрын барилга, 800 хүний суудалтай (Зуунмод сум) | 2014 | 2017 | 9500.0 | 1500.0 |
| 4 | Баянцагаан сумын соёлын төвийн барилга | 2015 | 2017 | 1.000.0 | 750.0 |
| 5 | Аврах, гал унтраах ангийн барилга (Зуунмод сум) | 2013 | 2016 | 2.700.0 | 105.0 |
| 6 | Төв аймгийн шинэ суурьшлын бүсийн хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг сайжруулах | 2014 | 2016 | 3.940.0 | 1.061.5 |
| 7 | 14 аймгийн төвд (үүний дотор Төв аймгийн төв) 1000 айлын орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ | 2013 | 2016 | 62.000.0 | 13.971.7 |
| 8 | 16 аймгийн сумын төвийн шинэчлэл төсөл (үүний дотор Төв аймгийн Лүн сум) | 2014 | 2016 | 80.000.0 | 11.119.0 |
| 9 | Батсүмбэр сумын Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төвийн нөхөн сэргээх сувиллын барилга | 2014 | 2016 | 5.591.1 | 1.500.0 |
| 10 | Батсүмбэр сумын Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төвийн байрны өргөтгөл | 2014 | 2016 | 3.398.5 | 849.6 |
| 11 | GPS-ийн (GNSS) байнгын ажиллагаатай станц байгуулах. Төв зэрэг 18 аймаг | 2013 | 2016 | 899.8 | 252.0 |
| 12 | Хөшигийн хөндийн Олон улсын шинэ нисэх буудал барихтай холбогдуулан Монголын талын гүйцэтгэх төсөл, арга хэмжээ болон авто зам, гудамж төсөл | 2012 | 2016 | 122.874.2 | 36.975.1 |
| 13 | Туулын голын модон гүүрний засвар. (Төв, Алтанбулаг сум) | 2013 | 2016 | 100.0 | 22.8 |
| 14 | Эмнэлгийн барилга 15 ортой, (Төв, Борнуур сум) | 2012 | 2016 | 1084.6 | 34.9 |

| | Унших тарни, гарах, ирэх зүг | Хүйс | Төрсөн он |
|---|---|---|---|
| УС | Урд зүгт гарч, «Ум гарма дагийни хум мама бизъяа суха» тарнийг 7-21 удаа уншаад хойт зүгээс ирнэ. | Эр | 1908, 1916, 1924, 1932, 1940, 1948, 1956, 1964, 1972, 1980, 1988, 1996, 2004, 2012 |
| | | Эм | 1904, 1912, 1920, 1928, 1936, 1944, 1952, 1960, 1968, 1976, 1984, 1992, 2000, 2008, 2016 |
| УУЛ | Баруун хойд зүгт гарч «Ум будда дагийни хум мама бизъяа суха» тарнийг 7-21 удаа зүүн хойд зүгээс ирнэ. | Эр | 1907, 1915, 1923, 1931, 1939, 1947, 1955, 1963, 1971, 1979, 1987, 1995, 2003, 2011 |
| | | Эм | 1905, 1913, 1921, 1929, 1937, 1945, 1953, 1961, 1969, 1977, 1985, 1993, 2001, 2009 |
| МОД | Хойд зүгт гарч, «Ум базар дагийни хум мама бизъяа суха»тарнийг 7-21 удаа уншаад зүүн зүгээс ирнэ. | Эр | 1906, 1914, 1922, 1930, 1938, 1946, 1954, 1962, 1970, 1978, 1986, 1994, 2002, 2010 |
| | | Эм | 1906, 1914, 1922, 1930, 1938, 1946, 1954, 1962, 1970, 1978, 1986, 1994, 2002, 2010 |
| ХИЙ | Урд зүгт гарч, «Ум базар пад дагийни хум мама бизъяа суха»тарнийг 7-21 удаа зүүн урд зүгээс ирнэ. | Эр | 1905, 1913, 1921, 1929, 1937, 1945, 1953, 1961, 1969, 1977, 1985, 1993, 2001, 2009 |
| | | Эм | 1907, 1915, 1923, 1931, 1939, 1947, 1955, 1963, 1971, 1979, 1987, 1995, 2003, 2011 |

НАЙМАН ХӨЛӨЛ

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Буян хишиг | Цог хийморь | 5 ад чөтгөр | Цог хийморь | Буян хишиг | Бие тасрах | 5 ад чөтгөр | Бие тасрах | Буян хишиг |
| Эм | ХИЙ | Бие тасрах | Амь | ГАЛ | 5 ад чөтгөр | Хорлол | ШОРОО | Цог хийморь |
| Шулмас | Амь | Хорлол | Хорлол | Эм | Шулмас | Амь | Шулмас | Эм |
| Эм | Амь | Хорлол |  | | | Бие тасрах | 5 ад чөтгөр | Цог хийморь |
| Буян хишиг | МОД | Шулмас | | | | Шулмас | ТӨМӨР | Буян хишиг |
| Бие тасрах | Цог хийморь | 5 ад чөтгөр | | | | Эм | Хорлол | Амь |
| Шулмас | Хорлол | Амь | Амь | Эм | Шулмас | Хорлол | Шулмас | Эм |
| Бие тасрах | УУЛ | Эм | Цог хийморь | УС | Хорлол | 5 ад чөтгөр | ОГТОРГУЙ | Амь |
| Буян хишиг | 5 ад чөтгөр | Цог хийморь | 5 ад чөтгөр | Буян хишиг | Бие тасрах | Цог хийморь | Бие тасрах | Буян хишиг |



Улс төр, цаг үе,нийгэм мэдээллийн чөлөөт сэтгүүл
ТОР АНАЛИЗ
Үнэний талд

# ГАЗРЫН ГҮНИЙ ДУЛААНААР ХАЛААЖ 130–160 САЯ ТӨГРӨГ ХЭМНЭДЭГ



Төв аймгийн Зуунмод сумын бүрэн дунд IV сургууль, Ирээдүй цогцолборын Эрдмийн далай цэцэрлэгийн /IV баг/ халаалтыг 2012 онд Монголд анх удаа газрын гүний дулаанаар шийджээ. М.Энхболд Монгол Улсын Шадар сайдаар ажиллаж байх үедээ энэхүү шинжлэх ухааны үндэслэлтэй инноваци төслийг дэмжиж, монгол-герман инженерүүд хамтран хэрэгжүүлсэн юм байна. Бид IV сургуулиар очиж, төслийн үр дүнтэй танилцсан юм. Тус сургууль 370 гаруй суралцагч, 35 багш ажиллагсадтай. Аймагтаа XII анги төгсч байгаа сурагчид нь сургалтын амжилтаараа тэргүүлдэг учраас Зүүндэлгэр сумын нутаг дэвсгэрт орших тус сургуульд аймгийн төвөөс 120-иод хүүхэд хичээлд явдаг юм байна. Дээр нь Зүүндэлгэр сумын 100 гаруй хүүхэд, хажуу Сэргэлэн, Баян-Өнжүүл, Баянцагаан сумаас 50 орчим хүүхэд ирж суралцдаг ажээ.

Сургуулийн захирал Ө.Дуламсүрэн, “манай сургуульд 2013 онд БСШУЯ-ны 380 сая төгрөгийн барилгын их засвар хийсэн. Түүнээс

### МАХБОДЫН ЗУРХАЙН ҮР ТҮҮНИЙ ЗАСАЛ

Бурханы шашины үндсэн онол нь амьтныг хайрлах, энэрэх, туслах үзэл юм. Энэ зарчмыг бүхий л судар номондоо сургадаг. Зурхайн судар бичигт ч ялгаагүй хүнийг айлгах, гарцаагүй үнэн гэж хүнд тулгах, харамж мөнгө нэхэх, яршиг төвөг удах зэргийг хатуу хориглодог. Нэг үгээр хэлбэл бэрийн зурхайд сайн зүг нь давах боломжгүй цасанд хучигдсан даваа байхад давахыг шаардаж хүн амьтанд төвөг учруулахыг эс зөвшөөрнө. Харин түүний оронд зүгийн заслын ном судар айлтгаж засаад өөр зүгээс ирүүлдэг уян хатан сайхан онолтой.

Бас хүмүүс өөрийн сүсэг бишрэл, хөрөнгө чинээ, орон зай, цаг үедээ тохируулан гүрэм номоо хийлгэхийг цаг ямагт мэргэд сануулж байдаг. Хамгийн гол нь сэтгэл. Сэтгэлээрээ буян номонд хандаж, эргэл мөргөл хийж, Бурхан багшийн айлдсан Таравчинбо, Сандуйн жүд, Алтангэрэл, Жадамба, Доржзодов зэрэг хөлгөн судруудыг хэр чадлаараа уншуулж байвал түүнээс илүү буян гэж үгүй гэж судар бичигт номлодог.

Мөн хурал номын газар гүрэм засал хийлгэхийн зэрэгцээ өөрийн биеэрээ буян хийж байхыг уриалдаг юм. Тухайлбал Маани, Мигзэмийг амны уншлаганд авах, ядарсан зүдэрсэн нэгэнд өглөг өгөх, баярлуулах, хүмүүст талархал илэрхийлэх, амьтны амийг хайрлах, ой мод, уул усаа хүндэлж зүй бусаар ашиглахгүй байх, хүмүүст хор хөнөөлтэй хүнсний бараа бүтээгдэхүүн зарахгүй байх зэрэг бүхий л хүн болон амьтан, эх байгалд хор хөнөөлгүй сэтгэлийн үйл хөдлөлийг буян гэдэг.

Ялангуяа ядууст өглөг өгөх нь том гүрэм засалд тооцогддогийг танд дуулгахад таатай байна.

### СУУДЛЫН ЦЭЭР

**МОД** - Туулай, илжиг, шувуу, бар ирвэсний мах идэх, хутга мэс, худалдан авах, хэрүүл тэмцэл хийх, хөх эд, ангийн арьс авах, мод огтлох зэрэг үйлүүдийг тэвч. Бурханд амь нас, амьдрал ахуйгаа даатгах, алт мөнгөөр гоёж чимэглэх, байшингийн суурь шинээр тавихад сайн. Элэг цөс, гэдэс, хөл өвдөх, яр шарх гарахаас сэрэмжил. Хутга, мэсний аюулаас болгоомжил. Тээрэм босгох, тангараг өргөх үйлэнд муу.

**ГАЛ** - Зээрд халиун гүү авах, улайн үйл хийх, оршуулганд явах, морь малын арьс үс, улаан өнгийн эд хүнээс авах зэргийг тэвч. Зун, намрын цагт толгой цээж өвдөхөөс болгоомжил. Онгод тахих, бэр, цэргийн үйл, хулгай дээрмийн үйлүүдэд бүү оролц. Галаа тахиулж бай.

хойш тасралтгүй газрын гүний дулаанаар сургуулиа халааж байгаа. Нүүрс огт түлэхгүй байгаа. Энэ технологийн эхлэлийг Монгол Улсад анх удаа, сонгогдсон аймагтаа тавьж өгсөнд сургуулийн удирдлагын зүгээс М.Энхболд гишүүнд талархаж явдаг. Манай сургууль утаа униаргүй болж, ажиллах хүчний зардал, түлээ нүүрсний зардлаа хэмнэж чадсан. Халаалтын зардлаа тооцож үзэхэд түүхий нүүрс шатаадаг байхдаа 2013 онд сардаа 13 сая төгрөг төлдөг байсан. Тэр хэмжээгээр тооцоход 2014 онд 14 сая, 2015 онд 16-17 сая төгрөгийг нүүрсний зардалд төлөхөөр байсан. Бид газрын гүний дулааныг ашиглаж эхэлснээр жилд цахилгааны зардлыг хасахад 130-160 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллаж байгаа. Сургуулийн тасалгааны температур 17-21 градусын хооронд хэлбэлздэг. Одоо барилга байгууламжийнхаа дулаан алдагдлыг бууруулж чадвал илүү дулаан, тохь тухтай орчинд хүүхдүүд маань сурч боловсрох боломжтой болно” гэлээ.

Улсын хэмжээнд газрын гүний дулаанаар халдаг ганцхан байдаг тус сургуульд сүүлийн жилүүдэд японууд ирж туршлага судлах болжээ. Мөн БСШУЯ, сургууль, эмнэлэг, албан байгууллагын албаны хүмүүс, хувь хүмүүс ирж газрын гүний дулаанаар оффис, хаусаа байгальд хоргүй, эко аргаар дулаахан байлгах энэхүү технологийг сураглаж ирдэг болсон юм байна. Тус сургуулийн бас нэг ялгарах онцлог нь өөрийн гэсэн цэвэрлэх байгууламжтай. Өнгөрсөн 2014 онд Барилга, хот байгуулалтын яам, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар цэвэрлэх байгууламжтай болжээ. Ирэх жил “Хааны эрэлд” цэргийн хамтарсан сургуулийн хүрээнд явуулах үйл ажиллагааны хүрээнд 75 хүүхдийн дотуур байр



бариулахаар болжээ. Түүнчлэн өөрийн гэсэн цэвэр усны байгууламжтай болсон учраас хэрэглээний халуун устай болжээ. Одоо төсөв хөрөнгөө шийдүүлээд сургуулийнхаа гадна талыг хөөсөн хавтангаар дулаалчихвал М.Энхболд даргын эхлүүлсэн ажлын үр дүн бүрэн дүүрэн гарах гээд байна гэж Ө.Дуламсүрэн захирал хэллээ.

Эрдмийн далай цэцэрлэгээр очлоо. Эмнэлгийн узельд доголдол гарсан учраас одоогоор газрын гүний дулааны хажуугаар түүхий нүүрс бага зэргийг түлж байгаа юм байна. Харин цэцэрлэг газрын гүний дулаанаа дангаар нь ашиглаж байв. Цэцэрлэгийн мэдээллийн самбарт байршуулсан төсөв зарлагын тайланд түлээ, түлшний зардал “0” гэж бичжээ. Газрын гүнд 40 гаруй цооног ухаж, доороос 5 градус дулаантай ус насосоор татаад, түүнийгээ цахилгаанаар 60 градус хүртэл халаадаг. Халуун ус тасалгаанд 17-21 градусын халуунтай очиж, паараар гүйж сургууль, цэцэрлэг, эмнэлгийг дулаацуулдаг ажээ.

**ШОРОО** - Шар толгойтой хонь авах, модны үйл хийх, газрын үүд хаах, ам авч тангараг тавих, байшингийн суурь тавих, эмгэн хүний малгай, шавар эдлэл авах, газар шороо ухах, хад чулуу булгалах зэрэг үйлүүдийг тэвч. Төмрийн үйл хийхэд сайн. Чимэг зүүх, цас мөс хайлах цагт сэрэмжтэй бай. Оршуулганд явахгүй бол сайн. Дарханы үйл сайн биш.

**ТӨМӨР** - Бухны мах идэх, төмөр хайлуулах, мод таслах, тангараг тавих, ан амьтан гөрөөлөх, хүүхэд анх хөлд оруулах, хүүр түлэх, хутга мэс авах, чоно нохойд ноцуулсан амьтны мах идэх зэрэг үйлүүдийг цээрлэ. Уушиг, зүрх гэдэсний өвчнөөс сэргийлж, ус хөлдөх үед анхаар. Хулгай дээрэм илрүүлэхэд сайн.

**ОГТОРГУЙ** - Нохой, цагаан морь авах, их хүнтэй гэрээ хэлэлцээр байгуулах, гэр байшин дээвэрлэх, гөрөөсний мах идэх, шар өнгийн эд авах, өндөрт авирах зэргийг цээрлэ. Толгой гар, хөл өвдөх, сэтгэл тавгүйтэх, нойр муудах болон газар хөлдөх үед болгоомжил. Огторгуйн үүдийг хаалга. Хараал адыг хариулахад сайн. Сүм байгуулах, балгадын суурь тавих, их хэмжээтэй нүүдэл хийхэд сайн биш.

**УС** - Гахай, загасны мах идэх, худаг малтах, хар зүсмийн мал хийгээд хар өнгийн хуучин эд авах, булаг шанд хөндөх, их гол мөрөн гатлах, тангараг тавих, суваг шуудуу малтах зэрэг үйлүүдийг тэвч. Бурхан сахиусаа тахих, газар лусаа аргад. Бөөр сав, гэдэс өвдөхөөс болгоомжил, зуны эхэн сардаа хянуур бай. Төмрөөр элдэв зүйл хийхэд сайн. Нүүдэл суудал хийхгүй.

**УУЛ** - Үхрийн худалдаа хийх, хуварга хүнээс таваг аяга авах, тахилын эд авах, газар ус хөндөх, өндөр ууланд авирах, хар малгай өмсөх, ан гөрөө хийх, шороо чулууны үйл зэрэг үйлүүдийг тэвч. Байшингийн суурь тавих, үс унах, яр шарх гарах, бөөр болон шар усны өвчнөөс сэрэмжил. Идээ ундаанаас бузартах болон өвс шарлах газар хөлдөхөд хянуур бай. Адуу, үхэр сургах, гэр бүрэхэд сайн. Худалдаа хийхэд сайн биш.

**ХИЙ** - Баруун зүгээс мах авах, галзуу хүн, хуварга хүнээс аяга таваг авах, өвчилсөн малын мах идэх, барын арьс авах, хуяг алт эрдэнийн зүйл авах, хэрүүл шуугиан хийх, тарни тоолох, хатуу үйл, согтууг номхотгох, модны зүйл, шар өнгийн эд авах, чимэг, хөгжмийн зэмсэг авах, модон тээрэм босгож байгуулах зэрэг үйлүүдийг



# Х.Эрдэнэхуяг: ГАЗРЫН ГҮНИЙ ДУЛААН ЦАХИЛГААН ХАЛААГУУРААС ХАМААГҮЙ ХЭМНЭЛТТЭЙ

*Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвийн дэд дарга асан Х.Эрдэнэхуягтай газрын гүний дулааныг халаалтад ашиглах талаар ярилцлаа.*

**-Төв аймгийн эмнэлэг, сургуулийг газрын гүний дулаан халааж байна. Энэ технологийг анхлан Монголд оруулж ирсэн хүн нь таныг гэж дууллаа. Эндээс ярилцлагаа эхлье?**

-Энэ бол улсын төсвийн хөрөнгө зарж хийсэн маш том ажил. Анх удаа газрын гүний дулааныг ашиглаж томоохон объектын халаалтыг шийдсэн юм. Төв аймгийн Зүүн дэлгэр багийн сургууль, цэцэрлэг хоёрынх нь дунд нэг уурын зуух байсан. Уурын зуухтай байх үед тэр үеийн халаалалтандаа сургууль нь нэг сард 13 сая, цэцэрлэг нь 6-7 сая төгрөг өгч байсан. Түүхий нүүрс, уурын зуухыг халж эко, сэргээгдэх технологиор халаалтыг нь шийдье гэсэн учраас ашиг хараагүй. “Монг-Угсралт” гэдэг компани угсарч тоног төхөөрөмжийг нь Швейцариас авчирсан. Швейцарь технологи бол хамгийн мундаг нь. Нэгд Монголд шинэ технологи оруулж ирье. Хоёрт, техникийн үр өгөөжийг нь харъя гэж л бодсон.

---

## XVII жарны “Муу нүүрт” хэмээх гал бич жилийн таны төөрөг махбодын зурхайд

***Таван махбодын зурхайн үрийг зурсан Монгол зурхайн Түвдэнпэлжээлин хийдийн зурхайч Д.Цолмон***

### ХУЛГАНА ЖИЛТЭН



*Хулгана жилтнүүд бар өдөр мягмар гаригт хийморийн буулттай. Хулган жилтний ивээл жил ургаж байна. 1936,1972, 2008 оны хулгана жилтэнүүд жилийн гүмэг засуул, 1924 оны эр, эм; 1948, 1972, 1996 оны эрэгтэй, 1936, 1960, 1984, 2008 эмэгтэйчүүд суудлын Нашидүрсүмийн засал хийлгэх. 1924, 1948, 1972, 1996 оны эрэгтэйчүүд, 1936, 1960, 1984, 2008 эмэгтэйчүүд усан суудлын, 1936, 1960, 1984, 2008 оны эрчүүд, 1924, 1948, 1972, 1996 эмэгтэйчүүд гал суудлын, мөн суудлын гүмэг засуулах, 1984 оны хулгана жилтэн 33-ны мөчлөгийн засал хийлгэнэ. Гомбо 33 удаа уншуулна.*

### ҮХЭР ЖИЛТЭН



*Үхэр жилтнүүд усан гахай өдөр пүрэв гаригт хийморийн буулттай тул хийморийн дарцаг хийсгэ. 1913, 1937, 1961, 1985, 2009 эмэгтэйчүүд, 1925, 1949, 1973, 1997 оны эрэгтэйчүүд суудлын нашидүрсүмийн засал хийлгэх. 1913, 1937, 1961, 1985, 2009 эрчүүд хий суудлын засал хийлгэ. 1913, 1937, 1961, 1985, 2009 эмэгтэйчүүд уул суудалд, 1925, 1949, 1973, 1997 оны эрчүүд огторгуйд, 1925, 1949, 1973, 1997 оны эмэгтэйчүүд шороон суудалд суусан бөгөөд суудлын тусгай засал хийлгэ.*

### БАР ЖИЛТНҮҮД



*Бар жилтнүүд төмөр бич өдөр бямба гаригт хийморийн буулттай байна. Хийморийн дарцаг хийсгэнэ. Бар жилтнүүд их харш жилийн засал хийлгэнэ. 1926, 1962, 1998 оны бар жилтнүүд мэнгэ голлосоны засал хийлгэх. 1914, 1938, 1962, 1986, 2010 оны бар жилтэй эрэгтэй, эмэгтэйчүүд модон суудалд суусан байна. Жилээ угтаж жилийн засал хийлгэнэ. 1926, 1962 оны бар суудлын гүмэгийн засал хийлгэнэ. Жагнаггадог уншуулах.*

**-Үр ашгийг нь тооцож үзсэн үү?**

-Газрын гүний технологиор халаадаг болсноос хойш цахилгаан энергийн төлбөртөө сургууль нь сард нэг сая, цэцэрлэг нь 300-400 мянган төгрөг өгч байгаа. 2009 онд цэцэрлэг нь, 2011 онд эмнэлэг, сургууль нь ашиглалтад орсон. Сургууль, цэцэрлэгт үр ашгийн тооцоо хийж үзсэн. Тэгэхэд сургууль халаалтын улиралд нийтдээ 91 орчим сая төгрөг төлдөг байсан. Гүний дулаан хэрэглэж эхэлснээр цахилгааны төлбөрт жилдээ 5.6 саяыг л төлж байна. Өөрөөр хэлбэл, жилдээ 85.4 сая төгрөгийг хэмнэж байна. Ингээд ажилласан хугацаагаар нь тооцож үзэхэд 340 саяын цэвэр хэмнэлттэй байна. Нөгөө талаар байгальд хаядаг хорт бодисууд, бүтээгдэхүүний хаягдал байхгүй боллоо гэсэн үг. Дээр нь биднийг анх очиход уурын зууханд дөрвөн галч, нэг механик ажиллаж байсан. Бас нүүрсээ холоос тээвэрлэнэ, уурын зуухны ашиглалтын зардал нэмэгдэнэ. Одоо энэ бүхнийг, хүмүүсийн цалинг хэмнэж чадлаа гэсэн үг.

**-Технологийн ажиллах зарчмыг тайлбарлахгүй юу?**

-Дэлхийн бөмбөрцгийн аль ч гадаргууд очоод өрөмдөхөд гаднаа ямар ч температуртай байсан 2.5-3 метрээс доошоо тогтмол температуртай. Дэлхий гадаргуугаасаа нарны, дотроосоо цөмийн дулааны тэжээл авч байдаг. Газрын дулааны насос нь нам температурт буцламтгай ажлын биетэй байдаг. 5-6 градустай ажлын биеийг насос нь 8-12 дахин өсгөж халаана. Доороос 8 градус дулаан ирвэл 80 градус болгож халаадаг. Ерөнхий ажиллах зарчим энэ.

**-Анх энэ технологийг суурилуулахад ямар зардал гарсан бол?**

-М.Энхболд дарга Шадар сайдаар ажиллаж байхдаа улсын төсөвт хөрөнгө мөнгийг нь суулган дэмжлэг үзүүлж тойрогтоо шинэ технологи нэвтрүүлье гэж хэлсэн юм. Нийтдээ 1.4 тэрбум төгрөгөөр хийгдсэн ажил. Швейцариуд бол хамгийн доод тал нь 20 жил эвдрэлгүй ажиллана гэсэн. Швейцариас авсан насосууд Хятад, Солонгост 30-40 жил зүгээр ажиллаж байна лээ. Энэ технологи цахилгаан халаагуурыг бодвол хамаагүй хямд, хэмнэлттэй. Төхөөрөмж нь өөрөө маш бага цахилгаан иддэг. Хоёр давхар хаус барих гэж байгаа бол кВт-аа тооцоод захиалаад авчихна.

**-Сул тал байна уу?**

-Нэг л сул тал бий. Сургуульд энэ технологийг тавихад 41 цооног ухаж байна. 41 цооног маань бие биеэсээ хааш хаашаа найман метр зайтай байх ёстой. Доошоо 100 метр ухна. Тийм учраас маш том хэмжээний талбай хэрэгтэй болдог. Надтай үүнийг асуух гэж барилгын нөхдүүд их ирж уулздаг. ТЭЦ-III-ын урд хороолол барих гээд цахилгааныг нь яаж шийдэх вэ гээд бас ирсэн. Энэ аргаар хийе гэсэн ч цооног ухах талбай байгаагүй л дээ. Есөн давхар байшин барилгыг халаая гэвэл барилгатайгаа адил дөрвөн ийм газарт цооног ухах хэрэгтэй болно. Талбай их орно.

**ТУУЛАЙ ЖИЛТЭН**



*Гал могой өдөр даваа гаригт хийморийн буулттай тул хийморийн дарцаг хийсгэнэ.*

*1963, 1999 оны туулай жилтэнгүүд жилийн гүмэг засуулах, 1927, 1951, 1975, 1999 оны эрэгтэй, эмэгтэйчүүд суудлын тусгай засал хийлгэх. 1915, 1939, 1963, 1987, 2011 оны эрэгтэйчүүд уул суудалд 1915, 1939, 1963, 1987, 2011 эмэгтэй хий суудалд, 1927, 1951, 1975, 1999 оны эрэгтэйчүүд шороон суудалд, 1927, 1951, 1975, 1999 эмэгтэйчүүд огторгуй суудалд суусан тул тус тусын заслыг хийлгэ*

*ЛУУ ЖИЛТЭН*



*Луу жилтнүүд модон бар өдөр мягмар гаригт хийморийн буулттай тул хийморийн дарцаг хийсгэнэ. Луу жилтэнгүүдийн ивээл жил ургаж байна.*

*1916, 1940, 1964, 1988, 2012 оны эрэгтэйчүүд усан суудлын, 1928, 1952, 1976, 2000 эмэгтэйчүүд усан суудлын, 1916, 1940, 1964, 1988, 2012 эмэгтэйчүүд гал суудлын, 1928, 1952, 1976, 2000 оны эрэгтэйчүүд гал суудлын суудлын засал хийлгэ. 1976 оны луу суудлын гүмэг засуул.*

**МОГОЙ ЖИЛТЭН**



*Усан гахай өдөр пүрэв гаригт хийморийн буулттай тул хийморийн дарцаг хийсгэнэ.*

*Усан гахай жилтэнгүүд бага харшийн засал хийлгэнэ. 1917, 1953, 1989 оны могой жилтнүүд мэнгэ голлосны засал хийлгэ. 1917, 1941, 1965, 1989, 2013 оны эрэгтэйчүүд огторгуй суудлын, 1917, 1941, 1965, 1989, 2013 эмэгтэйчүүд шороон суудлын, 1929, 1953, 1977, 2001 оны эрэгтэйчүүд хий суудлын, 1929, 1953, 1977, 2001 эмэгтэйчүүд уул суудлын засал хийлгэ.*

*Жилээ угтаж засал хийлгэнэ. 1953 оны могой жилтэн суудлын гүмэгийн засал хийлгэх. Жанаггагдог уншуулах.*


МОНГОЛ УЛСЫН 24 ДЭХ ЕРӨНХИЙ САЙД
2005 ОН
2007 ОН
М. ЭНХБОЛДЫН ТЭРГҮҮЛСЭН
"ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЛИЙН"
ЗАСГИЙН ГАЗАР
50.000
Ажлын байр
69.000
Ажлын байр
2005-2007 ОНУУДЫН ХООРОНД НИЙТ 19.000 ШИНЭ АЖЛЫН БАЙР БИЙ БОЛСОН.
+19.000
Шинээр ажлын байр
- Эмхлэн байгуулагдсан огноо: 2006.01.05
- Ажилласан хугацаа: 1 жил 10 сар
https://www.facebook.com/M.Enkhbold


МОНГОЛ УЛСЫН 24 ДЭХ ЕРӨНХИЙ САЙД
М. ЭНХБОЛДЫН ТЭРГҮҮЛСЭН
"ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЛИЙН" ЗАСГИЙН ГАЗАР
2005 ОН
2007 ОН
2015 ОН
1221 ТӨГ
АМ ДОЛЛАРЫН ХАНШ
1165 ТӨГ
АМ ДОЛЛАРЫН ХАНШ
1993 ТӨГ
АМ ДОЛЛАРЫН ХАНШ
НЭГ АМ ДОЛЛАРЫН ХАНШ 2005 - 2007 ОНУУДЫН ХООРОНД (-56) ТӨГРӨГӨӨР БУУРСАН.
- Эмхлэн байгуулагдсан огноо: 2006.01.05
- Ажилласан хугацаа: 1 жил 10 сар
https://www.facebook.com/M.Enkhbold

# М.ЭНХБОЛДЫН ЗАСГИЙН ГАЗАР ЦАЛИН ТЭТГЭВРИЙГ ХАМГИЙН ӨНДӨР ХУВИАР НЭМЖЭЭ

М.Энхболд 2006-2007 онд Монгол Улсын 24 дэх Ерөнхий сайдаар томилогдож, Үндэсний эв нэгдлийн Засгийн газрыг тэргүүлсэн билээ. 2000 оноос хойш өнөөдрийг хүртэл ажиллаж буй Засгийн газруудаас М.Энхболдын тэргүүлсэн Үндэсний эв нэгдлийн танхим түүхэнд хамгийн өндөр хувиар цалин тэтгэврийг нэмжээ. Тухайлбал, цалин, тэтгэврийг Н.Энхбаярын Засгийн газар 95, Ц.Элбэгдоржийн Засгийн газар 7.5 хувь, М.Энхболдын Засгийн газар 230 хувь, С.Баярын Засгийн газар 20 хувь, С.Батболдын Засгийн газар 100 хувь, Н.Алтанхуягийн Засгийн газар долоон хувиар нэмсэн байна. Ч.Сайханбилэг Ерөнхий сайдын Засгийн газар одоогоор цалин, тэтгэврийг огт нэмээгүй яваа юм.

М.Энхболдын Засгийн газар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 42500 байсныг 90 мянга, төрийн албан хаагчдын цалин 92 мянган төгрөг байсныг 250 мянга болгон нэмэгдүүлсэн. Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагчдын цалинг гурав дахин нэмэгдүүлсэн анхны Ерөнхий сайд болж түүхэнд тэмдэглэгдэн үлджээ.

Үндэсний эв нэгдлийн Засгийн газар бүрэн тэтгэврийн доод хэмжээ 32 мянга байсныг 97500 төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 20 мянга байсныг 45 мянган төгрөг, дундаж тэтгэвэр 37 мянга байсныг 79 мянга болон нэмэгдүүлж байжээ. Дунджаар тэтгэврийг 50-150 хувиар нэмэгдүүлж чадсан байна. Мөн залуу гэр бүлд олгодог 500 мянга, сар бүр хүүхдийн мөнгө олгож, жил бүр Хөдөлмөрийн баатар, Ардын цолтон ахмад дайчдад 200 мянга, гавьяат цолтонд 100 мянган төгрөгийн тэтгэмж олгохыг санаачилж, хэрэгжүүлсэн.

Үе үеийн Засгийн газар гадаадаас зээл авдаг, бонд босгодог. Тухайлбал, Н.Алтанхуягийн Засгийн газар “Чингис”, “Самурай” зэрэг хоёр тэрбум ам.долларын бонд босгосон. Одоогийн Ч.Сайханбилэгийн Засгийн газар Хятадаас нэг тэрбум ам.долларын зээл авч байгаа. Харин М.Энхболдын Засгийн газар гадаад зах зээлээс нэг ч төгрөгийн зээл авч, өр тавьж байгаагүй юм байна.

## ҮЕ, ҮЕИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН ЦАЛИН, ТЭТГЭВРИЙГ НЭМСЭН ХУВЬ



# М.ЭНХБОЛДЫН ЕРӨНХИЙ САЙД БАЙХДАА ГАРГАСАН ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД

**1** Цалин, тэтгэврийг 3 дахин нэмсэн

**2** Улаанбаатар хотыг аймгийн төвүүдтэй хатуу хучилттай замаар холбох шийдвэрийг анхлан гаргаж, 540 гаруй км хатуу хучилттай зам, замын байгууламжийг ашиглалтад оруулав.

**3** Монгол хүний хөгжил, хийж бүтээхийн үндсийг хангах “Эрүүл Монгол” хүн хөтөлбөрийг санаачлав.

**4** Гадаадын хөрөнгө оруулалттай зарим аж ахуйн нэгжийн Тогтвортой байдлын гэрээг шинэчлэх шийдвэр гаргаж, Бороо гоулд компаниас аж ахуйн нэгжийн орлогын татвар, нөөц ашигласны төлбөр 160 тэрбум төгрөг, Цайрт минерал компаниас аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нөөц ашигласны төлбөрт 243 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэв.

**5** Татварын багц хуулийг цогцоор нь шинэчилж, хүн ам, аж ахуйн нэгжийн орлого, НӨАТ, Нийгмийн даатгалын шимтгэлийн татварын хувь хэмжээг 10 хувь болгон бууруулснаар Монгол Улс Ази-Номхон далайн бүс нутагт хамгийн бага татвартай улс болов.

**6** Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг Хөшигийн хөндийд олон улсын нисэх онгоцны буудал барих талаар Япон Улсын Засгийн газартай анхны гэрээ хэлэлцээр байгуулав.



**7** Ерөнхий боловсролын сургуулийн I-V ангийн сурагчдад зориулсан "Үдийн цай" хөтөлбөрийг санаачилж, хэрэгжүүлэв.

**8** 40 мянган айлын орон сууц хөтөлбөрийг анхлан санаачилсан.

**9** "Эрчим хүч" хөтөлбөрийг хэрэгжүүлж 4000 орчим км цахилгааны шугам байгуулж 80 гаруй сумыг байнгын эрчим хүчний эх үүсвэрээр хангав.

**10** Монголын бүх сумын төвд үүрэн телефон холбооны үйлчилгээг нэвтрүүлэв.

**11** "Монгол Улсыг хөгжүүлэх сан"-гийн үйл ажиллагааг сэргээж 240 гаруй тэрбум төгрөгийг хуваарилж нь өмнөх гурван жилийн дунджаас 5.3 дахин нэмэгдүүлсэн байна.

**12** Олимпын наадамд бэлтгэх Үндэсний хорооны дэргэд "Олимп хөгжил" сан байгуулах санаачилгыг гаргаж 2007 онд нийт 190 сая төгрөгийг хуримтлуулж чаджээ.

# Ч.Болдбаатар: МОНГОЛЫГ ХЯТАДЫН НЭГ ХЭСЭГ ГЭЖ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН ҮЕД БИД ҮНДСЭН ХУУЛИАРАА УЛСАА ТУНХАГЛАЖ ЧАДСАН

*Монгол Улс анхны Үндсэн хуулиа батални, хаант засаглалаас Бүгд найрамдах засаглалыг тунхагласан 1924 оны арваннэгдүгээр сарын 26-ны талаар МУБИС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор Ч.Болдбаатартай ярилцлаа.*

**-Хэдий улс даяар албан ёсоор амарч, тэмдэглэхээ больсон ч 91 жилийн өмнөх түүхэн өдрийн талаар хоёулаа ярилцъя.**

-Манай төрт ёсны түүхийг харвал засаглалын хэлбэрийн хувьд хоёр хувааж болохоор байгаа. Эхнийх нь, 2200 гаруй жилийн түүхт хаант засаглалтай Монгол Улсын тухай. Хоёр дахь нь, бүгд найрамдах засаглалтай Монгол Улс. Хаант засаглалын амин сүнс нь угсаа залгамжлал. Хааныг хааны хүү, эсвэл түүний угсааныхан залгамжлахаас биш өөр хүн залгамжлахгүй. Бүгд найрамдах засаглалын амин сүнс нь сонгууль. Төрийн эрх барих дээд байгууллагаа ард иргэд нь сонгуулиар бүрдүүлнэ. Бид хоёрын ярих "улс тунхагласан" гэдэг өдөр бол Монголд бүгд найрамдах засаглалыг тунхагласан тухай юм. Арваннэгдүгээр сарын 26-нд БНМАУ-ыг тунхагласан өдөр. Уг нь XX зуунд монголчуудын тусгаар тогтнолын түүх дахин сэргэсэн нь 1911 онтой холбоотой. Гэтэл арваннэгдүгээр сарын 26-ныг "Улс тунхагласны баяр" гэхээр хүмүүс төөрөөд байдаг юм. "Тэгвэл 1911 он юу юм бэ" гэж. 1911 оны арванхоёрдугаар сарын 29-нд бид улсаа тунхаглаж, тусгаар тогтнолоо зарласан Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний өдөр. Гэхдээ хаант засаглалаар явсаар байгаад 1924 оны арваннэгдүгээр сарын 26-нд бүгд найрамдах засаглалд шилжсэн.

**-Ингэж анхны Үндсэн хуулиараа засаглалын хэлбэрээ тунхагласан. Энэ**

**МОРЬ ЖИЛТЭН**



*Төмөр бич өдөр бямба гаригт хийморийн дарцаг хийсгэнэ.*

*1927, 1954, 1990 оны морь жилтэнгүүд жилийн гүмэг засуулах. 1918, 1942, 1966, 1990, 2014 оны эрэгтэй, эмэгтэй төмөр суудлын засал хийлгэ. 1930, 1954, 1978, 2002 оны эрэгтэй эмэгтэй модон суудлын засал хийлгэ.*

**ХОНЬ ЖИЛТЭН**



*Гал могой өдөр даваа гаригт хийморийн дарцаг хийсгэх*

*-1931, 1955, 1979, 2013 оны эрэгтэй суудлын нашидүрсүмийн засал хийлгэнэ. 1919, 1943, 1967, 1991, 2015 оны эмэгтэй суудлын тусгай засал хийлгэнэ*

*1919, 1943, 1967, 1991, 2015 оны эрэгтэй шороо суудлын*
*1919, 1943, 1967, 1991, 2015 оны эмэгтэй огторгуй суудлын*
*1931, 1955, 1979, 2003 оны эрэгтэй уул суудлын*
*1931,1955,1979,2003,оны эмэгтэй хий суудлын засал хийлгэ.*

**БИЧ ЖИЛТЭН**



*Модон бар өдөр мягмар гаригт хийморийн буулттай тул хийморийн дарцаг хийсгэнэ. 1944, 1980, 2016 оны бич жилтэнгүүд мэнгэ голлож байна.*

*-1920, 1944, 1968, 1992, 2016 оны эрэгтэй гал суудалд*
*-1932, 1956, 1980, 2004 оны эмэгтэйчүүд гал суудалд*
*-1920, 1944, 1968, 1992, 2016 оны эмэгтэйчүүд усан суудалд*
*-1932, 1956, 1980, 2004 оны эрэгтэйчүүд усан суудалд*
*-1992, 1968, 1944 оны бич жилтнүүд суудлын гүмэгийн засал хийлгэж ном уншуул.*
*Бич жилтний жил орж байгаа тул 13 настай – Ламаадан, Нанжид дашзэгвэ*
*25 настай – Алтангэрлийн даллага, Цэнд, Доржнамжим*
*37 настай – Жадамба, Жанаггагдог, Цагаан шүхэрт, Лусын сан*
*49 настай – Сундуй, Дашдондов, Гурван гүрэм*
*61 настай- Сундүйн жүд, Алтангэрэл, Цагаан шүхэрт*
*73 настай – Цэвэгмэдийн чого, Цэнд, Жамбалцанжод*
*85 настай – Манал, Улаан юм, - 97 настай – Дүншиг, Маанийн гаа бум, Найман гэгээн, Нивaагүнсэл тус тус уншуул.*



**шаардлага, үндэслэл юунаас эхтэй байсан гэж үздэг вэ?**

-Азид бүгд найрамдах засаглалтай анхны улс бол Хятад буюу Дундад иргэн улс юм. Монгол Улс бол Азид бүгд найрамдах засаглалаа тунхагласан тав дахь улс. Бүгд найрамдах засаглалыг тунхаглах шаардлагын тухайд ярихад, нэгдүгээрт Богд хаан 1924 оны тавдугаар сард өөд болсон. Тэр үеийн нэр томъёогоор манай улсыг "Гадаад Монгол" гэж нэрлэж байсан. Богдыг өөд болсон тавдугаар сард Бээжинд Зөвлөлт болон Дундад иргэн улсын хооронд нууц хэлэлцээр болж Гадаад Монголыг Хятадын нэг хэсэг гэдгийг оросууд хүлээн зөвшөөрөх маягтай болсон. Ийм улс төрийн нөхцөл бий болсон үед Монгол Улсыг де факто оршин байгаа гэдгийг баталгаажуулах үүднээс Үндсэн хуулиа зарлах шаардлага гарсан гэж манай судлаачид үздэг юм.

**-Үүнээс өмнө ийм шийдэл, санаачилга гарч байсан уу?**

-Монголд нийгмийн шинэтгэл гарах ёстой гэдгийг 1921 оны хувьсгалыг гардаж хийсэн эх орончид үзэж байсан. Гэхдээ ямар хэлбэрийг сонгох вэ гэдэг дээр санал зөрөлдөж байсан. Манай Үндэсний төв архивт тэр үед боловсруулж байсан хоёр ч Үндсэн хуулийн төсөл бий. Нэгийг нь Д.Бодоо боловсруулсан гэж манай судлаачид үздэг. Бат-Очир, Ичинноров, Лонжид гуай нар тэгж бичсэн байдаг. Нөгөөг нь Цэвээн Жамсранов боловсруулсан гэдэг. Д.Бодоогийн боловсруулсан гэж үзээд байгаа тэр Үндсэн хуулийн төсөл 1921 оны арваннэгдүгээр сарын 30-нд батлагдсан Богд хаан Ардын засаг хоёрын хоорондын харилцааг зохицуулсан "Тангаргийн гэрээ" баримт бичигтэй яг адилхан байгаа юм. Үндсэндээ Д.Бодоогийн боловсруулсан гээд байгаа тэр Үндсэн хуулийн төслөөс нэг бүлгийг нь аваад Тангаргийн гэрээ болгочихсон байгаа юм л даа. Д.Бодоо Эрдэнэзуугийн хувилгаан ламд бичсэн захидалдаа "Монгол Улс ирээдүйд Англи улсыг өмнөх толь болгон ухваас зохино" гэж бичсэн байдаг. Англи улс яг Үндсэн хууль

**ТАХИА ЖИЛТЭН**



*Усан гахай өдөр пүрэв гаригт хиймориын буулттай хиймориын дарцаг хийсгэнэ.*

*1945, 1981 оны тахиа жилтэнгүүд жилийн гүмэг засуулах*

*1933, 1957, 1981, 2005 оны эрэгтэй ,эмэгтэй тусгай суудлын засал хийлгэнэ.*

*-1921, 1945 ,1969, 1993 оны эрэгтэй хий суудлын,*

*-1921, 1945, 1969, 1993 оны эмэгтэй уул суудлын,.*

*-1933, 1957, 1981, 2005 оны эрэгтэй огторгуй суудлын,*

*-1933, 1957, 1981, 2005 оны эмэгтэйчүүд шороон суудлын засал хийлгэ.*

**НОХОЙ ЖИЛТЭН**



*Төмөр бич өдөр бямба гаригт хийморийн буулттай. Хийморийн дарцаг хийлгэнэ.*

*1922, 1946, 1970, 1994 оны нохой жилтэй эрэгтэй, эмэгтэйчүүд мод суудлын засал,*

*1934, 1958, 1982, 2006 оны эмэгтэй, эрэгтэйчүүд төмөр суудлын засал хийлгэ.*

**ГАХАЙ ЖИЛТЭН**



*Гал могой өдөр даваа гаригт хийморийн буулттай тул хийморийн дарцаг хийсгэнэ. Бага харшийн засал хийлгэх.*

*-1935, 1971, 2007 оны гахай жилтэнгүүд мэнгэ голлосон.*

*-1923, 1947, 1971, 1995 оны эрэгтэйчүүд, 1935, 1955, 1983, 2007 оны эмэгтэйчүүд суудлын нашидурсүмийн засал хийлгэнэ.*

*-1923, 1947, 1971, 1995 оны эрэгтэйчүүд уул суудлын,*

*-1923, 1947, 1971, 1995 оны эмэгтэйчүүд хий суудлын,*

*-1935, 1955, 1983, 2007 эрэгтэйчүүд шороон суудлын,*

*-1935, 1955, 1983, 2007 оны эмэгтэйчүүд огторгуй суудлын засал хийлгэ.*

*1935 оны гахай жилтэн Жанагаргдог уншуулах.*

гээд заачих эрх зүйн баримт бичиггүй. Маш олон хуулиуд нь нийлж байж Үндсэн хуулийн агуулгыг тодорхойлдог. Тэгэхээр Д.Бодоо магадгүй Тангаргийн гэрээ, Засаг ба засаг бус ван, гүнгүүдийн эрх хэмжээний тухай дүрэм, Нутгийн захиргааны дүрэм ч зэргийг гаргаад, тэр нь нийлж Үндсэн хуулийн агуулгыг бүрдүүлэх Англи маягийн тогтолцоо руу явж байсан байж магадгүй.

**-Ж.Цэвээн, Д.Бодоо нарын төсөлд Богд хааны эрх хэмжээг хэрхэн бичиж үлдээсэн байдаг вэ?**

-Д.Бодоо, Ж.Цэвээн хоёрыг Үндсэн хуулийн төсөл санаачилж байх үед Богд хаан амьд байсан. Тэгэхээр Богд хаан, Засгийн газар, бас хууль тогтоодог хурлын байгууллага байж таарна. Энэ гурван институцийн хооронд ямар эрх хэмжээ явагдах юм бэ гэдгийг Д.Бодоогийн ч, Ж.Цэвээний ч Үндсэн хуулийн төсөл дээр тусгасан байна. Богд бол хаан буюу төрийн тэргүүн учраас Үндсэн хуулийн төсөлд Богдыг хасаагүй. Харин 1924 онд Богдыг нас барсны дараахь Үндсэн хуулийн төсөлд Богд хааны талаар байгаагүй. Өөрөөр хэлбэл, тэр хоёрын Үндсэн хуулийг боловсруулах явц дээр Богд хаан амьд сэрүүн байсан явдал ямар нэг хэлбэрээр нөлөөлж байсан гэдэг таамаглалыг түүхчид өгдөг. Үндсэн хуулийн төсөл боловсруулах комиссыг 1922 онд байгуулж ажиллуулсан ч олигтой зүйл хийгдээгүй. Тэд хаант засаглалтай улсын Үндсэн хуулийг монгол хэл дээр орчуулах ажил хийсэн. Голчлон Япон, Дани, Голланд зэрэг улсын хуулийг орчуулсан. Удалгүй тэр комиссыг татан буулгасан.

**-Комиссыг татан буулгах гол үндэслэл нь юу байв?**

-Зөвлөлт Орос улсын Үндсэн хуулиас үлгэр аваагүй байна гэсэн. Дараа нь дахиж нэг комиссыг байгуулсан. Ерөнхий сайд Б.Цэрэндоржоор толгойлуулсан, ихэвчлэн буриадууд байгаа юм. Цэвээн Жамсранов, Элбэгдорж Ренчино гээд олон хүн байсан. Энэ ажлын хэсэгт нэн даруй Үндсэн хуулийг боловсруулах даалгавар өгсөн. Улсын анхдугаар их хурал хуралдахаас үндсэндээ 20 хүрэхгүй хоногийн өмнө төслийг боловсруулж дууссан. Анхдугаар их хурал арваннэгдүгээр сарын 8-29-нд хуралдсан. Гэтэл аравдугаар сарын 20-дын үеэр байгуулагдсан комисс шүү дээ.

**-Анхны Үндсэн хуулийг боловсруулсан гол хүн нь хэн гэж түүхчид үздэг вэ?**

-Коминтерны төлөөлөгч байсан Турар Рыскулов гэдэг хүн Монголын анхны Үндсэн хуулийг голлож боловсруулсан гэж үздэг юм. Энэ хүний угшил нь хасаг. Тэр хүн Зөвлөлт Оросын Үндсэн хуулийн төрийн байгууллын загварыг манайд тэр чигт нь авчирсан. Тэгээд 1924 оны арваннэгдүгээр сарын 25-нд Монгол Улс анхны Үндсэн хуулиа баталсан. 26-нд нь индрийн хурал хийж Монголын нийт ард түмэнд зарласан учраас бид "Бүгд найрамдах Монгол ард улсыг тунхагласан өдөр" гэж түүхэнд тэмдэглэсэн.

**-Богд хааныг нас барж, Үндсэн хуулиас хассаны дараа залгамжлах явц үргэлжилсэн үү?**

-Богд хааныг тодруулах асуудал гараад




Арван хар нүглийг тэвчвээс арван цагаан буян болдог. Амь таслахыг тэвчин амьтны амь аврах, эс өгсөнийг авахыг тэвчин өглөг өгөх, буруу хурьцал үйлдэхийг тэвчин ёс зүйг сахих, худал ярихыг тэвчин үнэн зөвийг үгүүлэх, ховийг тэвчин зүй зохистойг үгүүлэх, ширүүн үг үгүүлэхийг тэвчин эелдэг зөөлөн үг үгүүлэх, дэмий ярихыг тэвчин утга төгс, хэрэгтэй зүйл ярих, хомхой сэтгэлийг тэвчин болин мэдлийг шүтэх, хорлох сэтгэлийг тэвчин туслах сэтгэлийг үүсгэх, буруу үзлийг тэвчин Гурван эрдэнэ, үйлийн үрд итгэмжлэх сэтгэл үүсгэхийг арван цагаан буян хэмээдэг.

**Нар, сарны хиртэлт**

- 2016 оны 3-р сарын 9-ний өдөр Улаанбаатарын цагаар 9:57 минутанд Нар бүтэн хиртэнэ. Монгол улсын нутагт харагдахгүй.
- 2016 оны 3-р сарын 23-ны өдөр Улаанбаатарын цагаар 17:39 минутанд Сарны сүүмгэр хиртэлт эхлэн 21:55 минутанд дуусна. Ажиглагдана.
- 2016 оны 9-р сарын 1-ний өдөр Улаанбаатарын цагаар 17:07 минутанд Нар цагирган хиртэнэ. Монгол улсын нутагт харагдахгүй.
- 2016 оны 9-р сарын 17-ны өдөр Улаанбаатарын цагаар 00:54 минутанд Сарны сүүмгэр хиртэлт эхлэн 04:54 минутанд дуусна. 02:54 минутанд хамгийн их сүүмгэр хиртэлт явагдана. Сар 18:53 минутанд мандах тул энэхүү Сарны сүүмгэр хиртэлт бүрэн ажиглагдана.
- 2017 оны 2-р сарын 11-ний өдөр Улаанбаатарын цагаар 06:34 минутанд Сарны сүүмгэр хиртэлт эхлэн 10:53 минутанд дуусна. Ажиглагдана.
- 2017 оны 2-р сарын 26-ны өдөр Улаанбаатарын цагаар 22:53 минутанд Нар цагирган хиртэнэ. Монгол улсын нутагт харагдахгүй.

*Хаант засаглалаар явсаар байгаад 1924 оны арваннэгдүгээр сарын 26-нд бүгд найрамдах засаглалд шилжсэн*

Есдүгээр Богдыг Төв аймгийн Ноён уулын орчимд Лувсандансан гэдэг нэртэй хүнийг албан бусаар тодруулсан. Төрийн хэмжээнд биш, шашны л хэмжээнд. Тэр хүн 1947 онд цэрэгт яваад нас барсан гэсэн аман мэдээ байдаг. Богд хааныг тодруулах асуудал хүч аваад ирэхэд нь Намын их хурлаар авч хэлэлцсэн юм билээ. Тэгээд Цэвээн Жамсрановын саналаар “Богд гэгээний хойд дүрийг тодруулна гэдэг бол цусан зүрхтэй, усан нүдтэй бид бүгдийн хийж чаддаг ажил биш ээ. Тийм учраас үүнийг Далай ламаас асуух хэрэгтэй” гээд хойшлуулсан гэж байгаа юм. Далай ламаас асуух үүднээс Төвд рүү төлөөлөгчдийг илгээсэн байдаг. Тэр хэдийг яваад ирэх хооронд Монголд коминтерн төрийн эргэлт хийгээд 1929 оноос Улсын V их хурлаас хутагт хувилгаадын хойд дүрийг тодруулахыг хуулиар хориглосон. Тэр хуулийг хүчингүй болгосон зүйл одоо хүртэл байхгүй. Тэрнээс үүдэж Богд гэгээнийг тодруулах асуудал зогссон.

**-Энэ түүхэн өдрийг монголчууд баяр болгон тэмдэглэж байх ёстой юу. Түүхч хүний хувьд юу гэж үздэг вэ?**

-Түүхээ мэдэж, сэргээж тэмдэглэх ёстой. Чи түүхээ мэдэхгүй бол хэн нэгэн чамд түүх зохиож өгнө гэдэг үг бий. Түүхээ мэдэж, ой санамжаа сэргээж байна гэдэг бол сайн зүйл. Хуучин Хөдөлмөрийн хуулиараа энэ өдөр бид амардаг байсан. Амардаг өдрийг нь арванхоёрдугаар сарын 29 рүү шилжүүлснийг та бид мэднэ. Ер нь хамгийн нижгэр тэмдэглэсэн нь бараг л 1934 онд Бүгд найрамдах засаглал тогтсоны 10 жилийн ойг улс даяар тэмдэглэсэн байдаг. Тэгэхэд ойд зориулж түүхийн дөрвөн боть эрхлэн гаргасан байдаг юм. Амарын “Монголын товч түүх”, Дэндэвийн “Монголын түүх”, Чойбалсан, Дэмид, Лосолын “Монголын үндэсний ардчилсан хувьсгал үүсч байгуулагдсан товч түүх”, Бадрахын “Бадрахын баруун этгээдтэй тэмцсэн тэмдэглэл” бүтээлүүд. Одоо ч түүхэнд хандах хандлага өөр болчихлоо. Хуучин бол Марксист, Ленинист үзэл баримтлалыг түүхийн дэг сургууль болгочихсон. Тэрүүгээр аливаа нийгэм бол дарлагч, дарлагдагч гэсэн хоёр бүлэгт хуваагддаг. 1911 онд монголчууд тусгаар тогтнолоо зарласан боловч тэнд нийгмийн элит хэсгийнхэн буюу лам, ноёд нэг хэсэг, хамжлагууд нөгөө талд нь байсан. Үүнийг нийгмийн түүхээрээ феодализмын түүх гэж явуулаад 1921 оноос хойш “Монголын шинэ үеийн түүх” гэж нэршүүлсэн. Тэгээд 1921 оны хувьсгал, улс тунхагласны баяр гэж түүхэнд хандаж байсан учраас тэмдэглэж яваад байсан. 1990 оноос хойш монголчуудын түүхэд хандах хандлага өөр болчихлоо шүү дээ.

**Хаврын тэргүүн цагаан бар (их) сар, 8 цагаан мэнгэ, төмөр суудалтай** — **2016 оны II сар**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Билгийн өдөр, гараг | | 1 φ | 2★ | 3 | 4❋ | 5 | 6☯φ |
| | | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| | | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | | цагаагчин тахиа | хар нохой | харагчин тахиа | хөх хулгана | хөхөгчин үхэр | улаан бар |
| Дүвзий од | | 22 | 23 | 24 | 25 | 26 | 0 |
| Жэдзий од | | 22 | 23 | 25 | 26 | 0 | 1 |
| Суудал | | уул | мод | хий | гал | шороо | төмөр |
| Мэнгэ | | 4 ногоон | 3 хөх | 2 хар | 1 цагаан | 9 улаан | 8 цагаан |
| Барилдлага | | үхэх | идэр | үл зохилдох | идэр | үл тохирох | арвидах |
| Шүтэн барилдлага | | Хуран үйлдэх | Тийн мэдэх | Нэр өнгө | Төрөн түгэх | Хүрэлцэх | Сэрэх |
| Нар ург/шин | | 08:10/18:04 | 08:08/18:06 | 08:07/18:07 | 08:05/18:09 | 08:04/18:10 | 08:02/18:12 |
| Сар ург/шин | | 08:15/19:06 | 08:50/20:22 | 09:23/21:37 | 09:55/22:53 | 10:28/- | 11:02/00:07 |

φ Лусын буулттай ★ Балжинням ☯ Дашням ❋ Бүтээлийн барилдлага.

**Хаврын тэргүүн цагаан бар (их) сар, 8 цагаан мэнгэ, төмөр суудалтай** — **2016 оны II сар**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Билгийн өдөр, гараг | 8 | 9φ | 10 | 11φ | 12❉ | 13△ | 14φ |
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | улаагчин туулай | шар луу | шарагчин могой | цагаан морь | цагаагчин хонь | хар бич | харагчин тахиа |
| Дүвзий од | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Жэдзий од | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Суудал | огторгуй | ус | уул | мод | хий | гал | шороо |
| Мэнгэ | 7 улаан | 6 цагаан | 5 шар | 4 ногоон | 3 хөх | 2 хар | 1 цагаан |
| Барилдлага | үхэх | түлэх | үл зохилдох | үл зохилдох | үл тохирох | түлэх | үхэх |
| Шүтэн барилдлага | Хүрьцах | Авах | Сансар | Төрөх | Өтлөх үхэх | Мунхаг | Нэр өнгө |
| Нар ург/шин | 08:00/18:14 | 07:59/18:15 | 07:57/18:17 | 07:55/18:18 | 07:53/18:20 | 07:52/18:21 | 07:50/18:23 |
| Сар ург/шин | 11:40/01:20 | 12:22/02:29 | 13:09/03:33 | 14:02/04:31 | 14:59/05:22 | 16:00/06:07 | 17:02/06:45 |

φ Лусын буулттай △ Тэрсүүд ❉ Хур ус



*Шинэ театр 800 хүний суудалтай, 9,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй*

Алдарт хөгжмийн зохиолч Б.Дамдинсүрэнгээр овоглосон Төв аймгийн “Монгол туургатан” хөгжимт драмын театр шинэ барилгадаа орох хугацаа дөхөж байна. 1962 онд ашиглалтад орсон одоогийн театрт 1996 онд мэргэжлийн хяналтын байгууллагаас акт тавьж, ашиглахыг хориглосон. Улсын нийслэл Улаанбаатартай хамгийн ойр төвийн бүсийн тулгуур аймгийн хувьд урлаг, уран сайхны гол арга хэмжээгээ театртаа явуулдаг. Мөн дотоод, гадаадын жуулчид аялалынхаа хажуугаар тоглолт үздэг. Монголын 10 Ардын уран зохиолчийн тав нь “Монгол туургатан” театрын тайзнаас төржээ. Зууны манлай хослон дуулаач, Зууны манлай поп дуучин, дуурийн дуучин, гавьяат жүжигчин гээд олныг төрүүлсэн. Иймучраас Төв аймгаас УИХ-д сонгогдсон М.Энхболд гишүүн нэлээд ач холбогдол өгч, улсын төсөвт шинэ театрын хөрөнгийг суулгасан гэдэг.

Монгол туургатан театрын шинэ барилга 800 хүний суудалтай байх бөгөөд 16х12 харьцаатай бөгөөд орон нутагт буй хамгийн том театр болох ажээ. Эргэдэг тайзтай байх агаад дотроо 200 хүний суудалтай мини заал, уран бүтээлчдийн өрөө, тоглолтын хувцас үйлдвэрлэх цех, тохилог ресторан, граж цөм байна. Бид “Монгол туургатан” хөгжимт драмын театрын захирал Д.Баасанжаргалтай уулзаж, барилгын явцын талаар сонирхсон юм.

Тэрээр, “Би өөрөө Төв аймгийн Эрдэнэсант сумын харьяат. Дуурын театрт дуулж байгаад эндэхийн захирлаар томилогдсон. Шинэ театртай болох том түүхийн гэрч болж

Хаврын тэргүүн цагаан бар (их) сар, 8 цагаан мэнгэ, төмөр суудалтай — 2016 оны II сар

| Билгийн өдөр, гараг | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | хөх нохой | хөхөгчин гахай | улаан хулгана | улаагчин үхэр | шар бар | шарагчин туулай | цагаан луу |
| Дүвзий од | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| Жэдзий од | 9 | 10 | 11 | 12 | 13 | 13 | 14 |
| Суудал | төмөр | огторгуй | ус | уул | мод | хий | гал |
| Мэнгэ | 9 улаан | 8 цагаан | 7 улаан | 6 цагаан | 5 шар | 4 ногоон | 3 хөх |
| Барилдлага | үхэх | арвидах | үл зохилдох | хотол чуулган | үл тохирох | үл тохирох | хүчин төгсөх |
| Шүтэн барилдлага | Төрөн түгэх | Хуран үйлдэх | Мунхаг | Өтлөх үхэх | Төрөх | Сансар | Авах |
| Нар ург/шин | 07:48/18:25 | 07:46/18:26 | 07:45/18:28 | 07:43/18:29 | 07:41/18:31 | 07:39/18:32 | 07:37/18:34 |
| Сар ург/шин | 18:05/07:19 | 19:07/07:48 | 20:09/08:16 | 21:09/08:41 | 22:09/09:07 | 23:09/09:33 | -/10:00 |

Хаврын тэргүүн цагаан бар (их) сар, 8 цагаан мэнгэ, төмөр суудалтай — 2016 оны II-III сар

| Билгийн өдөр, гараг | 21φ | 22 | 23 | 24 | 25 | 26◷ | 27 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 29 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | цагаачин могой | хар морь | харагчин хонь | хөх бич | хөхөгчин тахиа | улаан нохой | улаагчин гахай |
| Дүвзий од | 15 | 16 | 16 | 17 | 18 | 19 | 20 |
| Жэдзий од | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 |
| Суудал | шороо | төмөр | огторгуй | ус | уул | мод | хий |
| Мэнгэ | 2 хар | 1 цагаан | 9 улаан | 8 цагаан | 7 улаан | 6 цагаан | 5 шар |
| Барилдлага | үхэх | түлэх | идэр | үл зохилдох | идэр | шид | түлэх |
| Шүтэн барилдлага | Авах | Хурьцах | Сэрэх | Хүрэлцэх | Төрөн түгэх | Нэр өнгө | Тийн мэдэх |
| Нар ург/шин | 07:35/18:35 | 07:33/18:37 | 07:31/18:38 | 07:29/18:40 | 07:27/18:42 | 07:26/18:43 | 07:24/18:45 |
| Сар ург/шин | 00:08/10:31 | 01:07/11:05 | 02:04/11:44 | 03:00/12:29 | 03:53/13:21 | 04:42/14:21 | 05:27/15:28 |

φ Лусын буулттай ◷ Ичигсэд хөдлөх



# ОРОН НУТГИЙН ХАМГИЙН ТОМ ТЕАТР ТӨВ АЙМАГТ БАРИГДАЖ БАЙНА

байгаадаа баяртай байгаа. Энэ бол М.Энхболд гишүүний Монгол Улс, тэр дундаа Төв аймгийн оюун санаа, урлагийн хөгжилд оруулж байгаа маш том хөрөнгө оруулалт. Энэ хүн л улсын төсөвт шинэ театрын мөнгийг суулгаж өгсөн. Барилгын ажлыг 2014 оны долдугаар сарын 22-нд барилгын ажил эхэлсэн. Одоо театрын барилгын явц 70 гаруй хувьтай байна. Улсын төсөвт нийтдээ 9.5 тэрбум төгрөг суусан юм. Одоогийн байдлаар 4.5 тэрбум төгрөг авахаар байна. 3 тэрбум төгрөгийг нь авчихсан. 840 сая төгрөгийг нь яамнаас авчихсан. Үлдэгдэл 850 сая төгрөг авч амжаагүй байна. Энэ мөнгөө авчихвал энэ жилдээ багтаад барилгын ажлыг дуусгах боломж байгаа" гэв.

Мөн, "Манайх жилд давхардсан тоогоор 25-35 тоглолт тавьдаг. Сар бүр тоглолт хийдэг. Одоо 2016 он дөнгөж гарангуут зууны манлай хос дуучин С.Вандан, Д.Дуламсүрэн нарын тоглолтыг зохион байгуулна. Дахиад 10-хан хоногийн дараа Цагаан сарын тоглолт хийх жишээтэй. Төв аймгийн иргэд Улаанбаатарт очиж урлагийн тоглолтыг үздэг. Бид одоо Монголын хамгийн том театртай болж байгаа учраас Улаанбаатарт болж байгаа тоглолтыг Төв аймагт зохион байгуулдаг менежмэнт хэрэгжүүлнэ. Манай баруун талд Хөшигийн хөндийн олон улсын нисэх буудал, зүүн талд Майдар сити, хойно Цэцээ гүний оргил байна. Аялал жуулчлалын энэ маршрутыг дагаж аймгийнхаа театр руу гадна, дотны жуулчдыг татна. Мөн үндэсний хэмжээний Монгол туургатан төсөл бичиж салбарын яам руу хүргүүлсэн байгаа. Төв аймгийн өөрийн оркестртой болж, шинэ жүжгүүд, концертуудыг олноор тавина. Одоо хамгийн гол ажил манай театрын 65 хүний бүрэлдэхүүнтэй багт үлдээд байгаа" гэлээ.

**Хаврын тэргүүн цагаан бар (их) сар, 8 цагаан мэнгэ, төмөр суудалтай**
**Хаврын дунд цагаагчин туулай (бага) сар, 7 улаан мэнгэ, огторгуй суудалтай**

**2016 оны III сар**

| Билгийн өдөр, гараг | 28 | 29φ | 30 | 2 φ▲ | 3☯φ❋ | 4 | 5 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | шар хулгана | шарагчин үхэр | цагаан бар | цагаачин туулай | хар луу | харагчин могой | хөх морь |
| Дүвзий од | 21 | 22 | 23 | 24 | 26 | 0 | 1 |
| Жэдзий од | 22 | 23 | 24 | 25 | 26 | 0 | 1 |
| Суудал | гал | шороо | төмөр | огторгуй | ус | уул | мод |
| Мэнгэ | 4 ногоон | 3 хөх | 2 хар | 1 цагаан | 9 улаан | 8 цагаан | 7 улаан |
| Барилдлага | рашаан | түлэх | үхэх | үл зохилдох | идэр | үл тохирох | арвидах |
| Шүтэн барилдлага | Өтлөх үхэх | Төрөх | Сансар | Тийн мэдэх | Нэр өнгө | Төрөн түгэх | Хүрэлцэх |
| Нар ург/шин | 07:22/18:46 | 07:20/18:48 | 07:18/18:49 | 07:16/18:51 | 07:14/18:52 | 07:12/18:54 | 07:10/18:55 |
| Сар ург/шин | 06:07/16:39 | 06:44/17:55 | 07:19/19:12 | 07:52/20:30 | 08:25/21:48 | 09:00/23:04 | 09:38/- |

φ Лусын буулттай ☯ Дашням ▲ Модон хохимой ❋ Бүтээлийн барилдлага

**Хаврын дунд цагаагчин туулай (бага) сар, 7 улаан мэнгэ, огторгуй суудалтай**

**2016 оны III сар**

| Билгийн өдөр, гараг | 6 | 7 | 8★φ | 9 | 10φ | 11△ | 12 ⋎ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | хөхөгчин хонь | улаан бич | улаагчин тахиа | шар нохой | шарагчин гахай | цагаан хулгана | цагаагчин үхэр |
| Дүвзий од | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Жэдзий од | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| Суудал | хий | гал | шороо | төмөр | огторгуй | ус | уул |
| Мэнгэ | 6 цагаан | 5 шар | 4 ногоон | 3 хөх | 2 хар | 1 цагаан | 9 улаан |
| Барилдлага | идэр | хүчин төгсөх | рашаан | хотол чуулган | түлэх | идэр | арвидах |
| Шүтэн барилдлага | Сэрэх | Хурьцах | Авах | Сансар | Төрөх | Өтлөх үхэх | Мунхаг |
| Нар ург/шин | 07:08/18:56 | 07:06/18:58 | 07:04/18:59 | 07:01/19:01 | 06:59/19:02 | 06:57/19:04 | 06:55/19:05 |
| Сар ург/шин | 10:20/00:17 | 11:07/01:25 | 11:58/02:29 | 12:55/03:20 | 13:54/04:06 | 14:55/04:46 | 15:57/05:21 |

φ Лусын буулттай ★ Балжинням △ Тэрсүүд ⋎ Хаврын тэнцэл

Улс төр, цаг үе,нийгэм мэдээллийн чөлөөт сэтгүүл
ТОР АНАЛИЗ
Үнэний талд



# ГИШҮҮНИЙ ТЭРБУМААР БОСГОСОН АХМАДЫН СУВИЛАЛ

УИХ-ын дэд дарга, МАН-ын дарга М.Энхболд парламентын гишүүнд төсвөөс олгодог нэг тэрбум төгрөгөөрөө Төв аймагт Ахмадын сувилал, амралтын газар байгуулжээ. Тус сувиллыг 2013 оны арванхоёрдугаар сард ашиглалтад оруулсан байна. Ингэснээр эмч нэг, сувилагч хоёр, тогооч нэг, туслах тогооч нэг, амралтын менежер нэг, үйлчлэгч нэг, харуулын нэг ажлын байрыг шинээр бий болгожээ.

Сувиллын газар аймгийн Нийгмийн халамжийн хэлтсийн харьяанд үйл ажиллагаа явуулдаг учраас хөнгөлөлттэй үнээр үйлчилдэг байна. Тодруулбал, өдрийн 16 мянган төгрөгийн төлбөртэй сувилалд Төв аймгийн харьяат ахмадуудыг найман мянган төгрөгөөр Нийгмийн халамжийн сангаас хямдруулж үйлчилдэг. Сувилал 2015 оны зургадугаар сард эхний ээлжийн ахмадуудаа Төв аймгийн сум бүрээс хүлээн авчээ. Тус сувилал 28 ахмадыг хүлээн авах зориулалттай бөгөөд сэргээн засалт, уламжлалт бариа засал, сувилгаа, чийрэгжүүлэлт явуулах үндсэн чиглэлээр ажилладаг гэдгийг Төв аймгийн Нийгмийн халамжийн хэлтсийн Захиргаа, хяналтын албаны дарга Н.Баяраа тодотголоо. Ахмадуудын эрүүл мэндийг хүний гавьяат эмч Г.Түмэннаст хариуцан ажилладаг.

Биднийг ахмадын сувилалд очиход амрагчид үйлчилгээ, орчин нөхцөлд “онц” үнэлгээ өглөө. Амрагчид Төв аймгийн 27 сумаас ирдэг учраас ахмадуудын зарим нь олон жил уулзаагүй анд, нөхөртэйгээ уулзах сайхан завшаан тохиодог байна. Шинээр нөхөрлөсөн ахмадууд дурсгалын зураг татуулцгааж, утас хаягаа солилцдог ажээ.

**Хаврын дунд цагаагчин туулай (бага) сар, 7 улаан мэнгэ, огторгуй суудалтай** **2016 оны III сар**

| Билгийн өдөр, гараг | 13 | 14 | 15 ☾ | 16φ | 17 | 18φ | 19 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | хар бар | харагчин туулай | хөх луу | хөхөгчин могой | улаан морь | улаагчин хонь | шар бич |
| Дүвзий од | 9 | 10 | 11 | 12 | 12 | 13 | 14 |
| Жэдзий од | 10 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 |
| Суудал | мод | хий | гал | шороо | төмөр | огторгуй | ус |
| Мэнгэ | 8 цагаан | 7 улаан | 6 цагаан | 5 шар | 4 ногоон | 3 хөх | 2 хар |
| Барилдлага | үхэх | арвидах | үл зохилдох | хотол чуулган | үл тохирох | үл тохирох | арвидах |
| Шүтэн барилдлага | Хуран үйлдэх | Төрөн түгэх | Хүрэлцэх | Тийн мэдэх | Хуран үйлдэх | Мунхаг | Өтлөх үхэх |
| Нар ург/шин | 06:53/19:07 | 06:51/19:08 | 06:49/19:10 | 06:47/19:11 | 06:45/19:12 | 06:43/19:14 | 06:41/19:15 |
| Сар ург/шин | 16:59/05:51 | 18:00/06:19 | 19:00/06:45 | 20:01/07:10 | 21:00/07:36 | 22:00/08:03 | 22:59/08:32 |

φ Лусын буулттай ☾ Сар хиртэнэ буянд шамд /дэлгэрэнгүйг 37-р хуудас/

**Хаврын дунд цагаагчин туулай (бага) сар, 7 улаан мэнгэ, огторгуй суудалтай** **2016 оны III-IV сар**

| Билгийн өдөр, гараг | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 28 | 29 | 30 | 31 | 1 | 2 | 3 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | шарагчин тахиа | цагаан нохой | цагаагчин гахай | хар хулгана | харагчин үхэр | хөх бар | хөхөгчин туулай |
| Дү`взий од | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 |
| Жэдзий од | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 |
| Суудал | уул | мод | хий | гал | шороо | төмөр | огторгуй |
| Мэнгэ | 1 цагаан | 9 улаан | 8 цагаан | 7 улаан | 6 цагаан | 5 шар | 4 ногоон |
| Барилдлага | идэр | түлэх | рашаан | үл зохилдох | шид | шид | үхэх |
| Шүтэн барилдлага | Төрөх | Сансар | Авах | Хурьцах | Сэрэх | Хүрэлцэх | Төрөн түгэх |
| Нар ург/шин | 06:39/19:17 | 06:37/19:18 | 06:35/19:20 | 06:33/19:21 | 06:31/19:23 | 06:29/19:24 | 06:27/19:25 |
| Сар ург/шин | 23:56/09:04 | -/09:41 | 00:52/10:23 | 01:45/11:11 | 02:34/12:06 | 03:19/13:08 | 04:00/14:15 |

Богд хаан уулын дархан цаазат газарт орших энэхүү амралтын газар нь төвийн дуу чимээнээс хол, ой модтойгоо ойрхон, цэвэр агаартай. Эрүүл агаар эм гэдэгчлэн ирсэн ахмадууд сэтгэл ханамжтай буцацгааж, ирэх жил амрах захиалгаа өгөөд явдаг байна.

Амралт сувиллын газрын гурван давхар барилгын 2, 3 дугаар давхарт нь амрагчид байрладаг. Харин нэг давхарт уламжлалт бариа заслын өрөө, чийрэгжүүлэлтийн танхим, хөзөр, шатар, даалуу өрөх тоглоомын өрөө, гал тогоо, хоолны танхим, телевиз, буйдантай үзвэрийн өрөө, дөрвөн хүн зэрэг орох боломжтой халуун ус, душ, эмчийн өрөө, угаалгын өрөө зэрэг байлаа. Тусгай хамгаалалттай газар нутаг учраас элдвийн хүмүүс шавахгүй, хулгай зэлгий гарна гэхгүй амар юм. Тус амралтын газар одоогийн байдлаар 250 ахмадыг амраагаад байна. Ахмадууд буцахаасаа өмнө баярласан талархсанаа илэрхийлж, "төддүгээр ээлжийн амрагч нараас дурсгав" гэсэн дурсгалын зүйл үлдээдэг болжээ. Үлдээсэн сэтгэлийн зүйлсийг амралтын газрынхан хүндэтгэж ханандаа бүгдийг нь өлгөсөн байлаа.

Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газраас жил бүр тендер зарлаж ахмадуудыг хөнгөлөлттэй үнээр амраах газрыг сонгон шалгаруулдаг. Тийм амралтын газар улсын хэмжээнд 50 орчим байдаг бөгөөд Төв аймгийн хэмжээнд тав байна. М.Энхболд гишүүний санаачилга, дэмжлэгээр байгуулсан амралтын газартай нийлээд Төв аймаг ахмадуудад зориулсан зургаан амралт, сувиллын газартай болоод байгаа ажээ. Одоогоор ахмадын амралт, сувиллын газар нь 250 амрагчаас нийтдээ 40 гаруй сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн бөгөөд





үүнийгээ ашиглалтын зардал болон засвар, тохижуулалтад зарцуулж байгаа юм.

Эднийхээр үйлчлүүлсэн ахмадуудаас хэд хэдэн хүсэлт иржээ. Өвөл, зунжин байшин, орон сууцанд амьдардаг ахмадууд зуны дэлгэр цагт монгол гэрт амрах хүсэлт тавьсан бол гэрт амьдардаг ахмадууд байшинг илүүд үзжээ. Түүнчлэн Амралт, сувиллын газрын эзэмшил 10 га газрыг хашаалж, хашаан дотроо дулааны улиралд гадаа чийрэгжүүлэх элдэв боломж бүрдүүлэхийг хүсчээ. Гүүний саам, хүчилтөрөгчийн коктейл үйлчилгээндээ нэмэхийг хүссэн саналыг ч ахмадууд ирүүлсэн байна.

**Хаврын дунд цагаагчин туулай (бага) сар, 7 улаан мэнгэ, огторгуй суудалтай** **2016 оны IV сар**
**Хаврын адаг хар луу (бага) сар, 6 цагаан мэнгэ, ус суудалтай**

| Билгийн өдөр, гараг | 27о | 28 | 29 | 30 | 1☯ | 2 | 3▲ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумьяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адьяа |
| Аргын өдөр, гараг | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | улаан луу | улаагчин могой | шар морь | шарагчин хонь | цагаан бич | цагаагчин тахиа | хар нохой |
| Дүвзий од | 22 | 23 | 24 | 25 | 26 | 0 | 1 |
| Жэдзий од | 23 | 24 | 25 | 26 | 0 | 1 | 2 |
| Суудал | ус | уул | мод | хий | гал | шороо | төмөр |
| Мэнгэ | 3 хөх | 2 хар | 1 цагаан | 9 улаан | 8 цагаан | 7 улаан | 6 цагаан |
| Барилдлага | идэр | арвидах | рашаан | үл зохилдох | үл тохирох | түлэх | арвидах |
| Шүтэн барилдлага | Нэр өнгө | Мунхаг | Өтлөх үхэх | Төрөх | Нэр өнгө | Төрөн түгэх | Хүрэлцэх |
| Нар ург/шин | 06:25/19:27 | 06:23/19:28 | 06:21/19:30 | 06:19/19:31 | 06:17/19:33 | 06:15/19:34 | 06:13/19:36 |
| Сар ург/шин | 04:37/15:27 | 05:12/16:42 | 05:46/18:00 | 06:19/19:19 | 06:54/20:38 | 07:31/21:55 | 08:12/23:09 |

☯ Дашням ▲ Модон хохимой о Ханш нээх-23:07

**Хаврын адаг хар луу (бага) сар, 6 цагаан мэнгэ, ус суудалтай** **2016 оны IV сар**

| Билгийн өдөр, гараг | 4 | 6 | 7 | 8 | 9∆ | 10* | 11 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумьяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адьяа |
| Аргын өдөр, гараг | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | харагчин гахай | хөх хулгана | хөхөгчин үхэр | улаан бар | улаагчин туулай | шар луу | шарагчин могой |
| Дүвзий од | 2 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 8 |
| Жэдзий од | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| Суудал | огторгуй | ус | уул | мод | хий | гал | шороо |
| Мэнгэ | 5 шар | 4 ногоон | 3 хөх | 2 хар | 1 цагаан | 9 улаан | 8 цагаан |
| Барилдлага | идэр | хүчин төгсөх | рашаан | хотол чуулган | түлэх | идэр | арвидах |
| Шүтэн барилдлага | Сэрэх | Хурьцах | Авах | Сансар | Төрөх | Өтлөх үхэх | Мунхаг |
| Нар ург/шин | 06:11/19:37 | 06:09/19:38 | 06:07/19:40 | 06:05/19:41 | 06:03/19:43 | 06:01/19:44 | 05:59/19:46 |
| Сар ург/шин | 08:59/- | 09:50/00:16 | 10:46/01:14 | 11:46/02:05 | 12:48/02:47 | 13:50/03:23 | 14:52/03:55 |

* Балжинням ∆ Тэрсүүд

# МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ТОВЧ

**Монгол Улсын хилийн нийт урт-8158 км**

Үүнээс: **ОХУ-тай -3485 км**

**БНХАУ-тай -4673 км**

Монгол орны баруунаас зүүн захын цэг хүртэл - 2392 км

Монгол орны хойноос өмнө захын цэг хүртэл - 1259 км

Монгол орны усан хил: Буйр нуур, Тарь нуур /Дорнод/, Увс нуур /Увс/

Монгол орны усан хагалбар: Хэнтийн нуруу Цогтчандмань уул / Төв / - д.т.д 1845 м

**Хамгийн өндөр цэг:** Хүйтэн уул / Найрамдал оргил / / Баян-Өлгий / - д.т.д 4374 м
**Хамгийн нам цэг:** Хөх нуур / Дорнод / - д.т.д 560 м
**Хамгийн урт нуруу:** МОНГОЛ АЛТАЙН НУРУУ - 900 гаруй км
**Хамгийн том тогтмол нуур:** УВС НУУР - 3350км$^2$
**Хамгийн гүн, цэнгэг нуур:** / ХӨВСГӨЛ НУУР/ - 267м гүн, 136км урт, 45км өргөн, 2770км$^2$
**Хамгийн урт гол:** Орхон гол - 1124 км
**Хамгийн том мөсөн гол:** Потанины мөсөн гол / Алтай Таван Богд уул / - 20км урт, 5км өргөн
**Хамгийн өндөр хүрхрээ:** Арсайн хүрхрээ / Хорьдол Сарьдагийн нуруу / - 70 метрийн өндрөөс буудаг
**Хамгийн олон галт уултай нутаг:** ДАРЬГАНГА / Сүхбаатар / - 220 орчим
**Хамгийн өргөн уудам тал:** Монголын Дорнод тал - 150-200км өргөн, 300км урт
**Хамгийн том газар нутагтай аймаг:** ӨМНӨГОВЬ - 165400км$^2$
**Хамгийн том агуй:** / Сүхбаатар / - ХӨ 45$^o$35`, ЗУ 114$^o$30`
**Хамгийн халуун рашаан:** Шаргалжуут / Баянхонгор / +89$^o$с
**Хамгийн том элс:** Бөөрөг Дэлийн элс / Алтан элс -ний хамт / - 4000км$^2$
**Хамгийн том говь:** ГАЛБЫН ГОВЬ / Өмнөговь / - 70000км$^2$
**Хамгийн халуун болдог газар:** Эхийн гол / Баянхонгор / - +45$^o$с
**Хамгийн хүйтэн болдог газар:** Тосонцэнгэл / Завхан /- -52,9$^o$с
**Хамгийн их тунадас унадаг газар:** Дадал / Хэнтий /- 387 мм
**Хамгийн бага тунадас унадаг газар:** Захуйн говь / Говь-Алтай / - 45 мм
**Хамгийн өндөрт оршдог аймгийн төв:** АЛТАЙ / Говь-Алтай / - д.т.д 2160 м
**Хамгийн өндөрт оршдог сум:** Дуут / Ховд / - д.т.д 2400 м

**Төв цэг:** Өвөр хангай аймгийн Бүрд сум, Өвөр Хөшөөтийн булаг - ХӨ 46$^o$52` , ЗУ 103$^o$50`
**Баруун захын цэг:** Мааньт уул / Баян-Өлгий / - ЗУ 87$^o$44`
**Хойд захын цэг:** Монгол Шарын даваа / Хөвсгөл / - ХӨ 52$^o$09`
**Өмнө захын цэг:** Орвог гашууны бор толгой / Өмнөговь / - ХӨ 41$^o$35`
**Ази тивийн их даралтын төв:** УЛААНГОМ / Увс / 1055 М.У.Б.Ө.

Хаврын адаг хар луу (бага) сар, 6 цагаан мэнгэ, ус суудалтай — 2016 оны IV сар

| Билгийн өдөр, гараг | 12 | 13 | 14⓪ | 14 | 15 | 16 | 17 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | цагаан морь | цагаачин хонь | хар бич | харагчин тахиа | хөх нохой | хөхөгчин гахай | улаан хулгана |
| Дүвзий од | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 |
| Жэдзий од | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 |
| Суудал | төмөр | огторгуй | ус | уул | мод | хий | гал |
| Мэнгэ | 7 улаан | 6 цагаан | 5 шар | 4 ногоон | 3 хөх | 2 хар | 1цагаан |
| Барилдлага | үхэх | хүчин төгсөх | үл зохилдох | хотол чуулган | үл тохирох | түлэх | түлэх |
| Шүтэн барилдлага | Хуран үйлдэх | Тийн мэдэх | Хүрэлцэх | авах | Сэрэх | Нэр өнгө | Тийн мэдэх |
| Нар ург/шин | 05:57/19:47 | 05:56/19:48 | 05:54/19:50 | 05:53:19:51 | 05:50/19:53 | 05:48/19:54 | 05:47/19:56 |
| Сар ург/шин | 15:53/04:23 | 16:53/04:49 | 17:53/05:15 | 18:53/05:40 | 19:53/06:06 | 20:52/06:34 | 21:51/07:05 |

⓪ Тариалангийн хур

Хаврын адаг хар луу (бага) сар, 6 цагаан мэнгэ, ус суудалтай — 2016 оны IV-V сар

| Билгийн өдөр, гараг | 18 | 19 ❋ | 20 | 21 | 22 | 23 | 24 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 25 | 26 | 27 | 28 | 29 | 30 | 1 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | улаагчин үхэр | шар бар | шарагчин туулай | цагаан луу | цагаагчин могой | хар морь | харагчин хонь |
| Дүвзий од | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 |
| Жэдзий од | 17 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 |
| Суудал | шороо | төмөр | огторгуй | ус | уул | мод | хий |
| Мэнгэ | 9 улаан | 8 цагаан | 7 улаан | 6 цагаан | 5 шар | 4 ногоон | 3 хөх |
| Барилдлага | идэр | түлэх | рашаан | үл зохилдох | шид | шид | үхэх |
| Шүтэн барилдлага | Хуран үйлдэх | Мунхаг | Өтлөх үхэх | Төрөх | Сансар | Авах | Хүрьцах |
| Нар ург/шин | 05:45/19:57 | 05:43/19:58 | 05:41/20:00 | 05:40/20:01 | 05:38/20:03 | 05:36/20:04 | 05:35/20:05 |
| Сар ург/шин | 22:47/07:40 | 23:41/08:20 | -/09:06 | 00:31/09:58 | 01:17/10:56 | 01:58/12:00 | 02:35/13:07 |

❋ Бүтээлийн барилдлага

# ТӨВ АЙМГИЙН ТУХАЙ ТОВЧ

- Төв аймаг хурдан морины бүх насны ангилалд нийтдээ 276 түрүү авсан нь улсын хэмжээнд хамгийн олон хурдан хүлэгтэй аймаг болжээ. Төв аймаг хамгийн олон сумтай аймаг бөгөөд нийт 27 сумтай.
- Төв аймаг газар нутгийн хэмжээгээрээ улсад 12-т ордог ч дэлхийн 77 орноос том газар нутагтай.
- Богд хан уулын аймаг нь Монгол Улсын нутгийн барag дөрөвний нэгийг хамарсан нутагтай байсан.
- Монголын хамгийн үнэтэй ном хэмээх Сундуйн жүд буюу Нууцын хураангуй судар Монгол банкны Эрдэнэсийн санд хадгалагддаг.
- Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд байгуулж буй олон улсын нисэх онгоцны буудал Монгол Улсын хамгийн том нисэх онгоцны буудал юм.
- Монголын анхны Салхин цахилгаан станц Төв аймгийн Сэргэлэн сумын Салхитын хөндийд 2013 онд ашиглалтад орсон.
- Төв аймгийн Эрдэнэсант сумын Угалзат баг 10 мянга 479 толгой адуугаараа Монголын хамгийн олон адуутай багаар шалгарсан.
- Улаанбаатар хоттой хамгийн ойрхон сум Зуунмод -43км.

## ТӨВ АЙМГИЙН 7 ГАЙХАМШГААР

- Манзуширын хийдийн туурь
- Хустайн байгалийн цогцолборт газар
- Гүнжийн сүм,
- Зоргол хайрхан уул
- Чингис хааны морьт хөшөө
- Тоньюкукын гэрэлт хөшөөний бичээс
- Цогт хунтайжийн дуутын хадны бичээс зэрэг газрууд тодорчээ

**Хаврын адаг хар луу (бага) сар, 6 цагаан мэнгэ, ус суудалтай**
**Зуны эхэн харагчин могой (их) сар, 5 шар мэнгэ, уул суудалтай** **2016 оны V сар**

| Билгийн өдөр, гараг | 25 φ | 26 φ | 27 | 28● | 30 | 1 | 2 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | хөх бич | хөхөгчин тахиа | улаан нохой | улаагчин гахай | шар хулгана | шарагчин үхэр | цагаан бар |
| Дүвзий од | 23 | 24 | 25 | 26 | 0 | 1 | 2 |
| Жадзий од | 23 | 25 | 26 | 0 | 1 | 2 | 3 |
| Суудал | гал | шороо | төмөр | огторгуй | ус | уул | мод |
| Мэнгэ | 2 хар | 1 цагаан | 9 улаан | 8 цагаан | 7 улаан | 6 цагаан | 5 шар |
| Барилдлага | идэр | үхэх | рашаан | хотол чуулган | түлэх | түлэх | түлэх |
| Шүтэн барилдлага | Сэрэх | Хүрэлцэх | Төрөн түгэх | Хуран үйлдэх | Мунхаг | Төрөн түгэх | Хүрэлцэх |
| Нар ург/шин | 05:33/20:07 | 05:31/20:08 | 05:30/20:10 | 05:28/20:11 | 05:27/20:12 | 05:25/20:14 | 05:24/20:15 |
| Сар ург/шин | 03:10/14:19 | 03:42/15:33 | 04:14/16:49 | 04:47/18:08 | 05:23/19:26 | 06:01/20:43 | 06:46/21:56 |

φ Лусын буулттай ● зуны уур

**Зуны эхэн харагчин могой (их) сар, 5 шар мэнгэ, уул суудалтай** **2016 оны V сар**

| Билгийн өдөр, гараг | 3★ | 4▲ | 5 φ | 6 ❋ | 7∆ | 8 φ | 9☯ φ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | цагаачин туулай | хар луу | харагчин могой | хөх морь | хөхөгчин хонь | улаан бич | улаагчин тахиа |
| Дүвзий од | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| Жадзий од | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| Суудал | хий | гал | шороо | төмөр | огторгуй | ус | уул |
| Мэнгэ | 4 ногоон | 3 хөх | 2 хар | 1 цагаан | 9 улаан | 8 цагаан | 7 улаан |
| Барилдлага | үл зохилдох | үхэх | үл зохилдох | хүчин төгсөх | идэр | түлэх | арвидах |
| Шүтэн барилдлага | Сэрэх | Хурьцах | Авах | Сансар | Төрөх | Өтлөх үхэх | Мунхаг |
| Нар ург/шин | 05:22/20:16 | 05:21/20:18 | 05:19/20:19 | 05:18/20:20 | 05:17/20:22 | 05:15/20:23 | 05:14/20:24 |
| Сар ург/шин | 07:36/23:01 | 08:32/23:57 | 09:32/- | 10:35/00:44 | 11:39/01:24 | 12:42/01:58 | 13:44/02:27 |

★ Балжинням ☯ Дашням φ Лусын буулттайр ▲ Модон хохимойг ∆ Тэрсүүд ❋ Бүтээлийн барилдлага

# Эмч Б.Болдсайхан:

# ӨВЧИНГҮЙ, ӨВЧЛӨХГҮЙ БАЙХ ИХ АМАРХАН

*Улаанбаатар Сонгдо эмнэлгийн Ерөнхий захирал Б.Болдсайхантай ярилцлаа.*

**-Энэ удаа би тантай эмнэлгийн тухай ярихгүй. Харин хүн явал эрүүл байх, өвдөхгүй байх тухай ярилцах гэсэн юм.**

-Болно л доо, би ч бас энэ тухай эм тариа, эрүүл мэндийн зөвлөгөө гэж онол гэхгүйгээр ярьж болох уу.

**-Яаж хариулах нь таны л хэрэг. Хүмүүс аливаа нэгэн өвчин тусахаас сэргийлж хүнсний нэмэлт бүтээгдэхүүн хэрэглэж, витамин, кальци уудаг болж. Эдгээр нь урьдчилан сэргийлэх аргууд мөн үү?**

-Сүүлийн үеийн байгаа олон тооны том судалгаагаар нэмэлт бүтээгдэхүүн хэрэглэх нь өвчнөөс урьдчилан сэргийлэх баталгаа болж чадахгүй гэсэн судалгаа гараад байгаа. Өөрөөр хэлбэл, нэмэлт витамин, кальци, төрөл бүрийн бэлдмэл уух нь бараг үр дүнгүй юм байна гэсэн судалгаа гарсан.

**-Тэгвэл хувь хүн өөрөөр яаж өвчнөөс сэргийлэх вэ?**

-Эрүүл, өвдөхгүй байж, эрүүл, чийрэг биетэй, саруул ухаантай, залуу сайхан байдлаа удаан хугацаанд хадгалах тухай үеийн үед хүмүүс хүсч ирсэн. Чингис хаан хүртэл Чанчимбумыг дуудаж явал урт удаан амьдрах вэ гэж хамгийн түрүүнд асуусан гэдэг. Дараа нь, яаж улс орноо удирдах вэ, энэ том гүүрний олон арван зуун овог, аймгийн хүмүүсийг яаж аз жаргалтай байлгах вэ гэж асууж байсан гэдэг. Үеийн үед л хүмүүс эрүүл байж урт удаан наслах талаар бодож ирсэн. Ер нь өвчингүй, өвдөхгүй байх их амархан. Хамгийн түрүүнд, сэтгэл тайван байх ёстой. Амгалан байх ёстой. Хүн бол 70 кг мах биш шүү дээ. Хүний сэтгэл нь, хүний мөн чанар нь чухал.

**-Таныхаар сэтгэл амар амгалан, тайван байна гэдгийг юу гэж ойлгох вэ. Уур уцааргүй л бай гэсэн үг үү?**

-Буддын сургааль бол зөвхөн сэтгэлийн тухай шинжлэх ухаан. Сэтгэлээ шинжилж, тэрийгээ тогтоож, хэрхэн амгалан байлгах вэ. Сэтгэл амгалан байвал амьдрал жаргалтай байна. Тэгэхээр сэтгэлийн тухайд монголчууд нэг талаасаа азтай. Дэлхийн 200 гаруй улс дотор, хэдэн мянган үндэстэн угсаатай дотор сэтгэлийн тухай бүрэн төгс онол шинжлэх ухааныг бүх ном сургааль уламжлал, багштай нь авч үлдсэн хуруу

**Зуны эхэн харагчин могой (их) сар, 5 шар мэнгэ, уул суудалтай** — **2016 оны V сар**

| Билгийн өдөр, гараг | 10 φ | 11 | 12 | 13 | 14 ● | 15 φ | 16 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | шар нохой | шарагчин гахай | цагаан хулгана | цагаагчин үхэр | хар бар | харагчин туулай | хөх луу |
| Дүвзий од | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 |
| Жадзий од | 11 | 12 | 13 | 14 | 14 | 15 | 16 |
| Суудал | мод | хий | гал | шороо | төмөр | огторгуй | ус |
| Мэнгэ | 6 цагаан | 5 шар | 4 ногоон | 3 хөх | 2 хар | 1 цагаан | 9 улаан |
| Барилдлага | үл зохилдох | хүчин төгсөх | үл зохилдох | хотол чуулган | үл тохирох | түлэх | түлэх |
| Шүтэн барилдлага | Хуран үйлдэх | Тийн мэдэх | Нэр өнгө | Сэрэх | Хүрьцах | Авах | Төрөн түгэх |
| Нар ург/шин | 05:13/20:26 | 05:12/20:27 | 05:10/20:28 | 05:09/20:29 | 05:08/20:31 | 05:07/20:32 | 05:06/20:33 |
| Сар ург/шин | 14:45/02:54 | 15:46/03:20 | 16:46/03:45 | 17:46/04:10 | 18:45/04:37 | 19:44/05:07 | 20:42/05:41 |

φ Лусын буулттай ● Өчүүхэн дүүрэн

**Зуны эхэн харагчин могой (их) сар, 5 шар мэнгэ, уул суудалтай** — **2016 оны V сар**

| Билгийн өдөр, гараг | 17 | 18 | 19 φ | 20 | 21 φ | 22 | 23 φ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 | 29 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | хөхөгчин могой | Улаан морь | улаагчин хонь | шар бич | шарагчин тахиа | цагаан нохой | цагаагчин гахай |
| Дүвзий од | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 |
| Жэдзий од | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 |
| Суудал | уул | мод | хий | гал | шороо | төмөр | огторгуй |
| Мэнгэ | 8 цагаан | 7 улаан | 6 цагаан | 5 шар | 4 ногоон | 3 хөх | 2 хар |
| Барилдлага | идэр | үхэх | рашаан | үл тохирох | шид | идэр | түлэх |
| Шүтэн барилдлага | Нэр өнгө | Тийн мэдэх | Хуран үйлдэх | Мунхаг | Өтлөх үхэх | Төрөх | Сансар |
| Нар ург/шин | 05:05/20:34 | 05:04/20:35 | 05:03/20:36 | 05:02/20:38 | 05:01/20:39 | 05:00/20:40 | 05:00/20:41 |
| Сар ург/шин | 21:38/06:19 | 22:30/07:03 | 23:17/07:53 | 23:59/08:50 | -/09:51 | 00:38/10:56 | 01:12/12:05 |

φ Лусын буулттай



дарам цөөн хэдэн улсын нэг. Тэдний сонгодог төлөөлөл нь монголчууд бид. Номт гурван улс ч гэж нэрлэдэг. Анагаах судлах шинжлэх ном арга нь ч Монголд байдаг. Хамгийн түрүүнд би сэтгэлийг ярьж байна. Бие бол амархан. Учир нь хүний бие бол үхэр юм уу, нохойны биетэй адилхан. Үхэр, нохойтой адилхан 2.4 тэрбум жил хувьсан өөрчлөгдөж, байгальтай зохицож ирсэн. Тиймээс илүү идэхгүй, байгаль дээр байдаг зүйлээ идээд, байгаль дээр 2 тэрбум жилийн турш магадгүй өвөг дээдсийн сая жилийн турш идэж боловсруулж ирсэн. Боловсруулж сурсан эрхтэн элэг, гэдсэндээ зохицсон тэр хоолоо илүү идэхгүй, аль болох өлсч идэж, сайн хөдөлж, сайн унтвал дахиад амар амгалан байж чадах л юм бол хүн эрүүл байна. Залуу нас ч урт байна. Амьдрал уртасч, өвдөх нь бага байна.

**-Жишээ нь, та ямар үед сэтгэл тайван байдаг вэ?**

-Би ямар ч үед сэтгэл тайван байхыг оролддог болсон. Яг одоо тантай ярилцаж байхдаа ч гүний гүндээ тайван амгалан байна.

**-Сэтгэл тайван бус байна аа гэдэг нь амар амгалан амьдрал байхгүй байна аа л гэсэн үг биз дээ?**

-Ер нь хоёр талтай л даа. Хувь хүний талаар ярьж байгаа нэг хэрэг. Лотус гэж цэцэг намаг балчиг өмхий дотор ном ногоон навч, түүндээ цагаан юм уу, ягаан гэрэл цацруулаад ургаж чаддаг ш дээ. Үүн шиг ямарч нийгмийн дунд, амьдралын дунд хувь хүн бол өөрөө сонгож, сураад дадаж чадах юм бол сэтгэлийн амар амгалан, түүгээрээ хувь хүний бөгөөд амьдралын амар амгаланг олж чадна. Гэхдээ хурдан, амар замаар биш. Үүний талаар сургууль ном бий. Харин нийгмээрээ сэтгэлийн амар амгаланг олох гэдэг өөр хэрэг. Гурван сая хүний олонх нь хувь хүнийхээ хувьд сэтгэлээ цэгцэлж, амар амгаланг олж, өөрийн мэдэх мэдэхгүй, муу муухай зүйлийн тухай, өөрийн ухамсар сэрэхүйгээрээ ярихаа болих цагт амар амгалан, аз жаргалтай амьдрал тогтох болов уу гэж боддог.

**-Таны ярилцлагыг уншаад сууж байгаа хүмүүс сэтгэлээ тайван, амар амгалан байлгахад зөвлөгөө өгөөч гэвэл та юу зөвлөх вэ?**

- Хэдийгээр би зөвлөгөө өгдөг ч гэсэн сэтгэлээ амар тайван байлгах гэдэг дээр зөвлөж чадахгүй, зөвлөх хэрэг ч байхгүй. Түрүүн хэлсэн сэтгэлийн тухай бүхэл бүтэн төгс төгөлдөр батлагдсан, нотлогдсон шинжлэх ухааныг гаргасан хүн байгаа. 2500 жилийн өмнө амьдарч байсан нэг залуу байгаа. Тэр хүн хамгийн энгийнээс эхлээд амьдралын туршдаа судлаад туршаад, нэвтрээд дадал болоод ирэхэд тийм амар биш тэр замыг заагаад өгчихсөн байгаа. Тарган хүн турахад тийм амар биш шүү дээ. Өвчтэй хүн эрүүл болох тийм амар зүйл биш. Үүнтэй л адил. Эвдрээд хямраад, Улаанчулуутын хогийн цэг шиг болсон сэтгэлээ цэгцэлж тогтоогоод амар амгалан болгох гэдэг удаан хугацааных. Сониуч

Зуны эхэн харагчин могой (их) сар, 5 шар мэнгэ, уул суудалтай
Зуны дунд хөх морь (бага) сар, 4 ногоон мэнгэ, мод суудалтай

2016 оны V-VI сар

| Билгийн өдөр, гараг | 24 | 25 | 26 | 27 | 28 φ | 29 | 30❹ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 30 | 31 | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | хар хулгана | харагчин үхэр | хөх бар | хөхөгчин туулай | улаан луу | улаагчин могой | Шар морь |
| Дүвзий од | 23 | 24 | 26 | 0 | 1 | 2 | 3 |
| Жэдзий од | 24 | 25 | 26 | 0 | 1 | 3 | 4 |
| Суудал | ус | уул | мод | хий | гал | шороо | төмөр |
| Мэнгэ | 1 цагаан | 9 улаан | 8 цагаан | 7 улаан | 6 цагаан | 5 шар | 4 ногоон |
| Барилдлага | үхэх | үхэх | рашаан | хотол чуулган | түлэх | шид | хүчин төгсөх |
| Шүтэн барилдлага | Авах | Хурьцах | Сэрэх | Хүрэлцэх | Тийн мэдэх | Хуран үйлдэх | Мунхаг |
| Нар ург/шин | 04:59/20:42 | 04:58/20:43 | 04:57/20:44 | 04:57/20:45 | 04:56/20:45 | 04:56/20:46 | 04:55/20:47 |
| Сар ург/шин | 01:44/13:16 | 02:15/14:29 | 02:46/15:44 | 03:18/17:00 | 03:54/18:17 | 04:34/19:31 | 05:21/20:41 |

φ Лусын буулттай ❹ Буудай боловсрох

Зуны дунд хөх морь (бага) сар, 4 ногоон мэнгэ, мод суудалтай

2016 оны VI сар

| Билгийн өдөр, гараг | 1 | 3☆ | 4☯ | 5▲∆ | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | шарагчин хонь | цагаан бич | цагаагчин тахиа | хар нохой | харагчин гахай | хөх хулгана | хөхөгчин үхэр |
| Дүвзий од | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| Жэдзий од | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| Суудал | огторгүй | ус | уул | мод | хий | гал | шороо |
| Мэнгэ | 3 хөх | 2 хар | 1 цагаан | 9 улаан | 8 цагаан | 7 улаан | 6 цагаан |
| Барилдлага | рашаан | хүчин төгсөх | үхэх | үл зохилдох | түлэх | түлэх | хүчин төгсөх |
| Шүтэн барилдлага | Хүрэлцэх | Сэрэх | Хурьцах | Авах | Сансар | Төрөх | Өтлөх үхэх |
| Нар ург/шин | 04:55/20:48 | 04:54/20:49 | 04:54/20:49 | 04:54/20:50 | 04:53/20:51 | 04:53/20:51 | 04:53/20:52 |
| Сар ург/шин | 06:14/21:43 | 07:13/22:36 | 08:17/23:20 | 09:22/23:58 | 10:28/- | 11:32/00:30 | 12:34/00:58 |

☆ Балжинням ☯ Дашням ∆ Тэрсүүд ▲ Модон хохимой

зангаасаа болж би олон янзын шашны ном, судрыг уншиж байсан. Америкийн их сургуульд Библийг хоёр жилийн турш судалж төгсч байв. Коран судар ч надад байна. Бахайн тухай ном ч бий. Бөөгийн тухай чадлаараа унших гээд л судалж байна. Бат-Отгон гуайн номноос эхлээд бөөтэй хүртэл уулзаад явж байна. Би яагаад энэ бүхнийг хийгээд судлаад байна гэхээр нэгдүгээрт сониуч зан. Хоёрт, хувь хүнийхээ хувьд өөрийнхөө сэтгэлийг ойлгох цэгцлэх гэж явсан зам гэх үү дээ. Буддын номыг бага балчир наснаасаа уншиж ирсэн. Энэ дундаас үнэхээр сэтгэлийн тухай шинжлэх ухаан бол буддизм. Сэтгэлээ хэрхэн цэгцэлж, олж, тогтоож, амгалан, хүчтэй, эрх чөлөөтэй болгож чадах уу гэдэг тэр сургууль агуу. Би бол гэгээрсэн хүн биш. Ер нь гэгээрэл гэдэг бол гэрэл асааж кноп дардаг шиг пад гээд нэг өдөр духан дээр нь бөөрөнхий гэрэл гарчихдаг ч зүйл биш. Будда ч гэсэн өөрөө 35 жил сэтгэлийн амар амгаланг олж авах гэж оролдсон, зургаан жил таг хөдөлгөөнгүй шахам бясалгал хийж арайхийж л гайгүй болсон. Түүнээс хойш ч бас төгөлдөржиж л явсан. Эрүүл мэнд ч гэсэн адилхан ш дээ. Өвчтэй бие тэр даруй эдгэрдэггүй. Нэг эмч үзээд нэг бөөрөнхий юм аманд нь хийгээд цоо эрүүл болно гэсэн зүйл байхгүй. Байгаль дээр тийм зүйл байдаггүй. Тиймээс л би сэтгэлийн амар амгаланг олох сургаалийг уншиж, судалж, дадах гэж оролдож байгаа. Миний энэ ярилцлагыг уншиж байгаа хүн бүхэн адилхан. Хүнд хамгийн түрүүнд сэтгэл л чухал. 70 юм уу 80 кг мах 20-30 жилийн дараа үхээд, үмхийрээд шороонд дарагдаад л алга болно. Харин сэтгэл бол байна. Бид биеийн махандаа их анхаардаг шүү дээ. Гоё даашинз өмсч, гоё бөгж зүүж, зангиа зүүгээд, хөмсгөө будаад ухаантай царай гаргадаг шиг сэтгэлээ анхаарч байгаасай. Хэрвээ ярилцлага уншиж байгаа бол та гартаа барьсан утсаа эсвэл, сонингоо тавиад 30-хан секундэд эргээд сэтгэлээ чагнаж үзээрэй. Энэ хооронд юу хуулирч байна. Сэтгэл чинь тогтож байна уу, ер нь сэтгэл байна уу үгүй юу түр чагнаад үзээрэй. Ингэж л зөвлөе дөө.

**-Сүүлийн үед зарим хүнийг мөнгө, албан тушаал л сэтгэлийг нь амар амгалан тайван болгодог болоод байгаа юм биш үү?**

-Албан тушаал, мөнгө тэр хүний сэтгэлийг цэгцлэхгүй. Магадгүй гудамжинд гуйлга гуйгаад сууж байгаа залуу сэтгэлдээ асар гүн даянд орсон, биднээс тув тунгалаг амгалан тогтуун сэтгэлтэй хүн байхыг үгүйсгэхгүй. Яагаад гэвэл олон жил гуйлга гуйхаас өөр юу ч хийхгүй зөвхөн сэтгэлээ тогтоогоод судлаад сэтгэлийн амар амгалан олсон байж магадгүй. Өөрөөр хэлбэл, мөнгөтэй албан тушаалтай хэрнээ сэтгэл нь тогтоогүй, мөнхийн стресстэй нэг даргын хажууд гуйлга гуйж яваа тэр залуу илүү эрүүл байгаа. Яагаад гэвэл тэр хүн сэтгэл амгалан байгаа учраас. Тэгэхээр сэтгэлийн амар амгаланг олохыг хэн ч хийж болно.

**-Сэтгэлээ цэгцэлж, чадахгүй, амар тайван байдлаа олж авч чадахгүй байгаа нь тухай хүний эрүүл мэндэд нөлөөлөх үү. Өөрөөр хэлбэл, сэтгэл тайван бус байгаагаас өвчин үүсэх үү?**

-Ер нь өвчин үүсэх сэдэл сэтгэлтэй холбоотой байдаг. Би сүрхий мундаг, хэтэрхий сониучдаа ч үүнийг үзэж байсан юм биш. Би эмч хүн. Миний мэргэжил, амьдрал бол хүний л эмч. Гэхдээ хүний эмч гэдэг нь дахиад нөгөө 70 кг махны

**Зуны дунд хөх морь (бага) сар, 4 ногоон мэнгэ, мод суудалтай** — 2016 оны VI сар

| Билгийн өдөр, гараг | 9 | 9 | 10 φ | 11 | 12 | 13 | 14 φ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | улаан бар | улаагчин туулай | шар луу | шарагчин могой | цагаан морь | цагаачин хонь | хар бич |
| Дүвзий од | 11 | 12 | 13 | 13 | 14 | 15 | 16 |
| Жэдзий од | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 |
| Суудал | төмөр | огторгуй | ус | уул | мод | хий | гал |
| Мэнгэ | 5 шар | 4 ногоон | 3 хөх | 2 хар | 1 цагаан | 9 улаан | 8 цагаан |
| Барилдлага | үл зохилдох | хүчин төгсөх | үл зохилдох | хотол чуулган | түлэх | шид | түлэх |
| Шүтэн барилдлага | Мунхаг | Сансар | Хуран үйлдэх | Тийн мэдэх | Нэр өнгө | Төрөн түгэх | Хүрьцах |
| Нар ург/шин | 04:53/20:52 | 04:53/20:53 | 04:53/20:53 | 04:53/20:54 | 04:53/20:54 | 04:53/20:55 | 04:53/20:55 |
| Сар ург/шин | 13:36/01:24 | 14:36/01:49 | 15:36/02:14 | 16:36/02:41 | 17:35/03:09 | 18:34/03:41 | 19:31/04:17 |

φ Лусын буулттай

**Зуны дунд хөх морь (бага) сар, 4 ногоон мэнгэ, мод суудалтай** — 2016 оны VI сар

| Билгийн өдөр, гараг | 15 | 16● | 17 | 18 | 19 φ | 20 φ | 21 φ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | харагчин тахиа | хөх нохой | хөхөгчин гахай | улаан хулгана | улаагчин үхэр | шар бар | шарагчин туулай |
| Дүвзий од | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 |
| Жэдзий од | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 |
| Суудал | шороо | төмөр | огторгуй | ус | уул | мод | хий |
| Мэнгэ | 7 улаан | 6 цагаан | 5 шар | 4 ногоон | 3 хөх | 2 хар | 1 цагаан |
| Барилдлага | рашаан | үхэх | идэр | үл тохирох | идэр | шид | арвидах |
| Шүтэн барилдлага | Авах | Хүрэлцэх | Төрөн түгэх | Нэр өнгө | Тийн мэдэх | Хуран үйлдэх | Мунхаг |
| Нар ург/шин | 04:53/20:55 | 04:53/20:55 | 04:53/20:55 | 04:54/20:56 | 04:54/20:56 | 04:54/20:56 | 04:55/20:56 |
| Сар ург/шин | 20:25/05:00 | 21:15/05:48 | 22:00/06:43 | 22:40/07:43 | 23:16/08:48 | 23:49/09:56 | -/11:06 |

φ Лусын буулттай ● Зуны туйл

эмч биш. Зүүн чих юм уу баруун гар, эсвэл хөлийн хумсны юм уу, зүрх судасны эмч биш, хүний л эмч. Би бага зэрэг хүндрүүлж ойлгож байж магадгүй. Би хүний зөвхөн махан биеийг үзээд зогсдоггүй. Түүний цаад шалтгаан нь яг таны асуусан шиг цаад сэтгэлийн асуудал байдаг. Ер нь өвчин бол заавал байна. Хүн амьтан заавал л үхнэ. Үхдэггүй, төгсгөлгүй юм гэж хорвоо дэлхий дээр байхгүй. Ертөнц өөрөө төгсөөд дараагийнх нь эхэлдэг гэсэн онолоор явдаг. Тэгэхээр төгсөхийн тулд эвдрэх, хэмхрэх ёстой. Сэтгэл мөн адил нэг амьдралыг дуусгаад дараагийнх руугаа хувираад хувьсаад сүнс бодог юм уу яадгийн тэгээд л явдаг. Тэгэхээр хавдраар байна уу, ханиад байна уу гэдэг хамаагүй. Харин залуу насандаа өвдөөд байвал утгагүй. Би одоо 52 настай. Би өдий хүртэл ядарч байна гэж хэлж үзээгүй, өвдөх ч бага байна. Залуу байхдаа хэдэн өдрөөр нойргүй явсан ч ядарч байна гэж хэлж үзээгүй. Энд сэтгэл амар амгалан, тайван байсан нь нөлөөлдөг.

**-Муу зүйл бодож, муу үг хэлнэ гэдэг нь өөрөө сэтгэлийн амар амгаланг бусниулагч юм байна гэж бодлоо. Зөв үү?**

-Үнэн, үнэн. Дүрслээд хэлбэл хүний сэтгэл болор бөмбөлөг шиг тунгалаг гэрэлтэй. Хүүхэд байхад яг тийм байдаг. Харин томрох тусам бага багаар сэвтэж, хар цагаан зураасууд үүсч эхэлдэг. Заримдаа бүр цав үсэрдэг. Үүнийг буцааж эвлүүлж болно. Аль болох мэдсэнээсээ хойш аль болох сэвтүүлэхгүй, харлуулахгүй хог цуглуулахгүй байх хэрэгтэй. Жишээ нь, би гурван жилийн өмнө твийтрийн нэг нэвтрүүлэгт орохдоо хэлж байсан юм. Твийтр бол дэлхий даяар хэдэн сая хүн хэрэглэдэг, энэ дотор гайхамшигтай эрдэнэс ч яваа, манай цаг үеийн хамгийн гайхамшигтай хүмүүс ч үгээ хэлж байгаа. Түүн дотроос нь заавал хараал, хов жив новшийг нь цуглуулах уу гэдэг чинь өөрийн тань сонголт. Ер нь аливаа зүйлийн муу муухайг нь биш сайн сайхныг харж явах ёстой. Сайн сайхныг бодож хийгээд амьдарч болно. Тэгж байж л гурван сая хүн нэгнээсээ, амьдралаас, ширээн дээр байгаа аяганаас хүртэл гэрэл гэгээтэй сайн юмыг нь олж харж сурч байж энэ нийгэм арай өөрөг сэтгэхгүйгээр харж чаддаг болно. Нэгэн рүүгээ харж инээмсэглэдэг болно, хэн нэгнийг хараад баярладаг болно. Тэгэхгүй бол гурван сая мангас авчраад дунд нь бөмбөг тавьсан юм шиг амьдарч байна. Энэ нь бидний л хохь болж хоцорно ш дээ.

**-Надад хандаж муу үг хэлээгүй ч гэсэн хажууд тэрийгээ ярьснаас болж тэр үг нь, үйлдэл нь надад сөргөөр нөлөөлөөд байвал яах вэ?**

-Өөртөө тусгаж, хүлээж авахгүй байх хэрэгтэй. Хажууд чинь хүн ярих битгий хэл чам руу муу үгээр дайрч доромжилж байсан өөртөө хүлээж авахгүй бол тэр хүндээ үлдэнэ.

**-Таргалалт эрс нэмэгдэж байгаа нь буруу хооллолтоос л үүдэлтэй юу?**

-Талх, шарсан төмс, боорцог их иддэг хүмүүс таргалах нь элбэг байна. 1990 оноос өмнө монголчуудын дунд тарган хүн маш ховор байсан. Сургуульд нэг тарган хүүхэдтэй, 300-400 ажилтантай компани нэг тарган хүнтэй, сумд нэг тарган хүндтэй байдаг байв. 1990 онд ардчилсан хувьсгалын жагсаалыг гарахад тухайн үеийн хүмүүс эрүүл саруул, чийрэг харагдаж байгаа. Энэ нь монголчууд уламжлалт хооллолтоороо явсны л үр дүн. 1990-ээд оны төгсгөлөөс явсаар өдөрт гурван удаа хооллодог болсон байна.

**Зуны дунд хөх морь (бага) сар, 4 ногоон мэнгэ, мод суудалтай** — 2016 оны VI –VII сар

| Билгийн өдөр, гараг | 22 φ | 23 φ | 24 φ | 26 | 27 | 28 | 29 φ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 27 | 28 | 29 | 30 | 1 | 2 | 3 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | цагаан луу | цагаагчин могой | хар морь | харагчин хонь | хөх бич | хөхөгчин тахиа | улаан нохой |
| Дүвзий од | 24 | 25 | 26 | 0 | 1 | 2 | 4 |
| Жэдзий од | 25 | 26 | 0 | 1 | 2 | 3 | 4 |
| Суудал | гал | шороо | төмөр | огторгуй | ус | уул | мод |
| Мэнгэ | 9 улаан | 8 цагаан | 7 улаан | 6 цагаан | 5 шар | 4 ногоон | 3 хөх |
| Барилдлага | рашаан | үхэх | үл зохилдох | хүчин төгсөх | түлэх | шид | хүчин өгсөх |
| Шүтэн барилдлага | Өтлөх үхэх | Төрөх | Сансар | Авах | Хурьцах | Сэрэх | Нэр өнгө |
| Нар ург/шин | 04:55/20:56 | 04:56/20:56 | 04:56/20:55 | 04:57/20:55 | 04:57/20:55 | 04:58/20:55 | 04:59/20:54 |
| Сар ург/шин | 00:19/12:17 | 00:49/13:30 | 01:20/14:43 | 01:53/15:58 | 02:30/17:11 | 03:12/18:21 | 04:00/19:26 |

φ Лусын буулттай

**Зуны дунд хөх морь (бага) сар, 4 ногоон мэнгэ, мод суудалтай**
**Зуны адаг хөхөгчин хонь (бага) сар, 3 хөх мэнгэ, хий суудалтай** — 2016 оны VII сар

| Билгийн өдөр, гараг | 30 φ | 1 | 2 | 3△☺ | 4 × | 5☯× | 6▲× |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | улаагчин гахай | шар хулгана | шарагчин үхэр | цагаан бар | цагаагчин туулай | хар луу | харагчин могой |
| Дүвзий од | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 10 |
| Жэдзий од | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| Суудал | *хий* | гал | шороо | төмөр | огторгуй | ус | уул |
| Мэнгэ | 2 хар | 1 цагаан | 9 улаан | 8 цагаан | 7 улаан | 6 цагаан | 5 шар |
| Барилдлага | рашаан | хүч | үхэх | үл зохилдох | түлэх | түлэх | хүчин төгсөх |
| Шүтэн барилдлага | Тийн мэдэх | Сэрэх | Хурьцах | Авах | Сансар | Төрөх | Өтлөх үхэх |
| Нар ург/шин | 04:59/20:54 | 05:00/20:54 | 05:01/20:53 | 05:02/20:53 | 05:02/20:52 | 05:03/20:52 | 05:04/20:51 |
| Сар ург/шин | 04:56/20:24 | 05:57/21:13 | 07:03/21:54 | 08:09/22:29 | 09:15/22:59 | 10:19/23:27 | 11:22/23:53 |

☯ Дашням φ Лусын буулттай △ Тэрсүүд ▲ Модон хохимой ☺ Бага халуун × Усанд хор орно. Гол мөрний усанд бүү ор.

ТОР АНАЛИЗ

# ӨДӨРТ 100 ЛИТР СҮҮ ӨГДӨГ "СУПЕР" ҮНЭЭ



Монголчууд бид өнө эртнээс таван хошуу малаа өсгөн үржүүлж, тэдгээрийнхээ үржил шимийг өдөр тутмынхаа амьдралд хүртэж, ууж идэн, эдэлж хэрэглэж ирсэн уламжлалтай ард түмэн билээ.

Таван хошуу мал дотроос үржил шим ихтэйгээс гадна дэлхий дахинд хөдөө аж ахуйн үйлдвэрүүдэд хамгийн их үржүүлж, өсгөдөг нь үхэр. Манай улс бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг бол барууны улсуудад эрчимжсэн мал аж ахуй зонхилдог. Эрчимжсэн мал аж ахуй эрхэлдэг дэлхийн улс орнуудын үнээний фирм, махны үйлдвэрүүдийн талаар сонирхолтой баримтуудыг хүргэе.

Австрали, Израиль зэрэг хөдөө аж ахуй өргөн дэлгэрсэн орнуудад сүүний фирмүүд маш их байдаг. Тэднээс Австралийн фирмийн нэг үхэр өдөрт дунджаар 15 литр сүү өгдөг бол Израильд нэг үхрээс өдөрт дунджаар 32 литр сүү авдаг аж. Тус орнууд томоохон сүүний фирмүүдтэй бөгөөд тусгай бэлтгэсэн тэжээлээр үхрээ тэжээж, тусгай технологиор саадаг юм.

АНУ бол өдөр тутмын сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч орон. Тус улсын үхрийн үүлдрүүдийг хамгийн ашиг шим ихтэй гэдэг. Америкууд сүүний шим тэжээлийн агууламжид их анхаарал хандуулдаг бөгөөд тусгай технологийн дагуу тухайн сүүнд байгаа ураг, амин дэмийн хэмжээг нарийвчлан тогтоож худалдаанд гаргадаг. АНУ-ын сүүний фирмүүд дунд Европ, Хойд Америкийн эрлийз тарлан үхэр буюу алаг үнээ түгээмэл байдаг бөгөөд уг үүлдрийн үнээгилүү их сүүтэй байдаг хэмээн үздэг байна. "Холстейн" хэмээн нэрлэдэг уг үүлдрийн алаг үнээ төрөхдөө 40-45 кг жинтэй төрдөг бөгөөд бяруу 360 кг, нас бие гүйцсэн үхэр хамгийн багадаа хагас тонн буюу 580 кг, хамгийн ихдээ 650 кг жин татдаг байна. Ердийн өндөр нь дунджаар 147 см байдаг аж.

АНУ-ын жирийн сүүний фирмүүд нэг үхрээс өдөрт дунджаар 30 литр сүү авдаг бол тус улсын хамгийн том сүүний үйлдвэр "Висконсин" нэг үнээнээс өдөрт дунджаар 85-87 литр сүү гаргадаг байна. Мэдээж ураг, тэжээл нь байгалийн гаралтай бус үхэрт тусгайлан бэлтгэсэн нэмэлт тэжээл байдаг юм.

АНУ-д 1944 онд 25.6 сая үхэртэй гэх тооцоо байсан бол өнөөдөр ердөө 9.3 сая үхэртэй болжээ. Хэдий малын тоо толгой буурсан ч ашиг шим нь ихэссэн хэмээн үздэг байна.

-Тухайн хүний хоол боловсруулах замын микрофлор буюу ашигтай бактери муу байснаас болж хоол хүнсний харшил үүсдэг. Монголчуудын хувьд хамгийн сайн микрофлорыг дэмжих хүнс юу байна гэхээр маш сайн бактеритай тараг л уух байгаа юм. Тараг нь хоол боловсруулах замыг тэнцвэртэй байлгаж өгдөг. Ер нь хоол боловсруулах зам нь л тэнцвэртэй байвал тэр хүний дархлаа, хоолны боловсруулалт сайн, дээрээс нь харшил бага үүсдэг. Тэр тусмаа хүмүүс зуны улиралдаа цагаан идээ, айраг, тараг хэрэглэж байвал зүгээр.

**Өвлийн дунд цагаан хулгана (их) сар, 7 улаан мэнгэ, ус суудалтай** — **2016 оны XII сар**

| Билгийн өдөр, гараг | 13 | 14 φ | 16▲ | 17 | 18 | 19 | 20 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | шар луу | шарагчин могой | цагаан морь | цагаагчин хонь | хар бич | харагчин тахиа | хөх нохой |
| Дүвзий од | 1 | 2 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Жэдзий од | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Суудал | гал | шороо | төмөр | огторгуй | ус | уул | мод |
| Мэнгэ | 3 хөх | 2 хар | 1 цагаан | 9 улаан | 8 цагаан | 7 улаан | 6 цагаан |
| Барилдлага | үхэх | түлэх | үл зохилдох | үл зохилдох | үл тохирох | түлэх | үхэх |
| Шүтэн барилдлага | Хуран үйлдэх | Тийн мэдэх | Өтлөх үхэх | Төрөх | Сансар | Авах | Хурьцах |
| Нар ург/шин | 08:33/17:00 | 08:34/17:00 | 08:34/17:00 | 08:35/17:00 | 08:36/17:00 | 08:37/17:00 | 08:37/17:01 |
| Сар ург/шин | 16:04/05:46 | 16:51/07:02 | 17:45/08:14 | 18:47/09:19 | 19:53/10:14 | 21:02/11:00 | 22:10/11:39 |

φ Лусын буулттай ▲ Модон хохимой

**Өвлийн дунд цагаан хулгана (их) сар, 7 улаан мэнгэ, ус суудалтай** — **2016 оны XII сар**

| Билгийн өдөр, гараг | 21 φ | 22 | 23△♇ | 24 | 25 | 26 | 27☯ φ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | хөхөгчин гахай | улаан хулгана | улаагчин үхэр | шар бар | шарагчин туулай | цагаан луу | цагаагчин могой |
| Дүвзий од | 9 | 10 | 11 | 11 | 12 | 13 | 14 |
| Жэдзий од | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 |
| Суудал | *хий* | гал | шороо | төмөр | огторгуй | ус | уул |
| Мэнгэ | 5 шар | 4 ногоон | 3 хөх | 2 хар | 1 цагаан | 9 улаан | 8 цагаан |
| Барилдлага | үхэх | арвидах | үл зохилдох | хотол чуулган | үл тохирох | үл тохирох | арвидах |
| Шүтэн барилдлага | Сэрэх | Хүрэлцэх | Төрөн түгэх | Нэр өнгө | Тийн мэдэх | Хуран үйлдэх | Мунхаг |
| Нар ург/шин | 08:38/17:01 | 08:39/17:02 | 08:39/17:02 | 08:40/17:03 | 08:40/17:03 | 08:40/17:04 | 08:41/17:04 |
| Сар ург/шин | 23:17/12:11 | -/12:40 | 00:22/13:06 | 01:25/13:31 | 02:26/13:56 | 03:26/14:22 | 04:26/14:51 |

φ Лусын буулттай ☯ Дашням △ Тэрсүүд ♇ Өвлийн туйл

# МАНЗУШИР ХУТАГТ САНГИЙН ТЭРГҮҮН

VII Манзушир хутагт Данзанжамъяндоржийн “Манзушир хутагт сан”-г 2011 оны дөрөвдүгээр сарын 6-нд байгуулсан билээ. Сангийн тэргүүнээр УИХ-ын дэд дарга, МАН-ын дарга М.Энхболд ажиллаж байна. “Манзушир хутагт сан” нь Хутагтыг суралцах боломжоор хангаж улмаар Хутагтын үйл хэргийг дэлгэрүүлэх, Бурхан багшийн ариун сургаалийг олон түмэнд үнэн зөвөөр ойлгуулан таниулах зорилготой юм. Энэ хугацаанд сангийн зүгээс Манзушир хутагт гэгээнтэнийг Өмнөд Энэтхэгийн ДашГоман дацангийн арслант ширээнд залах Чойшүг хурал хуруулах, Гэгээнтэний номын өргөө буюу лаврант Энэтхэгт барьж байгуулах зэрэг томоохон ажлуудыг хийгээд байна.



Түүнчлэн УИХ-ын дэд дарга М.Энхболдын Монголын бурхан шашны төв Гандантэгчэнлин хийдээс зохион байгуулсан үндэсний шашин, соёлын арга хэмжээнд дэмжлэг үзүүлэн оролцдог. Тэрээр Монголын бурханы шашин, соёлын төв цогчин уншлагын Батцагаан дуган барих ажлыг дэмжин улсын төсвөөс хөрөнгө мөнгийг шийдүүлэх ажилд тусалсан. Бурхан багшийн гэгээрэл хутгийг олсон Энэтхэгийн Бодгаяад бүтээн барьж буй Монгол сүмд хандив өргөсөн. Дээрхийн гэгээн IX Богд Жэвзүндамба хутагтын Үндэсний эрх чөлөөний хувьсгалын 100 жилийн ойд зориулж санаачилсан Манзушир бурханыг өөрийн шадар нөхдийн хамт бүтээсэн. Сандуйн жүд, Доржзодов буюу Очироор огтлогч, Цэнд, Манал, Гурван гүрэм тэргүүтэй их хөлгөн судруудыг жил бүр олон мянган хувиар хэвлэн ард олонд үнэгүй түгээн өгдөг. Өмнөд Энэтхэгийн Гоман дацанд сурч буй монгол лам нарт тусалдаг. Жил бүрийн цагаан сараар Гандан хийдийн нандин шүтээн Очирдара бурханд мандал өргөн хурал хуруулдаг. Жил бүр Гандан хийдэд нэгээс хоёр хурлыг даан хуруулдаг. Гандантэгчэнлин хийдэд урилгаар ирсэн гадаадын шашны зүтгэлтнүүдийг хүндэтгэн хүлээн авч Гандан хийдэд тусалж байсан билээ. Төв аймгийн Баян сумын Бамбар эрдэнэ хувилгааны хийдийг сэргээн байгуулж өгсөн. Төв аймгийн Дэлгэрхаан сумын Норовчойнпэллин хийдэд хандив өргөсөн. Бүрэн сумын хийдэд хандив өргөж мандал бүтээсэн байдаг. Төв аймгийн төвийн хийдэд Богд Зонхова хоёр шавийн хамт өргөсөн. Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт суварга бүтээжээ. Төв аймгийн Баян сумын нутагт гурван суварга бүтээсэн. Гандантэгчэнлин хийдийн Эрдэм соёлын хүрээлэнгийн “Лавайн эгшиг” сэтгүүлийг ивээн тэтгэж хэвлүүлсэн юм.

**Өвлийн дунд цагаан хулгана (их) сар, 7 улаан мэнгэ, ус суудалтай**
**Өвлийн дунд цагаан хулгана ИЛҮҮ (бага) сар**

**2016 оны XII-2017 оны I сар**

| Билгийн өдөр, гараг | 28 | 29 | 29 | 30 | 1* | 2 | 3 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 26 | 27 | 28 | 29 | 30 | 31 | 1 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | хар морь | харагчин хонь | хөх бич | хөхөгчин тахиа | улаан нохой | улаагчин гахай | шар хулгана |
| Дүвзий од | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 |
| Жэдзий од | 16 | 17 | 18 | 19 | 20 | 20 | 21 |
| Суудал | мод | хий | гал | шороо | төмөр | огторгуй | ус |
| Мэнгэ | 7 улаан | 6 цагаан | 5 шар | 4 ногоон | 3 хөх | 2 хар | 1 цагаан |
| Барилдлага | идэр | түлэх | рашаан | үл зохилдох | шид | шид | түлэх |
| Шүтэн барилдлага | Сансар | Авах | Сэрэх | хурьцах | Өтлөх үхэх | Мунхаг | Хуран үйлдэх |
| Нар ург/шин | 08:41/17:05 | 08:41/17:06 | 08:42/17:07 | 08:42/17:07 | 08:42/17:08 | 08:42/17:09 | 08:42/17:10 |
| Сар ург/шин | 05:25/15:23 | 06:23/15:59 | 07:18/16:41 | 08:10/17:29 | 08:58/18:23 | 09:41/19:21 | 10:19/20:24 |

* Балжинням

**Өвлийн дунд цагаан хулгана ИЛҮҮ (бага)сар**

**2017 оны I сар**

| Билгийн өдөр, гараг | 4 | 5 | 6 | 7 φ♁ | 8 φ | 10 | 11 φ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | шарагчин үхэр | цагаан бар | цагаагчин туулай | хар луу | харагчин могой | хөх морь | хөхөгчин хонь |
| Дүвзий од | 22 | 23 | 24 | 25 | 26 | 0 | 1 |
| Жэдзий од | 22 | 23 | 25 | 26 | 0 | 1 | 2 |
| Суудал | уул | мод | хий | гал | шороо | төмөр | огторгуй |
| Мэнгэ | 9 улаан | 8 цагаан | 7 улаан | 6 цагаан | 5 шар | 4 ногоон | 3 хөх |
| Барилдлага | рашаан | түлэх | рашаан | үл зохилдох | тохирох | түлэх | арвидах |
| Шүтэн барилдлага | Тийн мэдэх | Нэр өнгө | Төрөн түгэх | Хүрэлцэх | Сэрэх | Хурьцах | Авах |
| Нар ург/шин | 08:42/17:11 | 08:42/17:12 | 08:42/17:13 | 08:42/17:14 | 08:41/17:15 | 08:41/17:17 | 08:41/17:18 |
| Сар ург/шин | 10:53/21:30 | 11:24/22:38 | 11:54/23:47 | 12:22/- | 12:52/00:58 | 13:23/02:10 | 13:59/03:24 |

φ Лусын буултгай ♁ Бага хүйтэн

# ОЛИМП

М.Энхболд Үндэсний олимпийн хорооны гишүүнээр ажиллаж байх хугацаандаа 2008 оны Олимпийн их наадамд оролцох Монгол Улсын шигшээ багийн санхүүжилтийг шийдвэрлэх, тамирчдын ахуй хангамж, бэлтгэл хангах нөхцөл байдлыг сайжруулах тал дээр онцгой анхааран, олимпийн багийг ахлаж ажиллажээ. 2007 онд Шадар сайдаар ажиллаж байх хугацаандаа Үндэсний хорооны дэргэд Олимпийн наадамд бэлтгэх “Олимп хөгжил” санг байгуулсан юм. Энэ хүрээнд байгууллага, иргэдээс хандив цуглуулж, 2007 онд нийт 190 сая төгрөгийг хуримтлуулсан байдаг. Ингэснээр тамирчдын бэлтгэлээ хангахад учирдаг саад, бэрхшээлийг шийдэж чадсан.

2008 онд Бээжин хотноо болсон Олимпоос Найдангийн Түвшинбаяр Монгол Улсын анхны алтан медалийг жүдог бөхийн төрлөөр хүртэж ард түмнээ баярлуулж байсан билээ. Түүнчлэн боксын 54 кг-ийн жинд Монгол Улсын тамирчин Э.Бадар-Ууган алтан медаль авчирч дэлхийд эх орныхоо нэрийг мандуулж, төрийн дуулдаа Олимпийн ногоон дэвжээнээ эгшиглүүлж чадсан юм. Мөн тухайн жил буудлагын спортын мастер О.Гүндэгмаа мөнгөн медаль, боксын төрөлд П.Сэрдамба мөнгөн медаль авчирч, хөдөлмөрийн үр шимээ хүртэж байсан юм. Уг Олимпод Монгол Улс өмнө нь нэг ч алтан медаль авч байгаагүй орнуудаас медалийн чанараараа тэргүүлсэн байдаг.



Үүний дараагийн олимп буюу “Лондон-2012” олимпийн наадамд оролцох Монгол Улсын баг, тамирчдын ахлагчаар тухайн үеийн Шадар сайд, “Олимп хөгжил” сангийн тэргүүн  М.Энхболд ажилласан юм. Уг Олимпоос жүдогийн төрлөөр С.Ням-Очир хүрэл медаль, Н.Түвшинбаяр мөнгөн медаль, чөлөөтийн тамирчин С.Батцэцэг, боксын тамирчин У.Мөнх-Эрдэнэ нар тус бүр хүрэл медаль, боксын тамирчин Н.Төгсцогт мөнгөн медаль хүртэж амжилтаа ахиулж байсан нь тамирчдын үндсэн бэлтгэлийг сайтар хангасантай холбоотой гэж болох юм.

**Өвлийн дунд цагаан хулгана ИЛҮҮ (бага) сар** — **2017 оны I сар**

| Билгийн өдөр, гараг | 12 | 13 | 14 | 15 φ | 16▲ | 17 | 18 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | улаан бич | улаагчин тахиа | шар нохой | шарагчин гахай | цагаан хулгана | цагаагчин үхэр | хар бар |
| Дүвзий од | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Жэдзий од | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| Суудал | ус | уул | мод | хий | гал | шороо | төмөр |
| Мэнгэ | 2 хар | 1 цагаан | 9 улаан | 8 цагаан | 7 улаан | 6 цагаан | 5 шар |
| Барилдлага | идэр | хүчин төгсөх | рашаан | хотол чуулган | түлэх | идэр | арвидах |
| Шүтэн барилдлага | Сансар | Төрөх | Хуран үйлдэх | Тийн мэдэх | Өтлөх үхэх | Төрөх | Сансар |
| Нар ург/шин | 08:40/17:19 | 08:40/17:20 | 08:40/17:21 | 08:39/17:23 | 08:38/17:24 | 08:38/17:25 | 08:37/17:27 |
| Сар ург/шин | 14:40/04:38 | 15:29/05:51 | 16:25/06:58 | 17:29/07:58 | 18:37/08:49 | 19:47/09:32 | 20:57/10:09 |

φ Лусын буулттай ▲ Модон хохимой

**Өвлийн дунд цагаан хулгана ИЛҮҮ (бага) сар** — **2017 оны I сар**

| Билгийн өдөр, гараг | 19 | 20 | 21 φ | 22 | 23△☃ | 24 | 25 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | харагчин туулай | хөх луу | хөхөгчин могой | улаан морь | улаагчин хонь | шар бич | шарагчин тахиа |
| Дүвзий од | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 |
| Жэдзий од | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 |
| Суудал | огторгуй | ус | уул | мод | хий | гал | шороо |
| Мэнгэ | 4 ногоон | 3 хөх | 2 хар | 1 цагаан | 9 улаан | 8 цагаан | 7 улаан |
| Барилдлага | үхэх | хүчин төгсөх | үл зохилдох | хотол чуулган | үл тохирох | түлэх | түлэх |
| Шүтэн барилдлага | Авах | Хүрьцах | Сэрэх | Хүрэлцэх | Төрөн түгэх | Нэр өнгө | Тийн мэдэх |
| Нар ург/шин | 08:37/17:28 | 08:36/17:30 | 08:35/17:31 | 08:34/17:32 | 08:33/17:34 | 08:32/17:35 | 08:32/17:37 |
| Сар ург/шин | 22:04/10:40 | 23:09/11:08 | -/11:34 | 00:13/11:59 | 01:14/12:25 | 02:15/12:53 | 03:14/13:23 |

φ Лусын буулттай △ Тэрсүүд ☃ Их хүйтэн

# МОНГОЛЫН МОРИН СПОРТ, УЯАЧДЫН ХОЛБОО ЭРИЙН ЦЭЭНД ХҮРЛЭЭ







Монголын морин спорт, уяачдын холбоог 1995 оны хавар Төв аймгийн Баянжаргалан сумaнд адуучны отрын бор гэрт удамт өвгөдийнхөө үйл хэргийг түүчээлэн яваа морины зүтгэлтнүүд үүсгэн байгуулах санаачилга тавьж, тухайн оныхоо тавдугаар сарын 25-нд Анхдугаар их хурлаа хийж байсан түүхтэй. Энэ жил 20 насны босгыг давж, эрийн цээнд хүрсэн тус холбоо Монголын Үндэсний Олимпийн хорооны гишүүн, Азийн морин уралдааны холбооны гишүүн, Дэлхийн морин уралдааны холбооны гишүүнчлэлтэй, 21 аймаг, нийслэл Улаанбаатар хот, 330 сум суурин, зургаан дүүрэгт салбар холбоотой, 100 мянга гаруй гишүүнтэй Монгол Улсын хамгийн том төрийн бус байгууллага болжээ.

М.Энхболд нь 2008 оноос Монголын морин спорт, уяачдын холбооны ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байна.

Энэ хугацаанд Монголын морин спорт, уяачдын холбооны Азийн морин уралдааны холбоонд гишүүнээр элсүүлэх ажил, Дэлхийн морин уралдааны холбооны гишүүн уяачдыг бүртгэлжүүлэх, уяачдын хөдөлмөрийг үнэлэх, уралдаанч хүүхдүүдийг спортын зэрэг цол олгох, салбар хороодын ажлыг идэвхижүүлэх, улс бүсийн чанартай томоохон уралдаануудыг Засгийн газрын тогтоолоор зохион байгуулдаг болгож цэгцэлсэн. “Хурдан морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас хэрэглэлийн стандарт батлуулах, хүүхэдгүй уралдсан морийг тав ухрааж барих, монгол болон эрлийз морьдыг тусад нь уралдуулах, Монгол уяач, 3000 аймаг сумдын зөвлөлгөөн зэрэг олон ажлуудыг санаачлан зохион байгуулсан.

Хубилай хаан 1263 онд төрийн тогтолцоондоо Адууны яам байгуулсны түүхт 850 жилийн ойн хүрээнд 2013 оны наймдугаар сарын 9,10-нд Улаанбаатар хотод “4249 хурдан морины уралдаан”, “11125 морьтны их жагсаал зохион байгуулж дэлхийн дээд амжилтыг тогтоож Гиннесийн номонд бичигдэж, Монгол Улс дэлхийн дээд амжилтыг хоёр төрлөөр эзэмшиж байна.

Энэ жил ММСУХ-ны түүхт 20 жилийн ой тохиосон юм. Үүнтэй холбогдуулан холбооны тулгын чулуугаа асаасан голомт болох Төв аймгийн Баянжаргалан сумын Сайн Хөөтийн Адуун чулуу гэдэг газарт холбооны логог чулуун суурин дээр товойлгон зэсээр цутгасан хөшөөг бүтээж, 2015 оны дөрөвдүгээр сарын 20-ны өдөр нээлтээ хийлээ.

**Өвлийн дунд цагаан хулгана ИЛҮҮ (бага) сар**
**Өвлийн адаг цагаагчин үхэр (их) сар, 6 цагаан мэнгэ, уул суудалтай**

**2017 оны I сар**

| Билгийн өдөр, гараг | 26 | 27 φ◐ | 28 | 29 | 30 | 1 | 2 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 | 29 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | цагаан нохой | цагаагчин гахай | хар хулгана | харагчин үхэр | хар бар | хөхөгчин туулай | улаан луу |
| Дүвзий од | 16 | 17 | 18 | 19 | 19 | 20 | 21 |
| Жэдзий од | 17 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 |
| Суудал | төмөр | огторгуй | ус | уул | мод | хий | гал |
| Мэнгэ | 6 цагаан | 5 шар | 4 ногоон | 3 хөх | 2 хар | 1 цагаан | 9 улаан |
| Барилдлага | идэр | түлэх | рашаан | үл зохилдох | шид | шид | үхэх |
| Шүтэн барилдлага | Хуран үйлдэх | Мунхаг | Сансар | Авах | Хурьцах | Мунхаг | Хуран үйлдэх |
| Нар ург/шин | 08:31/17:38 | 08:30/17:40 | 08:28/17:41 | 08:27/17:43 | 08:26/17:45 | 08:25/17:46 | 08:24/17:48 |
| Сар ург/шин | 04:13/13:58 | 05:09/14:37 | 06:03/15:22 | 06:52/16:14 | 07:38/17:11 | 08:18/18:14 | 08:55/19:20 |

φ Лусын буултай ◐ Дашням

**Өвлийн адаг цагаагчин үхэр (их) сар, 6 цагаан мэнгэ, уул суудалтай**

**2017 оны I-II сар**

| Билгийн өдөр, гараг | 3 | 4 | 5 | 6 | 7° | 8 | 9★ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 30 | 31 | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | улаагчин могой | шар морь | шарагчин хонь | цагаан бич | цагаагчин тахиа | хар нохой | харагчин гахай |
| Дүвзий од | 22 | 23 | 24 | 25 | 0 | 1 | 2 |
| Жэдзий од | 23 | 24 | 25 | 26 | 0 | 1 | 2 |
| Суудал | шороо | төмөр | огторгуй | ус | уул | мод | хий |
| Мэнгэ | 8 цагаан | 7 улаан | 6 цагаан | 5 шар | 4 ногоон | 3 хөх | 2 хар |
| Барилдлага | идэр | арвидах | рашаан | үл зохилдох | үл тохирох | түлэх | арвидах |
| Шүтэн барилдлага | Тийн мэдэх | Нэр өнгө | Төрөн түгэх | Хүрэлцэх | Сэрэх | Хурьцах | Авах |
| Нар ург/шин | 08:23/17:49 | 08:21/17:51 | 08:20/17:52 | 08:19/17:54 | 08:17/17:56 | 08:16/17:57 | 08:15/17:59 |
| Сар ург/шин | 09:28/20:28 | 09:58/21:38 | 10:27/22:49 | 10:56/- | 11:27/00:01 | 12:00/01:13 | 12:38/02:25 |

★ Балжинням ° 2017 оны хаврын үүр.




## НААДМЫН КОМИСС

М.Энхболд 1999-2005, 2008-2012 онд Үндэсний их баяр наадмын зохион байгуулах хорооны даргаар 11 жил ажилласан. Энэ хугацаанд хурдан морины уралдаан нь Яармагийн дэнжид болдог байсныг болиулж, Монгол даншиг наадам болдог байсан түүхт Хүй мандлын дэнжид шилжүүлсэн. Түүнчлэн авто замыг өргөтгөн сайжруулах, шинээр зам, талбай засах, хурдан морины гарааны шинэ төхөөрөмж нэвтрүүлэх, уралдааны морьд, унаач хүүхдүүдийг даатгалд хамруулах, хамгаалалтын хувцас хэрэгслээр хангуулах, наадамчин олны тав тухыг хангах, наадамд амжилт үзүүлсэн бөхчүүд, харваачид, уяачид, унаач хүүхдүүдийн бай шагналыг тэдний хөдөлмөр зүтгэлтэй уялдуулан нэмэгдүүлэх, цолны шинэчлэл хийх зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.

## СОЦИНТЕРН

СоцИнтерн бол дэлхийн социал демократ, социалист, хөдөлмөрийн намуудаас бүрдсэн дэлхийн улс төрийн хамгийн том нэгдэл юм. Уг холбоо нь ардчилсан социалист үзэл баримтлалыг төлөвшүүлэхийг эрмэлздэг. Тус холбоо одоогоор 100 гаруй орны 160 гаруй намын гишүүнчлэлтэй.

Монгол Ардын нам /тухайн үед МАХН/ 1999 онд уг байгууллагад ажиглагч гишүүнээр элсч, 2003 онд бүрэн эрхт гишүүнээр сонгогдсон байдаг.

Дэлхийд нөлөө бүхий СоцИнтерний холбоод гишүүнчлэлтэй Монгол Ардын намын даргаар М.Энхболд хоёр дахь удаагаа сонгогдон ажиллаж байна.

СоцИнтернд гишүүнчлэлтэй намуудын түүхэнд хоёр удаа намын даргаар сонгогдсон арваад хүн байдгийн нэг нь М.Энхболд юм. Харин тус холбоонд бүртгэлтэй намуудаас завсарлаад буцаж намын даргаар ирсэн хоёр хүн байдгийн нэг нь М.Энхболд, нөгөө нь хойд хөрш ОХУ-ын Шударга Орос намын тэргүүн, нөлөө бүхий улстөрч Сергей Миронов юм.

Өдгөө дэлхийн улс төрд амжилттай яваа нөлөө бүхий улстөрчид ч уг холбоонд гишүүнчлэлтэй намын гишүүд байдаг. Тухайлбал, дэлхийд нөлөө бүхий 20 улсын нэг, Европын холбооны тэргүүлэгч орнуудын нэг Герман улсын Социал демократ нам гишүүн Ангела Меркель гурван удаа Ерөнхий сайдаар томилогдсон байдаг. Түүнчлэн ардчиллын төлөө тууштай тэмцэгч, Мьянмарын Ардчиллын Төлөө Үндэсний Лигийн ерөнхий нарийн бичгийн дарга, улстөрч Ан Сан Су Чи уг холбооны хүндэт ерөнхийлөгчөөр ажилладаг юм.

**Өвлийн адаг цагаагчин үхэр (их) сар, 6 цагаан мэнгэ, уул суудалтай** **2017 оны II сар**

| Билгийн өдөр, гараг | 10☯ | 11 | 12 | 13 ✵ | 15 | 16 ☾ | 17 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | хөх хулгана | хөхөгчин үхэр | улаан бар | улаагчин туулай | шар луу | шарагчин могой | цагаан морь |
| Дүвзий од | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| Жэдзий од | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| Суудал | гал | шороо | төмөр | огторгуй | ус | уул | мод |
| Мэнгэ | 1 цагаан | 9 улаан | 8 цагаан | 7 улаан | 6 цагаан | 5 шар | 4 ногоон |
| Барилдлага | үл зохилдох | үхэх | үл зохилдох | хүчин төгсөх | идэр | түлэх | Арвидах |
| Шүтэн барилдлага | Сансар | Төрөх | Өтлөх үхэх | Тийн мэдэх | Нэр өнгө | Мунхаг | Өтлөх үхэх |
| Нарург/шин | 08:13/18:00 | 08:12/18:02 | 08:10/18:04 | 08:09/18:05 | 08:07/18:07 | 08:06/18:08 | 08:04/18:10 |
| Сарург/шин | 13:22/03:36 | 14:13/04:43 | 15:12/05:45 | 16:17/06:38 | 17:25/07:24 | 18:34/08:08 | 19:43/08:37 |

✵ Бүтээлийн барилдлага ☯ Дашням ☾ Сар хиртэнэ буянд шамд/37-р хуудсанд дэлгэрэнгүй/.

**Өвлийн адаг цагаагчин үхэр (их) сар, 6 цагаан мэнгэ, уул суудалтай** **2017 оны II сар**

| Билгийн өдөр, гараг | 18 | 19 ☯ | 20 | 21 | 21△ | 22✤ | 23 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | цагаагчин хонь | хар бич | харагчин тахиа | хөх нохой | хөхөгчин гахай | улаан хулгана | улаагчин үхэр |
| Дүвзий од | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 |
| Жэдзий од | 11 | 12 | 13 | 14 | 14 | 15 | 16 |
| Суудал | хий | гал | шороо | төмөр | огторгуй | ус | уул |
| Мэнгэ | 3 хөх | 2 хар | 1 цагаан | 9 улаан | 8 цагаан | 7 улаан | 6 цагаан |
| Барилдлага | үл зохилдох | хүчин төгсөх | үл зохилдох | хотол чуулган | үл тохирох | түлэх | түлэх |
| Шүтэн барилдлага | Төрөх | Сансар | Авах | Хурьцах | Хурьцах | Сэрэх | Хүрэлцэх |
| Нарург/шин | 08:02/18:12 | 08:01/18:13 | 07:59/18:15 | 07:57/18:16 | 07:56/18:18 | 07:54/18:19 | 07:52/18:21 |
| Сарург/шин | 20:51/09:07 | 21:56/09:34 | 22:59/10:01 | -/10:27 | 00:01/10:54 | 01:02/11:23 | 02:00/11:56 |

✤ Хур ус △ Тэрсүүд ☯ Дашням

Улс төр, цаг үе,нийгэм мэдээллийн чөлөөт сэтгүүл
ТОР АНАЛИЗ
Үнэний талд

# НИЙСЛЭЛ ХОТ ТӨВ АЙМГИЙН ДОЛООН ГАЗАРТ НҮҮДЭЛЛЭЖ БАЙЖЭЭ




Сэлбийн голын хөндийд байршихаас өмнө нийслэлийг 28 удаа нүүдэллэж байсан тухай түүхэн баримт байдаг юм байна. Ингэхдээ ихэвчлэн Орхон, Туул, Тамирын голын хөвөөг даган нутагладаг байжээ. Одоогийн Улаанбаатар хот 1706 оноос Их хүрээ болон суурьшиж эхэлжээ. Ийнхүү нийслэл хот 1706-1911 онд одоогийн Улаанбаатар хотын төв хэсэг байгаа Сэлбийн голын хөндийд бууж, тогтвортой суурьшиж эхэлсэн түүхтэй юм байна.

МАН-ын дарга, УИХ-ын дэд дарга М.Энхболд 1999-2005 онд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаар ажиллах хугацаандаа Нийслэлийн нүүдэллэж байсан газруудыг түүхчдээр тогтоолгож, гэрэлт хөшөө байгуулах шийдвэрийг гаргаж байв. Тодруулбал, тэрээр 1999 онд Улаанбаатар хот үүсч байгуулагдсаны 360 жилийн ойд зориулан Өргөө-Улаанбаатар эрдэм шинжилгээ, судалгаа сурталчилгааны аялал зохион байгуулах ажлыг эхлүүлж байжээ. Энэ аялалын хүрээнд нийслэлийн түүх бичигдэж эхэлсэн гэгдэх Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутагт орших Ширээт цагаан нуурын эрэг хөвөө, Их Монгол уулын урд бэлийн ариун дагшин хөрс газарт дурсгалын хөшөө босгох саналыг тухайн үеийн Нийслэлийн Засаг дарга Миеэгомбын Энхболд гаргасан байна. Улаанбаатар хот анх үүсч байгуулагдсаны 360 жилийн ойн хүрээнд 1639 онд байгуулагдсан Өргөө хотоос өнөөгийн Улаанбаатарын нүүдэллэн суурьшиж байсан газруудыг түүхэн баримт түшиглэн олж тогтох “Хүрээ нүүдэл” хөтөлбөрийг 2001-2003 онд хэрэгжүүлсэн байдаг. Энэхүү хөтөлбөрийг газар зүйч, профессор О.Сүхбаатарын удирдаж, үр дүнд Улаанбаатарын хотын нүүдэллэж байсан 20 орчим газрыг тогтоосон. Нийслэл хотын түүхэнд гол үүрэг гүйцэтгэсэн Архангай аймгийн Өгийнуур сумын Улаанхудаг, Төв аймгийн Баян сумын Өгөөмөр, Батсүмбэрийн Бургастайн гол, Хунцал, Үдлэг, Эрдэнэ сумын Тэрэлж, Туулын бэлчир, Сант сумын Орхон Ээвэн голын бэлчир, Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Дааган дэл зэрэг газарт нийслэл хот нүүдэллэж байсныг тогтоосон юм. Эдгээр газарт тухайн үеийн Улаанбаатар хотын захирагч М.Энхболдын шийдвэрээр дурсгалын багана босгож тэмдэгжүүлэн мөнхжүүлсэн юм. Энэ нь нийслэлийн түүхийг улам тодорхой болгож, хойч үеийнхэнд үлдээх, Улаанбаатарын үүсэл, нүүдэллэн суурьшиж байсан газруудаар аялал жуулчлалыг хөгжүүлэх өргөн боломж нээсэн байна. Дашрамд дурдахад, нийслэл хотын нүүдэллэж байсан газрын ихэнх Төв аймгийн газар нутаг байжээ.

**Өвлийн адаг цагаагчин үхэр (их) сар, 6 цагаан мэнгэ, уул суудалтай** **2017 оны II сар**

| Билгийн өдөр, гараг | 24 | 25 | 26 | 27 | 28 | 29 | 30▲ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумъяа | Ангараг | Буд | Бархасвадь | Сугар | Санчир | Адъяа |
| Аргын өдөр, гараг | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 |
| | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням |
| Жил өдөр | шар бар | шарагчин туулай | цагаан луу | цагаагчин могой | хар морь | харагчин хонь | хөх бич |
| Дүвзий од | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 |
| Жэдзий од | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 |
| Суудал | мод | хий | гал | шороо | төмөр | огторгуй | ус |
| Мэнгэ | 5 шар | 4 ногоон | 3 хөх | 2 хар | 1 цагаан | 9 улаан | 8 цагаан |
| Барилдлага | идэр | үхэх | рашаан | үл тохирох | шид | идэр | Түлэх |
| Шүтэн барилдлага | Төрөн түгэх | Нэр өнгө | Тийн мэдэх | Хуран үйлдэх | Төрөх | Сансар | Авах |
| Нар ург/шин | 07:50/18:23 | 07:49/18:24 | 07:47/18:26 | 07:45/18:27 | 07:43/18:29 | 07:41/18:30 | 07:39/18:32 |
| Сар ург/шин | 02:58/12:33 | 03:52/13:15 | 04:43/14:03 | 05:31/14:58 | 06:13/15:58 | 06:52/17:03 | 07:26/18:12 |

▲ Модон хохимой

**ИХ ДОЛООН ГАРИГИЙН ҮР**

**Ням - (наран) гариг нь (галын орон, гал махбодьтой)** ихэс дээдсийн сүлд гариг болно. Энэ гаригт гэр оронд өлзийтэй, юм хийж бүтээхэд сайн. Их хүн тушаал хүлээх зэрэг нэмэхэд сайн, хурим хийх, үр тариа цэцэг жимс тарих, мал адгуус сургах, эм найруулах, эрдэм ном сургах, лам болох, буяны үйл нугуудад сайн гэж үздэг байжээ. Харин орон байшингийн суурь тавих, шинэ гэр барих, хүн мал самнах, ханах, төөнөх, бэр авах өгөх, үхэгсдийн үйл үйлдэх, шинэ дээл эсгэх зэрэгт муу гэж үздэг ажээ.

**Даваа - (сар) гариг нь (усан орон, усан махбодьтой)** бөгөөд эм хүний сүлд гариг болно. Хишиг даллага авах, эм найруулах, лус ба тэнгэр тахих, хөрөнгө эсгэх, архи нэрэх, сүм хийд босгох, бэр авах, хурим хийх, тариа тарих, гэр байшин барих, сан тавих, зам мөр гаргах, хот байгуулахад сайн гэж үздэг ажээ. Харин эхэлж ном сонгох, замд хол явах, шинэ дээл өмсөх, эд юм өгөх, өмнө зүгт явахад зүгээр, бусад зүгт анхааралтай явах ёстой гэнэ.

**Мягмар - (ангараг) гариг нь (галын орон, гал махбодьтой)** Эр цэргийн сүлд гариг болно. Дайнд ялах, дайсан дарах, номхотгох, цэргийн ба догшин үйл хэрэг, худалдаа хийх, балгас эвдэх, шинэ ноён тавих, захиран тушаах ажилд сайн гэж үздэг аж. Энэ гаригт эм найруулах, замд гарах, бэрийн үйл нугуудыг тэвчих,

Э.Хүрэлбаатар:

# МЭРГЭЖИЛТНҮҮДИЙНХЭЭ ҮГИЙГ ИХ СОНСДОГ БАЙЛАА



**Монголын Архитекторуудын эвлэлийн ерөнхийлөгч Э.Хүрэлбаатартай ярилцлаа.**

**-Та Улаанбаатар хотын ерөнхий архитектор байсан хүн. УИХ-ын дэд дарга М.Энхболдыг нийслэлийн Засаг дарга байхад хот байгуулалтын чиглэлээр ямар чухал шийдвэрүүд гарч байсан бэ?**

-Би 1986 оноос Улаанбаатар хотод архитектороор ажилласан. 1991 оноос өөр газарт ажиллаж байгаад 2008 оноос дахиад хотод ажиллаж эхэлсэн. М.Энхболд даргын тухайд Чингэлтэй дүүрэгт ажиллаж байх үеэс нь мэдэх юм. Улаанбаатар хотын 27 дахь дарга болоход тэр үедээ хамгийн залуу дарга гэгдэж байлаа.

Ер нь бол 1990 оноос Монгол Улс зах зээлийн системд шилжиж, улс орны нийгэм эдийн засаг хүнд байсан үе. Орон нутгаас Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн ихэсч хүн амын механик өсөлт огцом бий болж байсан. Хотод олноороо нүүж ирсэн хүмүүс гэр хороололд төлөвлөлтгүй суурьшиж, огцом өсөлтийг хотын инженерийн нэгдсэн хангамж хангаж чадахгүй болсон иим үе. Тэр үед гэр хороололд 300 гаруй мянган хүн ирж суурьшсан байдаг шиг санаж байна. Хүн амын өсөлтийг дагаж сургууль, цэцэрлэг, орон сууц, үйлчилгээний газрууд, дэд бүтцийн хангамж, дулаан цахилгааны эх үүсвэрийг нэмэгдүүлэх шаардлага гарч ирсэн.

1999 оноос хойш Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2020 он хүртэл хийх шаардлага гарсан. Энэ төлөвлөгөөн дээр манай үндэсний мэргэжилтнүүд, архитектор, эдийн засагч, түүхч, хуульч нар баг болж ажилласан. Өмнө нь бол дандаа оросуудтай хамтарч хийдэг байсан. Энэ шинэ ерөнхий төлөвлөгөөг яг М.Энхболд даргын үед хийж 2002 онд Засгийн газрын хуралдаанаар орж баталж байсан юм. Өнөөдрийг хүртэл тэр төлөвлөгөөг хэрэгжүүлж яваа. Дунд нь 2009 онд Засгийн газрын тогтоолоор тодотгол хийсэн. Тэр үед би хотын ерөнхий архитектор байсан учраас тэр бодлогыг баримт бичигт тодотгол хийх, 2030 оны хөгжлийн чиг хандлагыг тогтоох ажлыг надад үүрэг болгосон. Ингээд 2013 онд УИХ-аар хууль болгож батлуулж байсан юм.

**-2020 оны ерөнхий төлөвлөгөө өмнөхүүдээсээ юугаар онцлог болсон бэ?**

---

үхэгсдийн үйл үйлдэхийг хориглоно. Эр хүн хэрэг чирэгдэлд холбогдохоос болгоомжилж явах ёстой. Хүн мал амгалангүй тул хичээнгүй сэрэмжлэх хэрэгтэй гэжээ.

**Лхагва - (буд) гариг нь (усан махбодьтой)** ялгуугсадын сүлд гариг, эд юм бүтээх, бичиг зурхай зурах, ураг садан болох, худалдаа хийх, сүмийн тахил, тахилга засах, өөрийн амьдралд тустай ажил хийхэд сайн гэж үздэг аж. Хатуу үйл ажил хийх, лам болох, ном сонсох, гадагш өгөх, хөрөнгө эсгэх, үр цацах зэргийг муу гэдэг.

**Пүрэв - (Бархасбадь) гариг нь (хий махбодьтой)** Лам хүний сүлд гариг. Сургуульд орох, бичиг зурхай, эрдэм сурах, ном сонсох, номлох, хэвлэх, замд явах, санваар өгөх, шүтээн босгох, номын хурал байгуулах, эм найруулах, мод тарих, хөрөнгө эсгэх, бэр авах, төрөх, буяны үйлс бүхэнд сайн гэж үздэг ажээ.

**Баасан - (сугар) гариг нь (шороон махбодьтой)** Ноёд хаадын сүлд гариг болно. Лам болох, эм найруулах, хурим хийх, замд гарах, эрдэм сурах, шинэ хувцас өмсөх, бэр авах, бэрийн үйл бүхэнд өлзийтэй сайн. Үхэгсдийн явдалд сайн, ном сонсоход дунд, эд хөрөнгө зээлдүүлэх, нэхэх, нүүдэл хийх зэрэгт муу гэж үздэг.

**Бямба - (санчир) гариг нь (шороон махбодьтой)** Нялхсын сүлд гариг. Насан буян бүтээх, эд мал авах, худаг гаргах, тариа тарих, мод суулгах, хот байшин барихад сайн ажээ. Бусад үйлийг тэвч. Бэр, хүргэн авч болохгүй.

**Онцгойлон үзэх нь:**

**Ням гаригт:** Тэнгэрийн үйл дэлгэрдэг ч шидийг бүү хий.
**Даваа гаригт:** Лусын үйл дэлгэрдэг ч балин бүү гарга
**Мягмар гаригт:** Түшмэл, хутганы ир дэлгэрдэг ч хутга бүү хурцал.
**Лхагва гаригт:** Үр таслах дэлгэрдэг ч үхэгсдийг бүү тавь.
**Пүрэв гаригт:** Модон гариг дэлгэрдэг ч сор бүү гарга.
**Баасан гаригт:** Мал адгуус дэлгэрдэг ч мал бүү гарга.
**Бямба гаригт:** Газрын гариг дэлгэрдэг ч эд бүү гарга.

**АРВАН ХОЁР ӨДРИЙН ҮР**

**1. Бар өдөр:** Хот тосгоны суурь тавих, бурхан шүтээн, орон гэрийг аравнайлах, бэр буулгах, хувцас эсгэх, тооцоо хийх, мэргэ төлөг тавих, цэрэг хөдөлгөх зэрэгт сайн.

**Муу нь:** Эм найруулах, төрөл садан бололцох, ном эхлэн заалгахад харш.

**2. Туулай өдөр:** Ном заалгах, бурханд залбирах, ихэс дээдэст бараалхах, үхэр хонь зэрэг малтай холбогдох үйл бүхэнд сайн.

**Муу нь:** Хот суурин, байшин барилга эхлэн барих, төрөл садан болох, газар

-Өнөөдрийн Улаанбаатар хотыг бий болгох үндэс суурийг тэр ерөнхий төлөвлөгөөгөөр тавьсан гэж мэргэжлийн хүний хувьд хэлнэ. Яагаад гэвэл, Улаанбаатар хотыг дөрвөн бүсэд хуваaж байгаад гэр хорооллыг амины орон сууц болгоно, инженерийн иж бүрэн хангамжтай хөгжүүлнэ гэж зорилт дэвшүүлсэн. Улаанбаатар хотын инженерийн хангамжийг түшиглэж гэр хорооллын наад захыг орон сууц, дунд хэсгийг амины орон сууц, цаад зах нь эдэлбэр газартай бие даасан инженерийн шугам сүлжээтэй хороолол болгоно гэсэн ерөнхий төлөвлөгөө хийсэн юм. Нөгөөтэйгүүр М.Энхболд гишүүнийг хотын дарга байх үед Газрын тухай хууль дөнгөж батлагдсан, мөн Иргэнд газар өмчлүүлэх тухай хууль дөнгөж хэрэгжиж эхэлсэн цаг л даа. Тэр үед газрын харилцаа Монголд төдийлөн хөгжөөгүй байсан. Иргэд өмчтэй, машинтай болсон, үүнийг дагаад граж хэрэгтэй болсон. Иргэд байр орон сууцныхаа дэргэд тоосгон болон бетонон граж барьж эхэлсэн. Өмч хувьчлал эрчимтэй явагдаж барилга байгууламж хувь хүнд очсон, хувийн өмчтэй болсон, хүн өмчөө тордож, өргөтгөх, томруулах хэрэгцээ гарсан, барилга байгууламж нэмж ихээр барьж эхэлсэн. Энэ олон давхацсан шинэ харилцааны дунд хотын удирдлагууд хот байгуулалтын ажлыг замбараагүй болгохгүйн тулд чадах чинээгээрээ хязгаарлан барьж зохицуулсан байдаг.

**-Барилгын салбар ид сэргэж байсан үед М.Энхболд хотын даргаар ажиллаж таарсан. Тэр үед хот байгуулалтыг цэгцтэй хөгжүүлэхэд хотын даргын санаачилга чухал байсан уу?**

-1990-2000 он бол барилгын салбар зогсонги байсан үе. Хөрөнгө санхүүжилт, боловсон хүчин байхгүй, бүх юм хувьд шилжчихсэн, улсын барилга тресстүүд байхгүй болсон үе. Миний мэдэхийн 2000 оноос хойш барилгын салбар сэргэж эхэлсэн. Тэр үеийн хотын дарга М.Энхболд 2002 оныг “Хот тохижилтын жил”, 2003 оныг “Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын жил”, 2005 оныг “Нийслэлийн хөгжилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх жил” гэж зарлан өргөн цар хүрээтэй ажилласан байдаг. Манай улсад 2003 онд 42.5 тэрбум төгрөгийн 1478 барилга объект ашиглалтанд орж байсан бол 2006 оны байдлаар 141,1 тэрбум төгрөгийн 4579 барилга объект ашиглалтад орсон статистик байдаг. Улсын нийт барилга угсралтын ажлын 70 гаруй хувь нь нийслэлд ногдож байсан юм. Эргээд санахад, Улаанбаатар хотод 1998-2001 онд 2929, 2002-2005 онд 11562 өрх шинэ орон сууцанд орсон тоо баримт байдаг юм. Энэ үе бол хот байгуулалт зөв зохистой хөгжиж, мэргэжлийн хүмүүсийн үг хүчтэй сонсогддог байсан цаг үе гэж би боддог. 1990-2000 он хүртэл зогссон байсан барилгын салбар 2000 оноос хотын бодлоготой уялдаад сэргэсэн, ажлын байр нэмэгдэж, хотын иргэдийн амьжиргааны төвшин дээшилсэн байдаг. Техник технологийн хөгжлийг дагаж 12-оос дээш давхар барилгууд, одоогийн Централ тауэр зэрэг хотын өнгө үзэмжийг нэмсэн барилгууд баригдсан. Энэ бүхнийг шинээр хийж гүйцэтгэхэд бэрхшээл, алдаа оноо гарсан л байх. Хот маань өдрөөс өдөрт хөгжиж, сая гаруй хүн амтай Монгол Улсын нийслэл, дэлхийн томоохон хотын нэг болж байна. Үүний эхлэл суурийг 2000 оноос тавьж чадсаны, хотын удирдлагууд зөв бодлогоор дэмжиж байсны үр дүн амьдрал дээр гарч байгаа.

**-Тэр үед М.Энхболд гишүүн газар болон барилгын асуудал дээр мэргэжилтнүүдийнхээ үгийг хэр сонсч, хүлээн байсан юм бол?**

-Би тухайн үед хотод ажиллаж байсан, мэргэжлийн хүний хувьд гаднаас нь анхааралтай хардаг байсан. М.Энхболд даргаас өмнө Ж.Наранцацралт агсан байхдаа газрын харилцааг эхлүүлж, Газрын албадыг байгуулж мэргэжлийн байгууллагатай болсон байсан. Энэ үед хотын дарга гэхээсээ илүү мэргэжлийн байгууллагууд асуудлыг шийдэж тэрийг нь хотын дарга хянаж, баталгаажуулдаг хууль эрх зүйн орчин бий болсон юм. Энэ уламжлал, залгамж чанарыг М.Энхболд дарга хадгалж ажилладаг байсан. Одоогийн Засаг дарга нар ч тийм байгаа байх. Жишээлбэл, өнөөдрийн төвшинд гэвэл Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газарт судлагдаж байгаа, Нийслэлийн өмчийн харилцааны газарт судлагдаж, хянагдаад ирснийг Засаг дарга л батламжилдаг. Тэрнээс биш Улаанбаатар хотын газрын асуудлыг хотын дарга найз нөхөдтэйгөө ярьж сууж байгаад “Тэр газрыг чамд шийдээд өгье” гэдэг асуудал байхгүй, байх ч боломжгүй. Үе үеийн хотын дарга нар хуулийн хүрээнд энэ байдлаараа ажиллаж байсан. Мэргэжлийн хүмүүсийн хурлаар орж, хянагдсан шийдвэрийг баталгаажуулдаг гэж би ойлгодог. Миний үед ч тийм байсан. Миний мэдэхээр М.Энхболд дарга хотыг удирдаж байхад нийслэлийн төсөв өргүй ажиллаж, жилд 5120 айлын орон сууц ашиглалтад орж, 1000 оюутны байр барьж, 6 цэцэрлэгт хүрээлэн байгуулж ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. Мөн Иргэнд газрыг өмчлүүлэх тухай хуулийн хүрээнд 32,3 мянган өрх газраа өмчлөн авсан, 10 гаруй мянган өрх шинээр цахилгаанаар хангагдсан байдаг. Нийслэл хотын өнгө төрх сэргэж, Сүхбаатарын талбайн шинэчлэлт, зам талбай, авто замын борооны ус зайлуулах шугам, гэрэлтүүлэг тохижилтын ажлыг эрчимтэй хийж байсан. Нийслэлийн ундны усны эх үүсвэр Туул, Улиастай, Гачуурт голын ус хураах талбайг хамарсан 11,6 мянган га газрыг нийслэлийн тусгай хамгаалалтад оруулсан байдаг. Энэ нь өнөөдрийн Улаанбаатар хотын оршин тогтнох нөхцөлийг хангаж өгсөн гэж үздэг. Өөрөөр хэлбэл, хот инженерийн шийдэлтэй хотжиж чадсан.

Түрүүч нь 69-р нүүрт

## ТӨВ АЙМАГТ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2015 ОНД САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

/сая төгрөг/

| Дугаар | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН НЭР | Хугацаа | | Төсөвт өртөг | 2015 онд санхүүжих дүн |
|---|---|---|---|---|---|
| | | Эхлэх | Дуусах | | |
| 1 | Эрдэнэ сумын 320 хүүхдийн сургуулийн барилга | 2012 | 2016 | 2668.7 | 531.4 |
| 2 | Эрдэнэсант сумын сургуулийн дотуур байрны барилга | 2012 | 2015 | 1300.0 | 131.4 |
| 3 | Батсүмбэр сумын сургуулийн 120 хүүхдийн дотуур байрны барилга | 2013 | 2016 | 1200.0 | 350.0 |
| 4 | Аймгийн хөгжимт драмын театрын барилга, 800 хүний суудалтай (Зуунмод сум) | 2014 | 2016 | 9500.0 | 1650.0 |
| 5 | Зуунмод сум, Баянхошуу багийн цэцэрлэгийн барилга | 2014 | 2015 | 919.5 | 619.5 |
| 6 | Борнуур, Жаргалант, Партизан, Батсүмбэр чиглэлийн 78.8 км хатуу хучилттай авто зам | 2010 | 2016 | 14772.1 | 1269.6 |
| 7 | Зуунмод сумын 1.5 км авто замын шинэчлэлийн ажил (Баянхошуу баг) | 2013 | 2015 | 311.3 | 244.2 |
| 8 | Аврах, гал унтраах ангийн барилга (Зуунмод сум) | 2013 | 2015 | 1600.0 | 322.0 |

**2015 онд Төв аймагт улсын төсвөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгт 9.8 тэрбум төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд 4.6 тэрбум төгрөг хуваарилагдсан.**





# Тусч Мессеж

Таны мэдээ мэдээллийн туслах . . .

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ

Эрхэм хэрэглэгч та өдөр тутмын хэрэгцээт мэдээ, мэдээллийг Жи-Мобайлын сүлжээ орсон бүх газарт гар утсаа ашиглан цаг хугацаа, орон зайг үл хамааран мессеж хэлбэрээр авах боломжтой. Нэг удаа мэдээлэл авах бол сонгосон үйлчилгээнийхээ харгалзах кодыг 303, сарын турш өдөр бүр тогтмол мэдээ авах бол 302 тусгай дугаарт мессеж илгээнэ. Та өөрийнхөө хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өдөр тутмын мэдээ мэдээллийг гар утсандаа хүлээн авах үйлчилгээ юм. Энэхүү үйлчилгээг ашиглахыг хүсвэл хэрэглэгч та:

- **Дорнын зурхай:** /Монголчууд эрт дээр үеэс амьдрал ахуйдаа ашиглаж ирсэн өдөр бүрийн зурхайн хэмнэлийг 3 хоногийн өмнөөс мессежээр аваарай. Жич: Зурхайг Монголын Үндэсний ШУА-ын академич, шинжлэх ухааны доктор профессор Л.Тэрбиш боловсруулав/
- **Өрнийн зурхай:** /Нар, сар, од, эрхэс 12 ордонд ээлжлэн байршихдаа амьдрал ахуйд тань хэрхэн нөлөөлөхийг 3 хоногийн өмнөөс урьдчилан хараарай/
- **Үзвэр үйлчилгээний хуваарь:** /Амралт чөлөөт цагаа төлөвлөхөд тань туслах зорилгоор Улаанбаатар хотын кино театрууд, үзвэр үйлчилгээний газруудын хуваарийг 2 хоногийн өмнөөс урьдчилан танилцуулна/
- **Үс засуулах өдрийн зурлага:** /Тухайн өдөр үс засуулахад тохиромжтой эсэхийг Монгол зурхайд буусан 3 өдрийн зурлагаар танд мэдээлнэ/
- **Түүхий эдийн ханш:** /Түүхий эд болон өргөн хэрэглээний зарим хүнсний бүтээгдэхүүн, үнэ ханшийн мэдээг танд мэдээлнэ/
- **Валютын ханш:** /Тухайн өдрийн Монголбанк, арилжааны банкуудын валютын албан ёсны ханшийн мэдээг танд мэдээлнэ/
- **Цаг агаарын мэдээ:** /Үс цаг уурын хүрээлэнгээс гаргадаг цаг агаарын мэдээг 3 хоногийн өмнөөс танд мэдэгдэнэ/ зэрэг таны өдөр тутмын амьдралд зайлшгүй хэрэгтэй мэдээллийг маш энгийн байдлаар хүлээн авах боломжтой.

## АШИГЛАХ ЗААВАР:

| | | | |
|---|---|---|---|
| Дорнын зурхай | dorno | 303 | sent |
| Өрнийн зурхай | urnu mm.dd | 303 | sent |
| Үзвэр үйлчилгээний хуваарь | Uzver | 303 | sent |
| Үс засуулах өдрийн зурлага | Us | 303 | sent |
| Түүхий эдийн ханш | Tuuxii ed | 303 | sent |
| Валютын ханш | USD | 303 | sent |
| Цаг агаарын мэдээ | **UB** | **303** | **sent** |

## ҮНЭ ТАРИФ:

**Дараа төлбөрт**
/НӨАТ ороогүй/

- Нэг удаа мэдээ авахад 40төг
- 30 хоног мэдээ авахад 1000төг

**Урьдчилсан төлбөрт үйлчилгээ**
/НӨАТ ороогүй/

- Нэг удаа мэдээ авахад 40төг
- 30 хоног мэдээ авахад 1000төг

*Санамж: Та сонгосон үйлчилгээнийхээ харгалзах кодыг буруу бичиж үйлчилгээг авах тусгай дугаарт илгээвэл төлбөр гарахыг анхаарна уу. Энэ тохиолдолд таны утсанд алдааны хариу мессеж ирнэ.*

хагалах, суваг шуудуу малтах, хурим хийх, цэрэг хөдөлгөх, тариа ногооны үр суулгах, нүүдэл хийх зэрэгт тохиромжгүй.

**3. Луу өдөр:** Ном айлтгаж, заалгах, дээдэст бараалхах, буян үйл хийх, зэтгэрийг номхотгох, шүтээн босгох, эм найруулах, тооцоо хийх, мэргэ төлөг тавих зэрэгт сайн.

**Муу нь:** Онгоц, сал, модон тээрэм урлах, гүүр барих, ханиур, төөнүүр хийлгэх, газар малтах зэрэгт харш.

**4. Могой өдөр:** Мал гадагш гаргах, газар лусын зан үйл, тахил хийх, нүүдэл хийх, цэрэг хөдөлгөх, зээл авахад сайн.

**Муу нь:** Мод таслах, эм найруулах, үхэгсдийн үйл, усыг хааж бөглөх, бэр өгөх, худалдаа хийх, заргалдах, замд явах, нүүдэл суудал хийх зэрэгт зохимжгүй.

**5. Морь өдөр:** Нууц зөвлөгөөн хийх, бурханд залбирах, нөхрийг эрэх, (нөхөртэй болох), хаад ноёд, ихэс дээдэст тангараг, амлалт гаргах зэрэгт сайн.

**Муу нь:** Байшин сууц тохижуулах, морь худалдах зэрэгт муу.

**6. Хонь өдөр:** Бурханд залбирах, хониноос ашиг шим авах, хот тосгон барьж эхлэх, мал гадагш өгөх, ажилчин авах, хурим найр хийх үйлд өерэг сайн.

**Муу нь:** Хануур, төөнүүр хийлгэх, эм найруулах, анагаах үйл хийх, цэрэг хөдөлгөх зэрэгт харш.

**7. Бич өдөр:** Бэр авах, мод суулгах, цэцэрлэг байгуулах, чимэг зүүх, бүжиг наадам хийх, туг дарцаг хийсгэх зэрэгт сайн.

**Муу нь:** Шинэ хувцас өмсөх, эсгэх, чимэг оёх, худалдаа хийх зэрэгт харш муу.

**8. Тахиа өдөр:** Мэргэ төлөг тавих, эм найруулахад сайн.

**Муу нь:** Мал агтлах, нууц зөвлөгөөн хийх, хурим найр хийх зэрэгт муу.

**9. Нохой өдөр:** Хөлсний ажилчин авах, урлах үйлд суралцах, чуулган хийх, ном заалгах, бурханд залбирах, ан гөрөө хийх үйлд сайн.

**Муу нь:** Бэрд холбогдох үйл, ашиг тустай үйл, нүүдэл хийх, хэрүүл зэрэгт муу.

**10. Гахай өдөр:** Номын хурим, лам хуварга болох, ном заалгах, гөлөг тэжээхэд сайн.

**Муу нь:** Үхэгсдийг оршуулах, мод таслах, худаг шуудуу малтах зэрэгт муу.

**11. Хулгана өдөр:** Шинэ барилгыг ашиглалтанд оруулах, худалдаа наймаа хийх, гэрлэх, тус хэрэгтэй үйлийг бүтээхэд сайн.

**Муу нь:** Төлөг тавих, морь уралдуулах, нохой тэжээх, хүүхэд үрчлэн авахад харш.

**12. Үхэр өдөр:** Мал зарах, худалдаа хийх, хот суурин, байшин барилгын суурь тавих зэрэг үйлд сайн.

**Муу нь:** Урлан бүтээх, дархлах, эрдэм ухаанд суралцах, цэрэг хөдөлгөхөд сөрөг муу нөлөөтэй.




# ТӨВ АЙМГИЙН БҮХ СУМАНД "ШАТРЫН ТАНХИМ" БАЙГУУЛНА

Монголын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Ж.Самбуугийн мэндэлсний 120 жилийн ой 2015 онд тохиож байна. Ойн хүрээнд УИХ-ын дэд дарга, МАН-ын дарга Миеэгомбын Энхболдын санаачилга, дэмжлэгээр "Эх нутгийн иргэд" ТББ-аас "Ж.Самбуу" сан, "Монгол туургатны шатрын холбоо"-той хамтран "Шатар ухаан-2015" тэмцээнийг зохион байгууллаа.

Найман насны ангиллаар Улаанбаатар хотноо өнгөрсөн зургадугаар сарын 6-8-ны өдрүүдэд болсон тус тэмцээний үеэр УИХ-ын дэд дарга, МАН-ын дарга М.Энхболд Төв аймгийн 27 сумын сургуульд "Шатрын танхим" байгуулахаар болсноо мэдэгдэв. Мөн тэрээр энэ санаачилгынхаа эхлэл болгож Батсүмбэр сумад "Шатрын танхим"-ын иж бүрэн хэрэгсэл, сургалтын ном гарын авлага бэлэглэсэн юм. Төв аймгийн үлдсэн бүх сумын сургуулийг 2015 ондоо багтааж Шатрын танхимтай болгох юм байна.

Дээрхи 12 өдрийн бар, бич өдрүүдэд худаг малтахыг, тахиа, туулай өдрүүдэд үзмэр үзэх, хурим хийхийг, нохой, луу өдрүүдэд мордохыг, гахай, могой өдрүүдэд мод таслах, газар малтахыг, хулгана морь өдрүүдэд морь уралдуулах, улаан идээ авахыг, үхэр, хонь өдерт өндөр суудалд сууж эхлэх, туг дарцаг хийсгэхийг цээрлэвэл зохино.

### ЗАРИМ ӨДРИЙН ҮРИЙН ТУХАЙ

**1. Балжинням, Дашнямтай** *өдөр гэдэг нь өлзий хутгийн наран ба цогийн наран ургахуй хэмээх хоёр өдөр бөгөөд ном уншуулах, буян үйлдэх, хишиг даллага авах, гэр байшин барих, бэр буулгах, хуварга тойн болох, эд мал авах зэрэгт ивээлтэй. Алив нэгэн ажил үйлс эхлэн, үйлдэхэд, тэр хүний санасан зүйлс бүтээд үр ач нар дэлгэрэн буян хишиг нэмэх нэн сайн болно.*

**2.Хутганы ир хэмээх өдөр** – *Зүү тавих, хануур, төөнүүр, мэс засал хийх зэрэг аливаа хутга мэсийн ажлыг цээрлэдэг ажээ.*

**3.Модон хохимой өдөр** – *Ураг садан бололцох, бэр авах, өгөх, нөгчигсдийн үйл, буян хишиг дуудах, аян замд гарах, бурхан тэнгэр тахих, хуварга тойн болох зэрэг буяны үйл, мөн нүүж нутаг сэлгэх зэргийг цээрлэн тэвчдэг ажээ.*

### ТЭРСҮҮ ӨДӨР

Тэрсүү өдөр үйл бүхнийг хоригловол тус ихтэй гэжээ. Монголын Цагаан сарын шинийн нэгнээс эхлэн хаврын тэргүүн буюу бар сар эхлэх бөгөөд түүнээс дэс дараалан 12 сард харгалзсан тодорхой өдрүүдийг "тэрсүү өдөр" гэж нэрлэнэ. Энэ өдөр аливаа үйл үйлдвэл үр нь муу гэж үздэг. Шинэ гэр баривал салж хагацах аюултай. Бэр буулгавал эхнэр нөхрөөс салах гэмтэй. Сүм дуган баривал лам хуварга үл тогтох, замд гарвал хулгай дээрэмчинтэй учирах, үр тариа таривал хатах, нэр алдар авбал доройтох, хишиг даллага авах сүлд дуудбал үл илрэх.

### САРЫН ОНЦГОЙ ӨДРҮҮДИЙГ ОЛОХ НЬ

| Сарын нэр | Бар | Туулай | Луу | Могой | Морь | Хонь | Бич | Тахиа | Нохой | Гахай | Хулгана | Үхэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Балжинням | 2 | 8 | 10 | 3 | 3 | 29 | 3 | 17 | 3 | 16 | 1 | 9 |
| Дашням | 2,6 | 3,8 | 1,10 | 3,9 | 3,4 | 5,19 | 3,18 | 17,24 | 3 | 1,11 | 1,27 | 10,19 |
| Модон хохимой | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 1,16 | 29 |
| Тэрсүүд | 13 | 11 | 9 | 7 | 5 | 3 | 1 | 19 | 17 | 25 | 23 | 21 |

# ХҮҮХДИЙН МӨНГӨ АВАХ ЖУРМЫГ ИНГЭЖ ӨӨРЧИЛЖЭЭ



Хүүхдийн мөнгөнд зориулан жил бүрийн улсын төсөвт 200 тэрбум гаруй төгрөг зарцуулдаг байсан. Гэвч эдийн засгийн байдал хүнд байгаатай холбогдуулан ирэх оны төсвийг батлахдаа энэ мөнгийг 144 тэрбум болгон бууруулсан. Өөрөөр хэлбэл, одоо энэ мөнгийг авч байгаа хүүхдүүдийн тал шахуу нь ирэх оноос авахгүй болно гэсэн үг юм. Өнгөрсөн жил Засгийн газар 2015 оны төсвийг өргөн барихдаа хүүхдийн мөнгийг хасахаар оруулж ирсэн ч УИХ дээр дэмжигдээгүй учраас хуучин хэвээр нь баталсан. Гэтэл эдийн засаг хүнд, хэмнэлт хийх зайлшгүй шаардлагатай гэж үзэн ирэх оны төсөвт хүүхдийн мөнгийг 144 тэрбумаар баталсан. Уг нь Засгийн газрын 2012-2016 оны мөрийн хөтөлбөрт 0-18 насны хүүхдэд сар бүр 20 мянган төгрөг олгож байхаар болсон ч эдийн засгийн байдлаас шалтгаалан ирэх онд нийт хүүхдийн 40 орчим хувь нь хүүхдийн мөнгөнөөсөө хасагдаж байгаа юм.

Хоёр жилийн өмнө Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын яамнаас айл өрхийн амьдралын төвшинг тодорхойлсон судалгаа хийж, айл өрхүүдийг амьдралын төвшингөөр нь 20 ангилсан. Энэ ангиллын 1-17-д багтаж байгаа айл өрхийн буюу 823 мянга орчим хүүхдэд ирэх оноос хүүхдийн мөнгө олгох бөгөөд 18-20-д орж байгаа айлуудад хүүхдийн мөнгө өгөхгүй.

1-17 дугаар бүлэгт нийт хүүхдүүдийн 60 гаруй хувь нь багтаж байгаа юм байна. Тэгэхээр хүүхдүүдийн 40 орчим хувь нь хүүхдийн мөнгө авахгүй гэсэн үг. Гэхдээ амьжиргааны төвшин нь 18-20-д багтаж байгаа ч хүүхдийн мөнгө авах хүсэлтээ өргөдлөөр өгвөл мөнгөө үргэлжлүүлэн авах боломжтой юм байна.

ХАХНХ-ын сайд С.Эрдэнэ “2014 онд л гэхэд хүүхдийн мөнгөө аваагүйгээс төрийн санд таван тэрбум төгрөг хуримтлагдсан. Амьдралын боломжтой, төрөөс мөнгө авах шаардлагагүй айлууд бий. Тэд хүүхдийн мөнгө огт авдаггүйгээс үүдэн төрийн санд төдий хэмжээний мөнгө үлддэг. Тиймээс ирэх оны төсөвт угаасаа хүүхдийн мөнгө авдаггүй хэсгийнхнийг л хасч баталсан. Ер нь хавтгайрсан халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх нь үндсэн зорилго. Улстөржсөн нийгмийн халамжаас татгалзах хэрэгтэй. Үүнд хэн нэгэн иргэний хүүхдийг ямар нэгэн байдлаар алагчилсан зүйл байхгүй. Хэрэв тухайн иргэн хүүхдийн мөнгөө авъя гэвэл хүсэлт гаргах эрх нь нээлттэй” гэсэн юм.

ХАХНХЯ-наас хоёр жилийн өмнө айл өрхийн амьжиргааны төвшинг судалж өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн бөгөөд тус судалгааг харгалзан хүүхдийн мөнгийг олгох юм. Харин тус мэдээллийн санд бүртгэлжүүлээгүй бол хүүхдийн мөнгөө авах боломжгүй болох учраас харьяа аймаг, сумынхаа халамж үйлчилгээнд хандаж бүртгэлтэй эсэхээ шалгуулаад хэрвээ бүртгэлгүй бол бүртгүүлэх шаардлагатай юм байна. Харьяа сумынхаа халамжинд үйлчилгээнд бүртгэлтэй, амьжиргааны түвшин нь 1-17-д багтаж байгаа айл өрхийн хүүхдүүд хүүхдийн мөнгөө ирэх жил ч авах юм байна. Дашрамд, 2014 онд хүүхдийн мөнгөнд 239 тэрбум, 2015 онд 246 тэрбум төгрөг төсөвлөн олгосон юм.

### ӨДРИЙН АРВАН УЧИРЛЫН ҮР

“Шид”, “хотол чуулган”, “рашаан”, “хүчин төгсөх”, “арвидах”, “идэр”-ийн учирлыг “зургаан сайн”, “үхэх”, “түлэх”, “үл тохирох”, “үл зохицох”-ыг “өдрийн муу” хэмээдэг.

**1. Шидийн учиралтай өдөр** – Аливаа санасан үйл сэтгэлчилэн бүтмүй. Шүтээн босгох, хот балгад барих, тариа тарих, худалдаа наймаа хийх зэрэг дэлгэрүүлэх үйлд хичээвэл сайн. Бүтээл туурвил үйлдэх зэрэг батжуулах үйлд ч сайн.

**2. Рашааны учиралтай өдөр** – Насны хүчийг арвижуулах, эм найруулах, усан засал, угаал үйлдэх, бэр авах, насны хишиг, насан бүтээлийн зан үйлийг хийлгэх, төрөл садан бололцох, худалдаа наймаа үүсгэх зэрэг дэлгэрүүлэх үйлсэд сайн.

**3. Идрийн учиралтай өдөр** – Сайн үйлс үүсгэх, баясгалангийн хурим үйлдэх, ялангуяа гэр бүл бололцох, газар хагалж тариа тарих, шинээр хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үйлдэх зэрэгт сайн.

**4. Арвидах учиралтай өдөр** – Идээ, хувцас олох, худалдаа наймаа үйлдэх, өглөг өгөх, хөрөнгө талбих, эдийн тэнгэр тахих хийгээд бүтээл үүсгэхэд сайн.

**5. Хотол чуулганы учиралтай өдөр** – Санасан хэрэг бүтнэ. Хэл ам намдаах, арга эвийг олж түргэн бүтээх үйлсэд сайн.

**6. Хүчин төгсөхийн учиралтай өдөр** - Өлзийтэй буян үйл үйлдэх, номын үйл эхлэх, гүйцээх, сүм дуган нээх, амирлангуй, дэлгэрэнгүй эрхшээх үйл бүхэнд сайн.

**7. Түлэхийн учиралтай өдөр** – Элдэв сайн үйлийг эхлэн үүсгэхийг тэвчвэл сайн. Хатуу үйл үүсгэвэл зохилтой.

**8. Үл тохирохын учиралтай өдөр** – Хулгай, дээрэм дарах, дайсныг номхотгох үйлд сайн. Амраг садан бололцох, багш шавь барилдахыг тэвч.

**9. Үхэхийн учиралтай өдөр** – Мал адгуус муулах үйлд сайн.

**10. Үл зохилдохын учиралтай өдөр** – Андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн.

### ХҮН БҮРИЙН СҮЛД, ҮХЛИЙН ГАРИГ, ОДНЫ ХҮСНЭГТ

| Төрсөн жил | Ивээл жил | Харш жил | Сүлд гариг | Амь гариг | Үхэх гариг | Сүлд од | Амь од | Үхэх од |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хулгана | Луу Бич | Морь Туулай | Лхагва | Мягмар | Бямба | 19 | 5 | 22 |
| Үхэр | Могой Тахиа | Хонь Луу | Бямба | Лхагва | Пүрэв | 16 | 13 | 4 |
| Бар | Морь Нохой | Бич Могой | Пүрэв | Бямба | Баасан | 4 | 26 | 1 |

# Н.Жанцанноров: ТӨРИЙН ХҮН ТАЛ РУУ ХАНАТАЙ НЬ М.ЭНХБОЛД ДОО

*Ардын жүжигчин, төрийн хошой шагналт хөгжмийн зохиолч Н.Жанцанноровтой ярилцлаа.*



**-Та МАН-ын дарга М.Энхболдыг хэзээнээс мэдэх вэ?**

-Би М.Энхболдыг хотын захиргаанд хамгийн бага албан тушаалд байхаас нь мэдэх юм. Хотын захиргаанд ажилладаг хүмүүсийг сүүлд УИХ-ын дарга байсан Л.Энэбишээр дамжуулж би мэддэг, гадарладаг байсан юм. Л.Энэбиш бид хоёр нэг талаар найз нөхөд, нөгөө талаар албан тушаал ойролцоо, ажил хэрэг маань уялдаатай явдаг байлаа. Тэгж явахдаа хотын захиргаанд өөрийнхөө чадлаар, ажил хийх чадвараараа шинээр гарч ирж байгаа залуусыг хэрхэн дэмжих талаар бид ярилцдаг, санал солилцдог байлаа. Тэгэхэд Миеэгомбын Энхболдын нэр байнга л гарч ирдэг байсан. Түүнээс хойш маш олон жил хамтарч ажиллаж байна. Манай хүн чинь Ерөнхий сайд, Шадар сайд ч байсан. Тэр үед нь соёлын арга хэмжээнүүдэд бид үргэлж хамтарч ажилладаг байлаа. М.Энхболд ялангуяа наадмын комиссын дарга, орлогч даргын ажлыг

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Туулай | Хонь<br>Гахай | Тахиа<br>Морь | Пүрэв | Бямба | Баасан | 10 | 26 | 17 |
| Луу | Бич<br>Хулгана | Нохой<br>Хонь | Ням | Лхагва | Пүрэв | 2 | 23 | 10 |
| Могой | Тахиа<br>Үхэр | Гахай<br>Бич | Мягмар | Баасан | Лхагва | 12 | 11 | 5 |
| Морь | Нохой<br>Бар | Хулгана<br>Тахиа | Мягмар | Баасан | Лхагва | 16 | 11 | 26 |
| Хонь | Гахай<br>Туулай | Үхэр<br>Нохой | Баасан | Даваа | Пүрэв | 7 | 0 | 26 |
| Бич | Хулгана<br>Луу | Бар<br>Гахай | Баасан | Пүрэв | Мягмар | 7 | 0 | 16 |
